2.3.2. Хямд өртөгтэй, хөнгөвчилсөн хучилттай орон нутгийн авто замын сүлжээг холбогдох олон улсын конвенци болон Үндэсний стандартын шаардлагад нийцсэн замын тэмдэг, тэмдэглэгээ, аюулгүйн тоноглолоор тоноглох;

2.3.2.1. Орон нутгийн авто замын сүлжээний аюулгүй байдлыг хангах шаардлагатай тэмдэг, тэмдэглэгээгээр тоноглох;

2.3.2.2. Орон нутгийн авто замын сүлжээний огцом эргэлт, огцом өгсүүр, уруудах хэсгүүдэд аюулгүйн саадыг шаардлагатай тэмдэг, тэмдэглээний хамтаар барих, тоноглох;

2.3.2.3. Хилийн боомт, аялал жуулчлалын бүс болон үйлдвэрлэлийн бүсэд мэдээллийн самбар, сурталчилгааг байрлуулах;

2.3.3. Хямд өртөгтэй, хөнгөвчилсөн хучилттай авто замын засвар, арчлалтын тогтвортой санхүүжилтийн болон замын ээлжит засварын хөтөлбөрийг боловсруулах;

2.3.3.1. Орон нутгийн авто замын сүлжээний засвар арчлалтын санхүүжилтийн хөтөлбөрийг боловсруулах, батлуулах;

2.3.3.2. Хямд өртөгтэй, хөнгөвчилсөн хучилттай авто замын зураг төсөл ба хучилтын хийцийг зөв сонгох замаар ашиглалтын хугацааг уртасгах, засвар арчлалтын зардлыг бууруулах;

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, удирдлага, зохион байгуулалт

3.1. Хугацаа, үе шат



3.1.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа: 2020-2024 он

3.2. Удирдлага, зохион байгуулалт

3.2.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах байдлаар удирдан зохион байгуулна.

3.2.1.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа 2050” болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн бусад бодлоготой уялдуулан авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн удирдлагаар ханган зохион байгуулна.

3.2.1.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, төсөл боловсруулан ажиллана.

3.2.1.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төрийн байгууллага, иргэд, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын оролцоог хангана.

Дөрөв. Хөтөлбөрийн санхүүжилт

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

- 4.1.1. улсын төсөв болон орон нутгийн төсөв;
- 4.1.2. гадаадын зээл тусламж;
- 4.1.3. гадаад дотоодын хөрөнгө оруулалт;
- 4.1.4. бусад эх үүсвэр.

Тав. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр Монгол Улсын эдийн засаг, нийгэмд болон тээврийн салбарт дараах үр дүн гарна.

Монгол Улсын эдийн засаг, нийгэмд дараах үр дүн гарна:

5.1.1. сум, суурин газрууд хямд өртөгтэй, хөнгөвчилсөн хучилт бүхий авто замуудаар холбогдоно.

5.1.3. сум, суурин газрууд, нь улс болон бүс нутгийн чанартай хатуу хучилттай авто замтай холбогдоно.

5.1.4. орон нутгийн чанартай авто замын сүлжээ өргөжинө.


5.1.5. ачаа болон зорчигч урсгалын хэмжээ нэмэгдэнэ.

5.1.6. дотоод худалдааны эргэлт өсч, ажлын байр нэмэгдэх бөгөөд үүнийг дагаад эдийн засгийн өсөлт бий болж, үндэсний баялаг нэмэгдэж, ажилгүйдэл, ядуурал буурах боломж бүрдэнэ.

5.1.7. авто замын осол, аваар буурна. Ослын улмаас үүдэлтэй хохирлын хэмжээ буурна.

5.1.8. хүн амын төвлөрлийг сааруулна.

5.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ:




№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны суурь түвшин	Зорилтот түвшин (он)	
				2021	2024
1.1	хямд өртөгтэй, хөнгөвчилсөн хучилттай авто зам	км	-	38	524
1.2.	тээврийн хэрэгслээс хүрээлэн буй орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийн хувь	хувь	10	7	5
1.3.	Нийт холбогдох сумдын тоо	Тоо	103	109	155

Зургаа. Хяналт-Шинжилгээ, үнэлгээний төлөвлөлт

6.1.1. Зам, тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Сайдын зөвлөлийн хуралдаанд жил бүр танилцуулна.

6.1.2. Орон нутагт бүх шатны Засаг дарга хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зам, тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад жил бүр тайлагнана.

---oOo---



**“НУТГИЙН ЗАМ ДЭД ХӨТӨЛБӨР”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ,
САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ТӨСӨӨЛӨЛ**

№	Бодлогын зорилго, зорилт	Эхлэх /дуусах огноо	Нийт төсөв /сая.₮/	Санхүүжилт эх үүсвэр				Эх үүсвэр
				2021	2022	2023	2024	
1	Тээврийн эрэлтэд нийцсэн, нийгэм, эдийн засгийн байдалд тохирсон хямд өртөгтэй, хөнгөвчилсөн хучилттай орон нутгийн авто замын сүлжээг өргөтгөх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:							
1.1	Монгол орны хүйтэн, ширүүн байгаль цаг уурын нөхцөлд тохирсон олон улсын замын барилгын технологийн туршлагыг судлах, нэвтрүүлэх;	2021	300.0	-	-	-	-	Улсын төсөв
1.2	Монгол орны нөхцөлд тохирох хямд өртөг бүхий авто замын хучилтыг сонгох, нэвтрүүлэх;	2021	500.0	-	-	-	-	Улсын төсөв
1.3	Авто замын барилгын ажилд аудит хийх, аудитын тайланд үндэслэн авто замын зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, батлуулах;	2021	150.0	-	-	-	-	Улсын төсөв
1.4	Сум, суурин газруудыг хямд өртөгтэй, хөнгөвчилсөн хучилттай авто замаар холбох;	2021-2024	198,654	22,268	39,262	94,053	43,070	Улсын төсөв
1.5	Орон нутгийн авто замын сүлжээг бүсийн төв болон ойролцоох аймгийн төвүүдийг дайрах улсын чанартай авто замтай холбох;	2021-2024	150,517.2	-	-	81,767	68,750.1	Улсын болон орон нутгийн төсөв
2.	Хямд өртөгтэй, хөнгөвчилсөн хучилттай орон нутгийн авто замын сүлжээг холбогдох олон улсын конвенци болон Үндэсний стандартын шаардлагад нийцсэн замын тэмдэг, тэмдэглэгээг, аюулеүйн тоноглолоор тоноглох;							
2.1	Орон нутгийн авто замын сүлжээний аюулгүй байдлыг хангах шаардлагатай тэмдэг, тэмдэглэгээгээр тоноглох;	2021-2024	196.0	49.0	49.0	49.0	49.0	Орон нутгийн төсөв
2.2	Орон нутгийн авто замын сүлжээний огцом эргэлт, огцом өгсүүр, уруудах хэсгүүдэд аюулгүйн саадыг шаардлагатай тэмдэг, тэмдэглээний хамтаар барих, тоноглох;	2021-2024						Улсын болон орон нутгийн төсөв
2.3	Хилийн боомт, аялал жуулчлалын бүс болон	230	32.2	8.05	8.05	8.05	8.05	Улсын төсөв

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖИЛИЙН ҮНДЭС
ЭХ ХҮЕВЬ
Самд Тогдсон нэрлэлийн биетийн
даргачь *Лодов Агва*

үйлдвэрлэлийн бүсэд мэдээллийн самбар, сурталчилгааг байрлуулах;										
3.	Хямд өртөгтэй, хөнгөөчлөгсөн хучилттай авто замын засвар, арчлалтын тогтвортой санхүүжилтийн болон замын ээлжит засварын хөтөлбөрийг боловсруулах;									
3.1	Орон нутгийн авто замын сүлжээний засвар арчлалтын санхүүжилтийн хөтөлбөрийг боловсруулах, батлуулах;	2021-2022	-	-	-	-	-	-	-	Улсын, орон нутгийн төсөв
3.2	Цаашид өртөгтөгх шаардлагатай олон улс, улсын чанартай авто зам дагуу баригдсан хямд өртөгтэй авто замын засварт арчлалт хийх	2021-2024	2,096.6	-	-	924.6	1,702			Улсын, орон нутгийн төсөв
3.3.	Орон нутгийн хямд өртөгтэй авто замын засвар арчлалт	2021-2024	4,682.8	-	349.6	966	3,367.2			Орон нутгийн төсөв
Нийт шаардагдах хөрөнгийн хэмжээ төгрөгөөр /сая.төгрөг/		2021-2024								

105

УСГАА ОУ ИСЭГ
ЗЭМ ТЭВЭРИЙН ХӨТӨЛБӨРИЙН
ЭХ ХУВЬ 9
Сайд Төрийн-мөрийн Ерлийн
Даргын 2020-01-01-ээр тусгач

“ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮЙЛЧИЛГЭЭ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛАХ ДУНД ХУГАЦААНЫ ДЭД ХӨТӨЛБӨР”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа
Нэг. Тээврийн эрэлтэд нийцсэн, нийгэм, эдийн засгийн байдалд тохирсон хямд өртөгтэй, хөнгөвчилсэн хучилттай орон нутгийн авто замын сүлжээг өргөтгөх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.						
1.1	Монгол орны хүйтэн, ширүүн байгаль цаг уурын нөхцөлд тохирсон олон улсын замын барилгын технологийн туршлагыг судлах, нэвтрүүлэх;	Хямд өртөгтэй авто зам барих технологийн судалгаа хийх	Судалгаа хийгдсэн байна.	ЗТХЯ	ЗТХТ ТӨҮГ, судалгааны байгууллага	2021
1.2	Монгол орны нөхцөлд тохирох хямд өртөг бүхий авто замын хучилтыг сонгох, нэвтрүүлэх;	Хямд өртөгтэй авто зам барих технологийн дагуу туршилт хийх	Туршилт хийсэн байна.	ЗТХЯ	ЗТХТ ТӨҮГ, судалгааны байгууллага	2021
1.3	Авто замын барилгын ажилд аудит хийх, аудитын тайланд үндэслэн авто замын зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, батлуулах;	Хямд өртөгтэй авто зам барих технологийн дагуу ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	ТЭЗҮ, зураг төсөл	ЗТХЯ	Зураг төслийн компани	2020-2024
1.4	Сум, суурин газруудыг хямд өртөгтэй, хөнгөвчилсэн хучилттай авто замаар холбох;	Архангай аймгийн Өндөр-Улаан сумыг холбох	8 км	Орон нутгийн ЗД	ЗТХЯ	2021
1.5		Архангай аймгийн Булган сумыг холбох	35 км	Орон нутгийн ЗД	ЗТХЯ	2022-2023
1.6		Баянхонгор аймгийн Баян-Овоо сумыг холбох	24 км	Орон нутгийн ЗД	ЗТХЯ	2023
1.7		Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумыг холбох	29 км	Орон нутгийн ЗД	ЗТХЯ	2022-2023
1.8		Говь-Алтай аймгийн Дэлгэр сумыг холбох	5 км	Орон нутгийн ЗД	ЗТХЯ	2021
1.9		Говьсүмбэр аймгийн Баянтал сумыг холбох	2 км	Орон нутгийн ЗД	ЗТХЯ	2021

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН АГАА
10
ЗХ ХУВЬ
Самд Төрчин-Нарвин Бундмаа
дотор /2023.08.12/

106

1.10		Говьсүмбэр аймгийн Шивээговь сумыг холбох	8 км	Орон нутгийн ЗД	ЗТХЯ	2022
1.11		Дундговь аймгийн Дэрэн сумыг холбох	32 км	Орон нутгийн ЗД	ЗТХЯ	2023
1.12		Завхан аймгийн Идэр сумыг холбох	12 км	Орон нутгийн ЗД	ЗТХЯ	2023
1.13		Завхан аймгийн Түдэвтэй сумыг холбох	9 км	Орон нутгийн ЗД	ЗТХЯ	2021
1.14		Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумыг холбох	16 км	Орон нутгийн ЗД	ЗТХЯ	2022
1.15		Төв аймгийн Заамар сумыг холбох	65 км	Орон нутгийн ЗД	ЗТХЯ	2023-2024
1.16		Төв аймгийн Угтаал сумыг холбох	18 км	Орон нутгийн ЗД	ЗТХЯ	2023
1.17		Төв аймгийн Цээл сумыг холбох	25 км	Орон нутгийн ЗД	ЗТХЯ	2024
1.18		Увс аймгийн Сагил сумыг холбох	11 км	Орон нутгийн ЗД	ЗТХЯ	2022
1.19		Увс аймгийн Түргэн сумыг холбох	5 км	Орон нутгийн ЗД	ЗТХЯ	2021
1.20		Хөвсгөл аймгийн Тариалан сумыг холбох	9 км	Орон нутгийн ЗД	ЗТХЯ	2021
1.21		Ховд аймгийн Цэцэг сумыг холбох	4 км	Орон нутгийн ЗД	ЗТХЯ	2021
1.22		Төв аймгийн Аргалант сумыг холбох	9 км	Орон нутгийн ЗД	ЗТХЯ	2023
1.23		Баян-Өлгий аймгийн Сагсай сумыг холбох	27 км	ЗТХЯ	Орон нутгийн ЗД	2024
1.24	Орон нутгийн авто замын сүлжээг бүсийн төв болон ойролцоох аймгийн төвүүдийг дайрах улсын чанартай авто замтай холбох;	Дундговь аймгийн Гурвансайхан сумыг холбох	71 км	ЗТХЯ	Орон нутгийн ЗД	2023-2024
1.25		Завхан аймгийн Цагаанхайрхан сумыг холбох	44 км	ЗТХЯ	Орон нутгийн ЗД	2023-2024
1.26		Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумыг холбох	26 км	ЗТХЯ	Орон нутгийн ЗД	2023
1.27		Говь-Алтай аймгийн Тайшир сумыг холбох	43 км	ЗТХЯ	Орон нутгийн ЗД	2023
1.28		Олон улс, улсын чанартай авто замын дагууд холбогдох сумдууд	Холбогдсон байна.	ЗТХЯ	СЯ, Орон нутгийн ЗД	2022-2023



107

1.29	хучилттай авто замаар холбох	Холбогдсон байна.	ЗТХЯ	СЯ, Орон нутгийн ЗД	2023-2024
1.30	Баян-Өлгий аймгийн Улаанхус, Цэнгэл сумыг улсын чанартай хатуу хучилттай авто замаар холбох	Холбогдсон байна.	ЗТХЯ	СЯ, Орон нутгийн ЗД	2022-2024
1.31	Булган аймгийн Гурванбулаг, Хишиг-Өндөр, Хангал сумыг улсын чанартай хатуу хучилттай авто замаар холбох	Холбогдсон байна.	ЗТХЯ	СЯ, Орон нутгийн ЗД	2023-2024
1.32	Дархан-Уул аймгийн Шарынгол сумыг улсын чанартай хатуу хучилттай авто замаар холбох	Холбогдсон байна.	ЗТХЯ	СЯ, Орон нутгийн ЗД	2022-2024
1.33	Дорнод аймгийн Чойбалсан сумыг улсын чанартай хатуу хучилттай авто замаар холбох	Холбогдсон байна.	ЗТХЯ	СЯ, Орон нутгийн ЗД	2022-2024
1.34	Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Хужирт сумыг улсын чанартай хатуу хучилттай авто замаар холбох	Холбогдсон байна.	ЗТХЯ	СЯ, Орон нутгийн ЗД	2020-2022
1.35	Өмнөговь аймгийн Цогтцэций сумыг улсын чанартай хатуу хучилттай авто замаар холбох	Холбогдсон байна.	ЗТХЯ	СЯ, Орон нутгийн ЗД	2022-2024
1.36	Сүхбаатар аймгийн Асгат, Эрдэнэцагаан, Баян-Адарга сумыг улсын чанартай хатуу хучилттай авто замаар холбох	Холбогдсон байна.	ЗТХЯ	СЯ, Орон нутгийн ЗД	2021-2023
1.37	Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн, Түшиг, Цагааннуур, Шаамар сумыг улсын чанартай авто замаар холбох	Холбогдсон байна.	ЗТХЯ	СЯ, Орон нутгийн ЗД	2020-2022
1.38	Төв аймгийн Мөнгөнморьт сумыг улсын чанартай авто замаар холбох	Холбогдсон байна.	ЗТХЯ	СЯ, Орон нутгийн ЗД	2022-2023
1.39	Увс аймгийн Өлгий сумыг улсын чанартай авто замаар холбох	Холбогдсон байна.	ЗТХЯ	СЯ, Орон нутгийн ЗД	2023-2024
1.40	Хөвд аймгийн Дөргөн, Хөвд, Чандмань, сумыг улсын чанартай авто замаар холбох	Холбогдсон байна.	ЗТХЯ	СЯ, Орон нутгийн ЗД	2022-2024
	Хэнтий аймгийн Баян-Адарга, Өмнөдэлгэр, Дадал, Норовлин, Батноров сумыг улсын	Холбогдсон байна.	ЗТХЯ	СЯ, Орон нутгийн ЗД	2022-2024

УЛААНБААТАР УРСУЛСЫН
 ДАМ ТЭВЭРИЙН ХЭВЭЛЭЙН ГАЗАР
 ЭХ ХУВЬ
 Саид Төрлин наржин бичгийн
 дарга *Р.Орвог*

109


1.42	чанартай авто замаар холбох Хөвсгөл аймгийн Рашаант сумыг улсын чанартай авто замаар холбох	Холбогдсон байна.	ЗТХЯ	СЯ, Орон нутгийн ЗД	2020-2024
1.2. Хямд өртөгтэй, хөнгөвчилсөн хучилттай орон нутгийн авто замын сүлжээг холбогдох олон улсын конвенци болон Үндэсний стандартын шаардлагад нийцсэн замын тэмдэг, тэмдэглэгээ, аюулгүйн тоноглолоор тоноглох;					
2.1	Орон нутгийн авто замын сүлжээний аюулгүй байдлыг хангах шаардлагатай тэмдэг, тэмдэглэгээгээр тоноглох;	Орон нутгийн чанартай авто замыг тэмдэжүүлэх Олон улс, улсын чанартай замаас салах цэг дээр чиглэл заасан тэмдэг тавих	Орон нутгийн ЗД ЗТХЯ	ЗТХЯ Орон нутгийн ЗД	2021-2024 2021-2024
2.2.	Орон нутгийн авто замын сүлжээний огцом эргэлт, огцом өгсүүр, уруудах хэсгүүдэд аюулгүйн саадыг шаардлагатай тэмдэг, тэмдэглээний хамтаар барих, тоноглох;	Орон нутгийн авто замын сүлжээний огцом эргэлт, огцом өгсүүр, уруудах хэсгүүдэд аюулгүйн саадыг арилгах Аюулгүйн байдлыг хангасан тэмдэг, тэмдэглэгээгээр тоноглох	ЗТХЯ, Орон нутгийн ЗД ЗТХЯ, Орон нутгийн ЗД	ЗТХТ ТӨҮГ, АЗЗА ЗТХТ ТӨҮГ, АЗЗА	2021-2024 2021-2024
1.3. Хямд өртөгтэй, хөнгөвчилсөн хучилттай авто замын засвар, арчлалтын тогтвортой санхүүжилтийн болон замын ээлжит засварын хөтөлбөрийг боловсруулах;					
3.1		Хөтөлбөрийг боловсруулсан байна	ЗТХЯ	Орон нутгийн ЗД	2022
3.2		185 км	ЗТХЯ	АЗЗА ТӨХК	2021-2024
3.3	Орон нутгийн авто замын сүлжээний засвар арчлалтын санхүүжилтийн хөтөлбөрийг боловсруулах, батлуулах;	339 км	Орон нутгийн ЗД	АЗЗА ТӨХК	2021-2024
3.4		-	ЗТХЯ, Орон нутгийн ЗД	ЗТХТ ТӨҮГ	2022-2023

---000---



109

110
ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХАВСРАЛТ № 3



**ОЛОН УЛС, УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭНИЙ
АРЧЛАЛТ, ЗАСВАР, АШИГЛАЛТЫГ САЙЖРУУЛЖ ЧАДАВХЫГ
БЭХЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ ДЭД ХӨТӨЛБӨР**

Улаанбаатар хот
2020 он

Агуулга

1. ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ
2. ХӨТӨЛБӨРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ
3. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО
4. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ
5. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА
6. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ХУГАЦАА,
7. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ
8. ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
9. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
10. ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨ
11. ХАВСРАЛТ

112

**ОЛОН УЛС, УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭНИЙ АРЧЛАЛТ, ЗАСВАР,
АШИГЛАЛТЫГ САЙЖРУУЛЖ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ
ХӨТӨЛБӨР**

НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын нутаг дэвсгэр дэх олон улс, улсын чанартай авто замын сүлжээ 893 км бөгөөд 2020 оны байдлаар 7 320,6 км /49,1%/ нь хатуу хучилттай авто зам байна.

Сүүлийн жилүүдэд олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд хатуу хучилттай замын хэмжээ эрчимтэй нэмэгдэж аймгийн төвүүдийг нийслэлтэй хатуу хучилттай авто замаар холбоод байгаа бөгөөд гадаад худалдааны гол эргэлт хийгддэг хилийн томоохон боомтуудруу хатуу хучилттай авто замаар нэвтрэх боломж бүрдээд байна.

Улсын төсвөөс авто зам барихад зориулж байгаа хөрөнгө жил тутам нэмэгдэж олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын хэмжээ нэмэгдсэн сайн тал байгаа боловч өндөр үнэ өртгөөр баригдсан зам, замын байгууламжийн арчлалт, засвар, ашиглалт төдийлөн сайн байхгүй байгаагаас замын эвдрэл их хэмжээгээр гарч хөдөлгөөн саатан аваар осол гарахад тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа талаар зам хэрэглэгч, олон нийтийн зүгээс их хэмжээгээр шүүмжилж байна.

Хөрөнгө мөнгөний дутагдал, зохион байгуулалтын оновчтой биш байдлаас шалтгаалан өдөр тутам хийгдэж байх замын арчлалт, урсгал засварын ажил бүрэн хэмжээгээр хийгдэхгүй байгаа нь зам, замын байгууламжид их хэмжээний эвдрэл гарах үндэс болж байна. Олон улс, улсын чанартай авто замд нормативоор жилд хийх арчлалт, урсгал засварын ажлын шаардлагатай зардлын дөнгөж 30-40%-ийг олгож байна.


Тэрчлэн авто замд хийгдэх ээлжит болон их засварын ажилд хөрөнгө төлөвлөхгүй байгаагаас олон улс, улсын чанартай хатуу хучилттай замын 46,2% буюу 3384,5 км замын ээлжит засвар хийх хугацаа, 9,2% буюу 675,6 км замын их засвар хийх хугацаа тус тус хэтэрсэн байна. Энэ нь эдгээр замыг цаашид илүү их хөрөнгө хүч гарган засаж хэвийн байдалд нь оруулна гэсэн хэрэг болж байгаа юм.

Иймд авто замын арчлалт, урсгал болон ээлжит, их засварын ажлыг тогтоосон нормативт хугацаанд нь стандартын дагуу хийж байх нь хойшлуулшгүй чухал асуудал болж байна. Авто замын арчлалт, засвар, ашиглалтыг сайжруулах ажлын удирдлага, зохион байгуулалтыг өөрчлөн оновчтой болгох шаардлага зайлшгүй чухал болж байна.

Олон улс, улсын чанартай авто замын арчлалт, засварын ажлыг төрийн өмчийн 20, хувийн өмчийн 12 компани гүйцэтгэж байгаагийн удирдлага, зохион байгуулалт нь ЗТХЯ, ТӨБЗГ, "ЗТХТ" ТӨҮГ гэсэн 3 газарт харьяалагдан үйл ажиллагааны давхардалтай, үүрэг нь тодорхойгүйгээс ажлын төлөвлөлт, үйл ажиллагаанд оролцогчдын хариуцлагын тогтолцоо сул байгаа нь замын арчлалт, засварын ажил хугацаа алдах, чанаргүй хийгдэх, хөрөнгө оруулалтын үр ашиг буурахад хүргэж байна.

Нөгөө талаар зам хариуцагч АЗЗА-ын 32 компанийн чадавхыг сайжруулан мэргэжилтэй боловсон хүчин, тоног төхөөрөмж материаллаг баазын хувьд бэхжүүлэх зорилт тулгарч байна.

Авто замын арчлалт, засварын ажлыг сайжруулахын тулд авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажил болон ашиглалтын эрх зүйн орчин, стандарт норм дүрмийг боловсронгуй болгож өнөөгийн нөхцөл шаардлагад нийцүүлэх нь чухал болж байна. Олон улс, улсын чанартай авто замын тэмдэгжүүлэлт, мэдээллийг тодорхой оновчтой болгож замын зурвас газрын тохижилт, замын дагуух үйлчилгээг бий болгож, тогтмолжуулан сайжруулах шаардлага гарч байна.



Нөгөө талаас жилд авто замын засвар арчлалтын ажилд хуваарилагддаг хөрөнгө оруулалтын хэмжээ бага, тогтвортой биш байгаагаас шалтгаалан ихэнх компаниуд зорилтот түвшинг биелүүлэхийн тулд аймаг орон нутагт зарлагдсан тендерт оролцож зам барилгын ажил хийх, замын барилгын байгууллагуудын туслан гүйцэтгэгчээр ажиллаж үндсэн ажлаасаа хөндийрч тэр хэмжээгээр улсын авто зам хариуцсан эзэнгүйдэх явдал гарч байна.

Авто замын салбарын 1990-2018 оны хөрөнгө оруулалт, үр дүнгийн судалгаагаар урсгал засвар, арчлалтад нийт хөрөнгө оруулалтын дөнгөж 5.8 % нь оногдож байгаа нь авто зам замын байгууламжийн засвар арчлалтын ажлын чанар, үр ашигт муугаар нөлөөлж байна.

Авто замын арчлалт, засварын ажил ийм байдлаар үргэлжилсэн тохиолдолд одоо баригдсан байгаа хатуу хучилттай авто замууд эвдэрч, устаж үгүй болон авто замуудыг шинээр дахин барих шаардлага гарах эрсдэл тулгарч байна.

Дээрх нөхцөл байдлаас үндэслэн "Олон улс, улсын чанартай авто замын сүлжээний арчлалт, засвар, ашиглалтыг сайжруулж чадавхыг бэхжүүлэх дунд хугацааны хөтөлбөр"-ийг боловсруулан хэрэгжүүлэх бодит шаардлагын үүднээс энэхүү хөтөлбөрийг гаргаж байна.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ

- 2.1 Хөтөлбөр нь олон улс, улсын чанартай авто замын сүлжээний арчлалт, засварын ажил, түүнд хамааралтай төрийн болон хувийн хэвшлийн бүх хэлбэрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хамаарна.
- 2.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:
 - 2.2.1 Олон улс, улсын чанартай авто замын сүлжээний арчлалт, засварын ажлыг нэгдсэн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулан хөгжүүлэх;
 - 2.2.2 Авто замын сүлжээг ашиглах, засварлах үйл ажиллагаа удирдлагын нэгдмэл бүтэц, тогтолцоотой байх;
 - 2.2.3 Авто зам ашиглах, арчлах, хамгаалах, засварлах үеийн үйл ажиллагаа нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх;
 - 2.2.4 Авто замын арчлалт засварын ажил төр хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагаанд тулгуурласан байна;

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Олон улс, улсын чанартай авто замын сүлжээний арчлалт, засварын ажлыг сайжруулан шинэ түвшинд гаргаж зам, замын байгууламжийн ашиглалтын бэлэн байдлыг бүрэн хангаж, авто зам хэрэглэгчдийг аюулгүй, тав тухтай авто замаар байнга үйлчлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ

- 4.1. Авто замын засвар арчлалтын ажлын удирдлага, зохион байгуулалтыг тодорхой, оновчтой болгож, хяналтын тогтолцоог сайжруулах;
- 4.2. Авто замын засвар арчлалтын ажлын стандарт, норм дүрэм, эрх зүйн орчинг боловсронгуй болгох;
- 4.3. Авто замын арчлалт, урсгал засварын ажлын хөрөнгө оруулалтыг шаардлагатай хэмжээнд хүртэл нэмэгдүүлж замын ашиглалтын бэлэн байдлын түвшингээр санхүүжүүлэн зам хариуцагч компаниудын идэвх санаачилга, хариуцлагыг дээшлүүлэх;




- 4.4. Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийн ээлжит болон их засварыг хугацааны норматив, техник ашиглалтын түвшингийн дүгнэлтэд үндэслэн үе шаттайгаар хийж хэвшүүлэх;
- 4.5. Авто замын арчлалт, засварын ажилд шинэ техник, технологи нэвтрүүлж, АЗЗА-ын компаниудын хүчин чадлыг нэмэгдүүлж, чадавхыг бэхжүүлэх;
- 4.6. Авто замын үндсэн хөрөнгийн менежментийг хэрэгжүүлж засварын ажлын хөрөнгө оруулалт түүний үр өгөөжийг нэмэгдүүлэх;
- 4.7. Олон улс, улсын чанартай авто замын сүлжээний тэмдэгжүүлэлт, мэдээллийг тодорхой болгож замын дагуух үйлчилгээг нэмэгдүүлэн сайжруулж зам хэрэглэгчдийн тав, тухтай зорчих нөхцөл, боломжийг бүрдүүлэх;

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

5.1 Авто замын засвар арчлалтын ажлын удирдлага, зохион байгуулалтыг тодорхой, оновчтой болгож, хяналтын тогтолцоог сайжруулах зорилтын хүрээнд:

- 5.1.1 Олон улс, улсын чанартай авто замын арчлалт, засварын ажлын удирдлага зохион байгуулалтын өнөөгийн тогтолцоонд өөрчлөлт оруулж төрийн өмчийн АЗЗА компаниудын төрийн өмчийн төлөөллийг ЗТХЯ-нд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх,
- 5.1.2 ЗТХЯ төрийн өмчит АЗЗА компанийн дүрэм, бүтэц, зохион байгуулалт, зорилтот түвшин, эдийн засаг санхүүгийн төлөвлөгөөг баталж хэрэгжилтэд нь хяналт тавьж байх эрх зүйн орчинг бүрдүүлэх,
- 5.1.3 Олон улс, улсын чанартай авто замын арчлалт, засварын ажлыг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж, зам хариуцагч компаниудын мэргэжлийн, өдөр тутмын удирдлага, зохицуулалт, хяналтыг хийж байх үүргийг “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-т хариуцуулах,
- 5.1.4 “Авто замын зөвлөл”-ийг хуулийн дагуу байгуулан ажиллуулж замын ашиглалтын бэлэн байдалд зам хэрэглэгч, олон нийтээс тавих хяналтыг хэрэгжүүлэн тэдний дэмжлэг тусалцааг авч хамтран ажиллах,
- 5.1.5 Зам хариуцагч төрийн өмчит компаниудын захирлаар мэргэжлийн болон эдийн засгийн өндөр мэдлэг, ажлын дадлага туршлага, ёс зүйтэй хүнийг томилж тогтвортой ажиллуулах чиглэлийг тууштай баримталж “Авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын зохион байгуулалтын дүрэм”-ийн 5.3.7-дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах,
- 5.1.6 Зам хариуцагч хувийн өмчит компаниудын шалгаруулалтад тавих шаардлагыг өндөржүүлж, гэрээгээр хүлээх үүргийг тодорхой болгож, тавих хяналтыг сайжруулах,
- 5.1.7 Авто зам хариуцагч компаниудын хариуцах замын уртыг оновчтой тогтоож авто замын ашиглалтын бэлэн байдлыг хангах, арчлалт засварын ажлын чанар, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар шаардлага, хариуцлагыг өндөржүүлэх заалтуудыг зам хариуцах гэрээнд тусган тогтмол хугацаанд дүгнэж байх,
- 5.1.8 Олон улс, улсын чанартай авто замын зурвас газрыг эзэмшигч буюу ЗТХЯ-ны бүртгэлд хамруулж кадастржуулах, “Авто замын тухай хууль”-ийн 4.1.7-д заасан зориулалтаар ашиглаж зурвас газарт явуулж буй үйл ажиллагаанаас Авто замын санд орлого олох боломжийг хуулийн дагуу бүрдүүлэх.
- 5.1.9 Авто замын арчлалт, засвар, ашиглалтад тавих хяналтыг сайжруулан үр нөлөөтэй болгох зорилгоор зам засварын ажлын хяналтын инженерүүдийг улсын байцаагчийн эрхтэй болгох асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлэх
- 5.1.10 Улсын чанартай хатуу хучилттай авто замд даац хэтрүүлэн тээвэр хийдэг асуудлыг арилгах зорилгоор төлбөр хураах цэгүүдэд даац хэмжих төхөөрөмж байрлуулан стандартыг мөрдүүлж даац хэтрүүлэн тээвэрлэлт хийх явдлыг зогсоох арга хэмжээг шат дараатай авах



115

5.2 Авто замын засвар арчлалтын ажлын стандарт, норм дүрэм, эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилтын хүрээнд

5.2 Авто замын арчлалт, засвар, ашиглалтын норм, дүрэм, стандартуудад үзлэг, шинжилгээ хийж өөрчлөн сайжруулах, шаардлагатай норм, стандарт, дүрмийг шинээр боловсруулан хууль эрх зүй, стандартын оновчтой тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх

- 5.2.1. "Авто зам, замын байгууламжийн засварын ажлын үйлдвэрлэлийн жишиг норм БНБД 81-20-08"-ыг шинэчлэн боловсруулж батлуулан хэрэгжүүлэх
- 5.2.2. "Авто зам, замын байгууламжийн засварын ажлын төсвийн жишиг норм БНБД 81-26-08"-ыг шинэчлэн боловсруулах ажлыг дуусгаж хэрэгжүүлэх
- 5.2.3. Авто замын орон зайн мэдээллийн санд суурилсан веб аппликэйшнд улсын чанартай авто замын судалгааны мэдээллийг оруулах, веб аппликэйшнийг мэргэжлийн, хэрэглээний түвшинд ашиглах дадлагыг бий болгох, олон улсын стандартын түвшинд нэгдсэн мэдээллийг системийг бий болгох
- 5.2.4. Авто зам, замын байгууламжийн техник ашиглалтын түвшин тогтоох үнэлэх аргачлал MNS 6441:2014 стандартыг шинэчлэн гаргаж хэрэгжүүлэх
- 5.2.5. "Авто зам, замын байгууламжийн засвар арчлалтын арга технологи БНБД 13-03-00" нормыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх
- 5.2.6. "Авто зам, замын байгууламжийн засвар арчлалтын техникийн шаардлага" нормыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх
- 5.2.7. "Авто зам, замын байгууламжийн арчлалт, урсгал засвар, онцгой ажлуудыг гүйцэтгэх хугацааны норм ЗЗБНБД 41-010-2016"-ыг шинэчлэн боловсруулах
- 5.2.8. "Авто зам, замын байгууламжийн арчлалт засварын зохион байгуулалт техникийн дүрэм ЗЗБНБД 41-011-2016"-ыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх

5.3 Авто замын арчлалт, урсгал засварын ажлын хөрөнгө оруулалтыг шаардлагатай хэмжээнд хүртэл нэмэгдүүлж замын ашиглалтын бэлэн байдлын түвшингээр санхүүжүүлэн зам хариуцагч компаниудын идэвх санаачилга, хариуцлагыг дээшлүүлэх зорилтын хүрээнд

- 5.3.1 Авто замын арчлалт урсгал засварын ажилд зарцуулах хөрөнгө оруулалтыг жил тутам нэмэгдүүлэн шаардлагатай хэмжээнд хүргэх.
- 5.3.2 Зам, тээврийн хөгжлийн сайд болон Сангийн сайдын хамтарсан "Журам батлах тухай" 2020 оны 154/А/159 дугаар тушаалаар батлагдсан "Авто замын ашиглалтын бэлэн байдлын түвшнээр санхүүжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангаж 2021 оноос зарим компаниудад туршилтын журмаар хэрэгжүүлж эхлэн 2023 онд бүх компаниудыг хамруулах арга хэмжээ авах
- 5.3.3 Олон улс, улсын чанартай авто замын ашиглалтын бэлэн байдлын судалгааг хийж зам хариуцагч компаниудын хариуцсан замын бэлэн байдлын түвшинг замын хучилтын төрөл, насжилтын байдлаар нь тогтоох ажлыг зохион байгуулах
- 5.3.4 Авто замын ашиглалтын бэлэн байдлыг шалгаж дүгнэн санхүүжүүлэх нарийвчилсан журмыг боловсруулж баталж хэрэгжүүлэх
- 5.3.5 "Авто замын сан"-г шаардагдах эх үүсвэрээр нь байнга хангаж хуульд заасан чиг үүргийн дагуу бие даасан хэлбэрээр ажиллуулж замын арчлалт, урсгал засварын ажлыг бүрэн хэмжээгээр сангаас санхүүжүүлэн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх
- 5.3.6 Авто замын сангийн орлогын эх үүсвэрийг тогтвортой хэмжээнд нэмэгдүүлэх арга хэмжээ авч сангийн үйл ажиллагааг зах зээлийн зарчимд нийцүүлэн өөрийн орлогоор санхүүждэг болох чиглэлийг баримтлан эрх зүйн орчныг бүрдүүлнэ.



5.4 Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийн ээлжит болон их засварыг хугацааны норматив, техник ашиглалтын түвшингийн дүгнэлтэд үндэслэн үе шаттайгаар хийж хэвшүүлэх зорилтын хүрээнд

- 5.4.1 Авто замын салбарын хөрөнгө оруулалтыг төлөвлөж, санхүүжүүлэхэд эхний ээлжид одоо ашиглагдаж байгаа хатуу хучилттай зам, гүүрийн ээлжит болон их засварын ажлыг гүйцэтгэхэд чиглүүлж зам, замын байгууламжийг удаан хугацаанд хэвийн хэмжээнд ашиглаж байх боломжийг бүрдүүлэх
- 5.4.2 Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу олон улс, улсын чанартай авто замын сүлжээний 10 чиглэлийн 515,06 км, замд их засвар, 5 чиглэлийн 334,2 км хатуу хучилттай авто замд ээлжит засвар хийх ажлыг зохион байгуулах
- 5.4.3 Авто замын ээлжит засвар хийх орчин үеийн өндөр бүтээмжтэй тоног төхөөрөмж нь өндөр үнэтэй учир зам хариуцагч компаниуд худалдан авах боломжгүй байгааг харгалзан энэ асуудлыг нэгдсэн байдлаар шийдвэрлэн компаниудад түрээсээр ашиглуулж ээлжит засварыг нормативт хугацаанд нь хийж байх оновчтой тогтолцоог бүрдүүлж ажиллах
- 5.4.4 Авто замын ээлжит болон их засвар хийхийн өмнө замын техник ашиглалтын түвшин болон хийх засварын хэмжээг тогтоох судалгааг энэ ажлаар мэргэшсэн багаар хийлгэж зургийн даалгаврыг бодитой гаргаж зураг төслийн чанарыг сайжруулахад анхаарч хэвшүүлэх
- 5.4.5 Ээлжит болон их засварын ажилд тавих хяналтын тогтолцоо, үүрэг, хариуцлагыг дээшлүүлж хөндлөнгийн хяналтын үр нөлөөг нэмэгдүүлж замын барилгын ажлын менежмент, хөдөлгөөн зохицуулалтыг сайжруулж, ээлжит болон их засварын ажлын үед хөдөлгөөний саатал, аваар, осолгүй байх нөхцөлийг бүрдүүлж ажиллах
- 5.4.6 Олон улс, улсын чанартай авто замд 2025-2028 онд хийх их болон ээлжит засварын ажлыг тодорхойлон үе шаттайгаар төлөвлөн гүйцэтгэж байх

5.5 Авто замын арчлалт, засварын ажилд шинэ техник, технологи нэвтрүүлж, АЗЗА-ын компаниудын хүчин чадлыг нэмэгдүүлж, чадавхыг бэхжүүлэх зорилтын хүрээнд


- 5.5.1. Авто замын арчлалт, засварын ажилд ашиглагдаж байгаа бусад улс орнуудын дэвшилтэт шинэ технологийг судалж нэвтрүүлэхийн дээр зам, замын байгууламжийн засварын ажилд тохирсон бага оврын өндөр хүчин чадалтай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах арга хэмжээ авах
- 5.5.2. Төрийн өмчит АЗЗА-ын компаниудын машин механизм тоног төхөөрөмжийг шинэчлэх талаар дараах арга хэмжээг авч ажиллана. Үүнд:
 - Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хооронд байгуулсан Экспортын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд авто замын засвар арчлалтын нүхэн засварын тусгай тоноглол бүхий MA3-5337A2-348-600 маркийн "Тайфун" авто машин 21 ширхэг, хосолмол ажиллагаатай тусгай зориулалтын тоноглол бүхий MA3-5905A2-390 маркийн авто машин 21 ширхгийг худалдан авах
 - Азийн хөгжлийн банкны зээлээр Гадаргуун боловсруулалтын машин /Чип силлэр/ Гадаргуун боловсруулалтын машин /Слюрри силлэр/ Авто замын үзлэгийн машин /Laser Crack Measurement System/ тус бүр 1 ширхгийг худалдан авах
 - Улсын төсвийн хөрөнгөөр 2021-2024 онд 65,9 тэрбум төгрөгийн үнэ бүхий 15 нэр төрлийн 435 ширхэг машин механизм тоног төхөөрөмжийг худалдан авах



- 5.5.3. Хувийн өмчит АЗЗА-ын компаниудтай байгуулах зам хариуцагчийн гэрээнд заавал байх машин, механизм тоног, төхөөрөмж, багаж хэрэгслийг нарийвчлан тодорхой зааж хэрэгжилтэд нь хяналт тавьж машин механизм, тоног төхөөрөмжөө сайжруулахад нь дэмжлэг үзүүлж хамтран ажиллах
- 5.5.4. АЗЗА-ын байгууллагуудыг шаардлагатай ИТА, мэргэжилтэй ажилчдаар бүрэн хангаж, мэдлэг, чадварыг нь дээшлүүлэх ажлыг төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлэх
- 5.5.5. Авто замын мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэж байгаа их, дээд сургууль, коллежид суралцагсдыг зам, замын байгууламжийн арчлалт, засварын чиглэлээр мэргэшүүлэх талаар хамтран ажиллаж зам хариуцагч компаниудад дадлага хийлгэж байх ажлыг зохион байгуулах
- 5.5.6. Авто замын инженер, техникч зэрэг мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудын судалгаа гаргаж тэднийг аймгууд дахь зам хариуцагч компаниудад ажиллуулахыг дэмжиж, урамшуулах арга хэмжээ авч ажиллах
- 5.5.7. АЗЗА-ын байгууллагуудын инженер техникийн ажилтнуудыг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, зэрэг олгох, гадаад, дотоодын их дээд сургуульд мэргэшлийн чиглэлээр нь сургалтад хамруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах
- 5.5.8. АЗЗА-ын байгууллагуудын ИТА-уудын цалин, урамшууллыг нэмэгдүүлж нийгмийн асуудлыг нь шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх
- 5.5.9. Авто замын засвар арчлалтын мэргэжилтэй ажилчид бэлтгэх талаар мэргэжил сургалтын төв, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж тэднийг зам хариуцагч компаниудад тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх
- 5.5.10. Авто замын засвар арчлалтын байгууллагуудын мэдээллийн системийг боловсронгуй болгох талаар дараах арга хэмжээг авч ажиллана. Үүнд:
 - “Авто замын орон зайн мэдээллийн санд суурилсан веб аппликейшнд улсын чанартай замын судалгааны мэдээллийг оруулах, веб аппликейшнийг мэргэжлийн, хэрэглээний түвшинд ашиглах дадлагыг бий болгох, олон улсын стандартын түвшинд нэгдсэн мэдээллийн системийг бий болгох” төсөл хэрэгжүүлж, ашиглалтад нэвтрүүлэх,
 - Авто зам хэрэглэгчдээс цахимаар замын нөхцөл байдлын мэдээллийг шуурхай авах програм хангамжийг хөгжүүлэх
 - Авто зам, замын байгууламжийн төвөгшилтэй цэгүүдийг камержуулж, нэгдсэн мэдээллийн системд холбох
 - Авто зам, замын байгууламжийн техник ашиглалтын түвшин тогтоох судалгааны үр дүнг авто замын орон зайн нэгдсэн мэдээллийн системд холбох
 - Олон улс, улсын чанартай авто замын бэлэн байдлын мэдээ авах системийг сайжруулан цаашид нэгдсэн удирдлагын төвтэй болох ажлыг шат дараатай авч хэрэгжүүлэх

5.6 Авто замын үндсэн хөрөнгийн менежментийг хэрэгжүүлж засварын ажлын хөрөнгө оруулалт түүний үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд;

- 5.6.1 Авто замын засвар арчлалтын ажлыг Замын үндсэн хөрөнгийн менежментийн систем (ЗҮХМС)-д үндэслэн гүйцэтгэж засвар арчлалтын ажилд шаардлагатай хөрөнгийн хэмжээг тодорхойлж төлөвлөн оновчтой хэрэгжүүлж зам, замын байгууламжийн ашиглалтыг сайжруулан хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх
- 5.6.2 Олон улс, улсын чанартай авто замын сүлжээний дахин үнэлгээг хийж зам, замын байгууламжийн үнэлгээг чиглэл бүрээр нь гарган үндсэн хөрөнгийн бүртгэлд оруулан жил бүр элэгдэл, хорогдлыг тооцон, өртгийн хөдөлгөөн хийж байх ажлыг хэвшүүлэх



- 5.6.3 Авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажлын хөрөнгө оруулалтын үр ашгийг тодорхой хугацаанд тооцон цаашид авах арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлж байх
- 5.6.4 Олон улс, улсын чанартай авто замаас төлбөр авах замын уртыг оновчтой тогтоож хоёр урсгалд нь төлбөр авах асуудлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх
- 5.6.5 Авто зам ашигласны төлбөрийн одоогийн хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх
- 5.6.6 Авто замын төлбөр авах цэгүүдийн байршлыг оновчтой тогтоон нэмэгдүүлж цахимжуулан хувь хүний оролцоо нөлөөллийг аль болох багасгах арга хэмжээ авах.
- 5.6.7 Авто замын улсын байцаагчийн ногдуулсан торгууль шийтгэврийн орлогын тодорхой хэсгийг авто замын санд төвлөрүүлэх асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх
- 5.6.8 Олон улс, улсын чанартай авто замын арчлалт, засварын ажлын хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, хяналтыг сайжруулан үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах

5.7 Олон улс, улсын чанартай авто замын сүлжээний тэмдэгжүүлэлт, мэдээллийг тодорхой болгож замын дагуух үйлчилгээг нэмэгдүүлэн сайжруулж зам хэрэглэгчдийн тав, тухтай зорчих нөхцөл, боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд

- 5.7.1 Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратегийг хэрэгжүүлэх шат дараатай арга хэмжээ авч замын тэмдэг тэмдэглэгээ, мэдээллийг оновчтой тодорхой болгож замаас хамааран гарах осол, авааргүй орчин нөхцөлийг бүрдүүлэх
- 5.7.2 Олон улс, улсын чанартай авто зам болон түүнээс салаалах орон нутгийн замыг тэмдэгжүүлэх арга хэмжээг нэгдсэн зохион байгуулалт, төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлж зорчигчид хаана, ямар онцлогтой замаар явж байгаа мэдээллийг авч зорьсон газраа төөрч, будлихгүйгээр хүрч байх нөхцөлийг шат дараатайгаар бүрдүүлэх
- 5.7.3 Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын нийт зурвас газрын судалгааг гарган кадастрын бүртгэлд хамруулах асуудлыг зохион байгуулж ЗТХЯ-ны эзэмшилд авах
- 5.7.4 Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын зурвас газарт үйл ажиллагаа, үйлчилгээ эрхэлж байгаа байгууллага, иргэдийн судалгаа гаргаж цаашид зурвас газрыг чөлөөлөх болон үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох зэргээр шийдвэрлэх
- 5.7.5 Авто замын зурвас газарт үйл ажиллагаа, үйлчилгээ явуулах, түүнд тавигдах шаардлага болон тодорхой хураамж тогтоох журам боловсруулж батлуулан хэрэгжүүлэх
- 5.7.6 Олон улс, улсын чанартай авто замын зурвас газарт үйл ажиллагаа, үйлчилгээ явуулах, газар эзэмшүүлэхгүй байх талаар орон нутгийн төр, захиргааны байгууллагад мэдэгдэл өгч зурвас газрыг хамгаалах, тохижуулах талаар хамтран ажиллах
- 5.7.7 Зам хариуцагч байгууллагаас замын зурвас газарт ажил гүйцэтгэх үүргийг тодорхой болгож байнга тохижуулан арчлан хамгаалдаг болгох арга хэмжээ авах
- 5.7.8 Олон улс, улсын чанартай авто замын сүлжээгээр зорчигчдын тав, тухтай зорчих боломжийг бүрдүүлэх зорилгоор замын дагууд тээврийн хэрэгслийн түр зогсох талбайг үе шаттайгаар байгуулна. Түр зогсох талбай нь тээврийн хэрэгслийн зогсох талбай, бие засах цэг, хогийн сав, сууж амрах сандал, ширээ зэргээс бүрдэнэ.
- 5.7.9 Зогсоол хоорондын зайг тухайн замын хөдөлгөөний эрчим, газар орон, авто замын нөхцөл байдлыг харгалзан тогтооно.
- 5.7.10 Олон улс, улсын чанартай авто замын сүлжээгээр зорчих тээврийн хэрэгслийн жолооч, зорчигчдын амрах болон машиндаа үзлэг, үйлчилгээ

МОНГОЛ УЛСЫН
 ЗАМ, ТЭЭВРИЙН ХЭРЭГЛИЙН ЯАМ
 9
 ЭХ ХУВЬ
 Сайд Төрийн нарийн бичгийн
 дарга 2020 он 11/23

хийх зориулалтаар авто замын дагууд үйлчилгээний цогцолборуудыг байгуулж ажиллуулна. Үйлчилгээний цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулж ажиллуулна.

5.7.11 Олон улс, улсын чанартай авто замын сүлжээний дагууд түр зогсох талбай болон үйлчилгээний цогцолбор байгуулж ажиллуулах журам гарган баталж хэрэгжүүлнэ

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ХУГАЦАА

Хөтөлбөрийг 2021-2028 онд 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

Хөтөлбөрийн 1-р үе шат (2021-2024 он, хөтөлбөрийн богино хугацааны зорилтыг шийдвэрлэх үе): 2024 онд Зам, тээврийн хөгжлийн яамнаас хөтөлбөрийн богино хугацааны зорилтын биелэлтэд дүгнэлт өгнө;

Хөтөлбөрийн 2 дугаар үе шат (2025-2028 он, хөтөлбөрийн зорилтыг шийдвэрлэх үе): 2028 онд хөтөлбөрийн зорилго, зорилтыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтад үзүүлэв.

ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээр санхүүжүүлнэ.

- ✓ Улс, орон нутгийн төсөв;
- ✓ Авто замын сан;
- ✓ Төр хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө
- ✓ Гадаад орон, олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, тусламж, хандив;

Хөтөлбөрийн эхний үе шат буюу 2020-2024 оны үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийн төсөөллийг 2 дугаар хавсралтад үзүүлэв.

НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

	ЗОРИЛТ	2021-2024 он	2025-2028 он
1	Авто замын засвар арчлалтын ажлын удирдлага, зохион байгуулалтыг тодорхой, оновчтой болгож, хяналтын тогтолцоог сайжруулах	АЗЗА компани, "ЗТХТ" ТӨҮГ-ыг ЗТХЯ-ны харъяанд ажиллуулна.	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Авто замын газар байгуулна.
2	Авто замын засвар арчлалтын ажлын стандарт, норм дүрэм, эрх зүйн орчинг боловсронгуй болгох;	Авто замын засвар арчлалтын голлох норм дүрэм, стандартыг шинэчлэн батална.	Авто замын засвар арчлалтын ажлын эрх зүйн орчин олон улсын түвшинд нийцсэн байна.
3	Авто замын арчлалт, урсгал засварын ажлын хөрөнгө оруулалтыг шаардлагатай хэмжээнд хүртэл нэмэгдүүлж замын ашиглалтын бэлэн байдлын түвшингээр санхүүжүүлэн зам хариуцагч компаниудын идэвх санаачилга, хариуцлагыг дээшлүүлэх	Авто замын арчлалт, урсгал засварын ажлын хөрөнгө оруулалтыг шаардлагатай хэмжээнд хүртэл нэмэгдүүлж замын ашиглалтын бэлэн, байдлын түвшингээр санхүүжүүлэн ажлыг тогтмолжуулсан байна.	Авто замын санг бие даасан байдлаар ажиллуулна.
4	Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийн	2020-2024 оны хооронд нийт 515,06 км авто замд	Олон улс, улсын чанартай авто замд

10

ЭХ ХУВЬ

Сайд Төрийн нарийн бичгийн дарга 2020 он /1/23/

	ээлжит болон их засварыг хугацааны норматив, техник ашиглалтын түвшингийн дүгнэлтэд үндэслэн үе шаттайгаар хийж хэвшүүлэх	ээлжит засвар, 334,2 км авто замд их засвар хийнэ.	2025-2028 онд хийх их болон ээлжит засварын ажлыг тодорхойлон үе шаттайгаар төлөвлөн гүйцэтгэсэн байна
5	Авто замын арчлалт, засварын ажилд шинэ техник, технологи нэвтрүүлж, АЗЗА-ын компаниудын хүчин чадлыг нэмэгдүүлж, чадавхыг бэхжүүлэх	АЗЗА байгууллагуудыг шаардлагатай машин механизм, тоног төхөөрөмж, ИТА, мэргэжилтэй ажилчдаар бүрэн хангасан байна.	АЗЗА-ын компаниудын чадавх олон улсын түвшинд хүрсэн байна.
6	Авто замын үндсэн хөрөнгийн менежментийг хэрэгжүүлж засварын ажлын хөрөнгө оруулалт түүний үр өгөөжийг нэмэгдүүлэх	Авто замын зурвас газрын менежментийг сайжруулан хөрөнгө оруулалт түүний үр өгөөж нэмэгдсэн байна.	Авто замын үндсэн хөрөнгийн менежмент, хөрөнгө оруулалт үр өгөөж олон улсын түвшинд хүрсэн байна.
7	Олон улс, улсын чанартай авто замын сүлжээний тэмдэгжүүлэлт, мэдээллийг тодорхой болгож замын дагуух үйлчилгээг нэмэгдүүлэн сайжруулж зам хэрэглэгчдийн тав, тухтай зорчих нөхцөл, боломжийг бүрдүүлэх;	Олон улс, улсын чанартай авто замын сүлжээний тэмдэгжүүлэлт, мэдээлэл, замын дагуух үйлчилгээ сайжирсан байна.	Авто зам хэрэглэгчдийн тав, тухтай зорчих нөхцөл, боломж бүрдсэн байна.


ЕС. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

- 9.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах ажлыг зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Авто замын асуудал хариуцсан бүтцийн нэгж хариуцна. Шаардлагатай тохиолдолд хөтөлбөрийн зорилтуудыг хангах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна.
- 9.2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ хийж, шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын зохион байгуулалтын бүтцийн нэгж 2 жил тутам зохион байгуулна.
- 9.3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд үндэслэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

АРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨ

- 10.1 Авто замын арчлалт засварын ажлын удирдлага, зохион байгуулалт, хяналтын тогтолцоо оновчтой, боловсронгуй болно.
- 10.2 Авто замын арчлалт, засварын ажлын хөрөнгө оруулалт нэмэгдэж үр ашиг нь дээшилнэ.
- 10.3 Авто замын бэлэн байдлын түвшин тогтвортой байж хөдөлгөөний аюулгүй байдал, зорчигчийн тав тух дээшилнэ.
- 10.4 Авто замын сүлжээний арчлалт, засвар, ашиглалтын чадавх бэхжинэ.

-oOo-



1 дүгээр хавсралт

“ОЛОН УЛС, УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭНИЙ АРЧЛАЛТ, ЗАСВАР, АШИГЛАЛТЫГ САЙЖРУУЛЖ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨР”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хариуцах байгууллага	Хэрэгжих хугацаа
Нэг. Авто замын засвар арчлалтын ажлын удирдлага, зохион байгуулалтыг тодорхой, оновчтой болгож, хяналтын тогтолцоог сайжруулах;					
1.1	Олон улс, улсын чанартай авто замын арчлалт, засварын ажлын удирдлага зохион байгуулалтын өнөөгийн тогтолцоонд өөрчлөлт оруулж төрийн өмчийн АЗЗА компаниудын төрийн өмчийн төлөөллийг ЗТХЯ-нд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх.	Засгийн газрын тогтоол	Төрийн өмчийн АЗЗА компаниудын төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх эрх ЗТХЯ-нд шилжсэн байх	АЗБХЗГ	2021
1.2	ЗТХЯ төрийн өмчит АЗЗА компанийн дүрэм, бүтэц, зохион байгуулалт, зорилгот түвшин, эдийн засаг санхүүгийн төлөвлөгөөг баталж хэрэгжилтэд нь хяналт тавьж байх эрх зүйн орчинг бүрдүүлэх.	Сайдын тушаал	Төрийн өмчит АЗЗА компанийн дүрэм, бүтэц, зохион байгуулалт батлагдсан байх	АЗБХЗГ ХШУДАГ	2021
1.3	Олон улс, улсын чанартай авто замын арчлалт, засварын ажлыг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж, зам хариуцагч компаниудын мэргэжлийн, өдөр тутмын удирдлага, зохицуулалт, хяналтыг хийж байх үүргийг “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-т хариуцуулах.	Сайдын тушаал	Авто замын арчлалт, засварын ажил нэгдсэн зохион байгуулалт, удирдлага, зохицуулалтаар ханган ажиллах талаар тушаал, шийдвэр гарч хэрэгжсэн байх	АЗБХЗГ ЗТХТ	2021
1.4	“Авто замын зөвлөл”-ийг хуулийн дагуу байгуулан ажиллуулж замын ашиглалтын бэлэн байдалд зам хэрэглэгч, олон нийтээс тавих хяналтыг хэрэгжүүлэн тэдний дэмжлэг туслалцааг авч хамтран ажиллах.	“Авто замын зөвлөл”	“Авто замын зөвлөл” байгуулагдсан байх	АЗБХЗГ Авто замын зөвлөл	2021
1.5	Зам хариуцагч хувийн өмчит компаниудын шалгаруулалтад тавих шаардлагыг өндөржүүлж, гэрээгээр хүлээх үүргийг тодорхой болгож, тавих хяналтыг сайжруулах	Гэрээ	Зам хариуцагч хувийн өмчит компаниудын гэрээгээр хүлээх үүрэг тодорхой болсон байх	ЗТХТ АЗЗА компаниуд	байнга
1.6	Авто зам хариуцагч компаниудын хариуцах замын уртыг оновчтой тогтоож авто замын ашиглалтын бэлэн байдлыг хангах, арчлалт засварын ажлын чанар, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар шаардлага, хариуцлагыг өндөржүүлэх заалтуудыг зам хариуцах гэрээнд тусган тогтмол хугацаанд дүгнэж байх	Сайдын тушаал Гэрээ дүгнэсэн акт	Зам хариуцагч компаниудын хариуцах замын урт оновчтой тогтоогдсон байх Хариуцлагын талаарх заалтууд гэрээнд тусгагдаж хэрэгжсэн байх	АЗБХЗГ ХШУДАГ ЗТХТ АЗЗА компаниуд	2021 Жил тутам

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

12

ЭХ ХУВЬ

Сайд Төрийн ордин Фынгийн

дэргэдүүд

2020

А/15

1.7	Олон улс, улсын чанартай авто замын зурвас газрыг эзэмшигч буюу ЗТХЯ-ны бүртгэлд хамруулж кадастржуулах, "Авто замын тухай хууль"-ийн 4.1.7-д заасан зориулалтаар ашиглаж зурвас газарт явуулж буй үйл ажиллагаанаас Авто замын санд орлого олох боломжийг хуулийн дагуу бүрдүүлэх.	Кадастрын гэрчилгээ Авто замын сангийн орлогын хэмжээ	Олон улс, улсын чанартай авто замын зурвас газрын кадастрын гэрчилгээ авсан байх "Авто замын тухай хууль"-ийн 4.1.7-д заасан үйл ажиллагаанаас Авто замын санд оруулах орлогын хэмжээ нэмэгдсэн байх	АЗБХЗГ	2021
1.8	Авто замын арчлалт, засвар, ашиглалтад тавих хяналтыг сайжруулан үр нөлөөтэй болгох зорилгоор зам засварын ажлын хяналтын инженерүүдийг улсын байцаагчийн эрхтэй болгох асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлэх	Авто замын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт	Авто замын засварын ажлын хяналтын инженерүүд улсын байцаагчийн эрхтэй болсон байх	АЗБХЗГ ХШУДАГ ЗТХТ	2021- 2024
1.9	Улсын чанартай хатуу хучилттай авто замд даац хэтрүүлэн тээвэр хийдэг асуудлыг арилгах зорилгоор төлбөр хураах цэгүүдэд даац хэмжих төхөөрөмж байрлуулан стандартыг мөрдүүлж даац хэтрүүлэн тээвэрлэлт хийх явдлыг зогсоох арга хэмжээг шат дараатай авах	Даац хэмжих төхөөрөмж	Улсын чанартай хатуу хучилттай авто замын төлбөр хураах бүх цэгүүдэд даац хэмжих төхөөрөмж байрлуулсан байх	АЗБХЗГ АЗЗА компаниуд	2021- 2024
Хоёр. Авто замын засвар арчлалтын ажлын стандарт, норм дүрэм, эрх зүйн орчинг боловсронгуй болгох					
2.1	"Авто зам, замын байгууламжийн засварын ажлын үйлдвэрлэлийн жишиг норм БНБД 81-20-08"-ыг шинэчлэн боловсруулж батлуулан хэрэгжүүлэх	Норм дүрэм	Нормыг шинэчлэн батлуулж хэрэгжүүлсэн байх	АЗБХЗГ СНХ АЗЗА компаниуд	2021
2.2.	"Авто зам, замын байгууламжийн засварын ажлын төсвийн жишиг норм БНБД 81-26-08"-ыг шинэчлэн боловсруулах ажлыг дуусгаж хэрэгжүүлэх	Норм дүрэм	Нормыг шинэчлэн батлуулж хэрэгжүүлсэн байх	АЗБХЗГ СНХ АЗЗА компаниуд	2021
2.3	Авто замын орон зайн мэдээллийн санд суурилсан веб аппликэйшнд улсын чанартай авто замын судалгааны мэдээллийг оруулах, веб аппликэйшнийг мэргэжлийн, хэрэглээний түвшинд ашиглах дадлагыг бий болгох, олон улсын стандартын түвшинд нэгдсэн мэдээллийг системийг бий болгох	веб аппликэйшн, мэдээллийн ситем	Нэгдсэн мэдээллийн систем бий болсон байх	АЗБХЗГ ЗТХТ	2021
2.4	Авто зам, замын байгууламжийн техник ашиглалтын түвшин тогтоох үнэлэх аргачлал MNS 6441:2014 стандартыг шинэчлэн гаргаж хэрэгжүүлэх	Стандарт	Стандартыг шинэчлэн батлуулж хэрэгжүүлсэн байх	АЗБХЗГ СНХ АЗЗА компаниуд	2021

2.5	"Авто зам, замын байгууламжийн засвар арчлалтын арга технологи БНБД 13-03-00" нормыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх	Норм дүрэм	Нормыг шинэчлэн батлуулж хэрэгжүүлсэн байх	АЗБХЗГ СНХ АЗЗА компаниуд	2021
2.6	"Авто зам, замын байгууламжийн засвар арчлалтын техникийн шаардлага" нормыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх	Техникийн шаардлага	Техникийн шаардлагыг шинэчлэн батлуулж хэрэгжүүлсэн байх	АЗБХЗГ СНХ АЗЗА компаниуд	2021
2.7	"Авто зам, замын байгууламжийн арчлалт, урсгал засвар, онцгой ажлуудыг гүйцэтгэх хугацааны норм ЗЗБНБД 41-010-2016"-ыг шинэчлэн боловсруулах	Норм дүрэм	Нормыг шинэчлэн батлуулж хэрэгжүүлсэн байх	АЗБХЗГ СНХ АЗЗА компаниуд	2021
2.8	"Авто зам, замын байгууламжийн арчлалт засварын зохион байгуулалт техникийн дүрэм ЗЗБНБД 41-011-2016"-ыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх	Норм дүрэм	Нормыг шинэчлэн батлуулж хэрэгжүүлсэн байх	АЗБХЗГ СНХ АЗЗА компаниуд	2021
Гурав. Авто замын арчлалт, урсгал засварын ажлын хөрөнгө оруулалтыг шаардлагатай хэмжээнд хүртэл нэмэгдүүлж замын ашиглалтын бэлэн байдлын түвшингээр санхүүжүүлэн зам хариуцагч компаниудын идэвх санаачилга, хариуцлагыг дээшлүүлэх;					
3.1	Авто замын арчлалт урсгал засварын ажилд зарцуулах хөрөнгө оруулалтыг жил тутам нэмэгдүүлэн шаардлагатай хэмжээнд хүргэх.	Авто замын арчлалт урсгал засварын ажилд зарцуулах хөрөнгө оруулалтын хэмжээ	2021 онд 52,0 тэрбум төгрөг 2022 онд 92,3 тэрбум төгрөг 2023 онд 94,8 тэрбум төгрөг 2024 онд 98,5 тэрбум төгрөг 2025-2028 онд 100-аас 112 тэрбум төгрөг болж жил тутам нэмэгдсэн байх	АЗБХЗГ БТГ	2021- 2028
3.2	Зам, тээврийн хөгжлийн сайд болон Сангийн сайдын хамтарсан "Журам батлах тухай" 2020 оны 154/А/159 дугаар тушаалаар батлагдсан "Авто замын ашиглалтын бэлэн байдлын түвшингээр санхүүжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангаж 2021 оноос зарим компаниудад туршилтын журмаар хэрэгжүүлж эхлэн 2023 онд бүх компаниудыг хамруулах арга хэмжээ авах	Журмаар санхүүжигдсэн компаний тоо	2021 онд 3 компани 2023 онд бүх компанийг Авто замын ашиглалтын бэлэн байдлын түвшингээр санхүүжүүлэх журамд хамруулсан байх	АЗБХЗГ ЗТХТ АЗЗА компаниуд	2021- 2023
3.3	Олон улс, улсын чанартай авто замын ашиглалтын бэлэн байдлын судалгааг хийж зам хариуцагч компаниудын хариуцсан замын бэлэн байдлын түвшинг замын хучилтын төрөл, насжилтын байдлаар нь тогтоох ажлыг зохион байгуулах	Судалгааны тайлан	Авто замын ашиглалтын бэлэн байдлын түвшинг замын хучилтын төрөл, насжилтын байдлаар нь тогтоосон байх	ЗТХТ	2021

3.4	Авто замын ашиглалтын бэлэн байдлыг шалгаж дүгнэн санхүүжүүлэх нарийвчилсан журмыг боловсруулж баталж хэрэгжүүлэх	Журам	Журмыг боловсруулж батлуулсан байх Журмын хэрэгжилтийг хангаж ажилласан байх	ЗТХТ АЗБА компаниуд	2021 байнга
3.5	"Авто замын сан"-г шаардагдах эх үүсвэрээр нь байнга хангаж хуульд заасан чиг үүргийн дагуу бие даасан хэлбэрээр ажиллуулж замын арчлалт, урсгал засварын ажлыг бүрэн хэмжээгээр сангаас санхүүжүүлэн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх	Авто замын сан	"Авто замын сан"-гийн орлого нь тухайн жилд шаардагдах замын арчлалт, урсгал засварын ажлыг бүрэн санхүүжүүлдэг хэмжээнд хүргэх "Авто замын сан"-г хуульд заасан чиг үүргийн дагуу бие даасан хэлбэрээр ажиллуулж эхлэх	АЗБХЗГ ЗТХТ	2021- 2024 2025
3.6	Авто замын сангийн орлогын эх үүсвэрийг тогтвортой хэмжээнд нэмэгдүүлэх арга хэмжээ авч сангийн үйл ажиллагааг зах зээлийн зарчимд нийцүүлэн өөрийн орлогоор санхүүждэг болох чиглэлийг баримтлан эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	Авто замын сан Холбогдох дүрэм журам	Авто замын сангийн орлогын эх үүсвэр жил тутам тогтвортой нэмэгдсэн байх Авто замын сангийн орлогоор зөвхөн засвар арчлалтын ажлыг санхүүжүүлдэг эрх зүйн орчин бүрдсэн байх.	АЗБХЗГ ЗТХТ АЗБХЗГ	Жил тутам 2021- 2022
Дөрөв. Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийн ээлжит болон их засварыг хугацааны норматив, техник ашиглалтын түвшингийн дүгнэлтэд үндэслэн үе шаттайгаар хийж хэвшүүлэх					
4.1	Авто замын салбарын хөрөнгө оруулалтыг төлөвлөж, санхүүжүүлэхэд эхний ээлжид одоо ашиглагдаж байгаа хатуу хучилттай зам, гүүрийн ээлжит болон их засварын ажлыг гүйцэтгэхэд чиглүүлж зам, замын байгууламжийг удаан хугацаанд хэвийн хэмжээнд ашиглаж байх боломжийг бүрдүүлэх	Ээлжит болон их засварын ажил хийгдсэн хатуу хучилттай зам, гүүрийн урт	Авто зам, замын байгууламжийг удаан хугацаанд хэвийн хэмжээнд ашиглаж байх боломж байх боломж бүрдсэн байх 23 км авто замд их засвар хийсэн байх 208,36 км авто зам их засвар, 102,2 км авто замд ээлжит засвар хийсэн байх 2023 онд -201,8 км авто зам их засвар, 123,56 км авто замд ээлжит хийсэн байх 81,9 км авто зам их засвар, 108,5 км авто замд ээлжит засвар хийсэн байх	АЗБХЗГ БТГ АЗБХЗГ АЗБХЗГ АЗБХЗГ	2022- 2024 2021 2022 2023 2024
4.2	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу олон улс, улсын чанартай авто замын сүлжээний 10 чиглэлийн 515,06 км, замд их засвар, 5 чиглэлийн 334,2 км хатуу хучилттай авто замд ээлжит засвар хийх ажлыг зохион байгуулах	Ээлжит болон их засварын ажил хийгдсэн хатуу хучилттай зам, гүүрийн урт			

4.3	Авто замын ээлжит засвар хийх орчин үеийн өндөр бүтээмжтэй тоног төхөөрөмж нь өндөр үнэтэй учир зам хариуцагч компаниуд худалдан авах боломжгүй байгааг харгалзан энэ асуудлыг нэгдсэн байдлаар шийдвэрлэн компаниудад түрээсээр ашиглуулж ээлжит засварыг нормативт хугацаанд нь хийж байх оновчтой тогтолцоог бүрдүүлж ажиллах	Нормативт хугацаанд нь ээлжит засварыг хийсэн авто замын урт	Өндөр бүтээмжтэй тоног төхөөрөмжийг АЗЗАкомпаниудад түрээсээр ашиглуулж авто замын ээлжит засвар хийх боломжийг хангасан байх	ЗТХТ АЗЗА компаниуд	2021-2028
4.4	Авто замын ээлжит болон их засвар хийхийн өмнө замын техник ашиглалтын түвшин болон хийх засварын хэмжээг тогтоох судалгааг энэ ажлаар мэргэшсэн багаар хийлгэж зургийн даалгаврыг бодитой гаргаж зураг төслийн чанарыг сайжруулахад анхаарч хэвшүүлэх	Авто замын ээлжит болон их засварын ажлын зураг төсөл	Авто замын ээлжит болон их засварын ажлын зураг төслийн чанарыг сайжруулсан байх	АЗБХЗГ Зураг төслийн компаниуд	Байнга
4.5	Ээлжит болон их засварын ажилд тавих хяналтын тогтолцоо, үүрэг, хариуцлагыг дээшлүүлж хөндлөнгийн хяналтын үр нөлөөг нэмэгдүүлж замын барилгын ажлын менежмент, хөдөлгөөн зохицуулалтыг сайжруулж, ээлжит болон их засварын ажлын үед хөдөлгөөний саатал, аваар, осолгүй байх нөхцөлийг бүрдүүлж ажиллах	Ээлжит болон их засварын ажлын чанар Ээлжит болон их засварын ажлын үед хөдөлгөөний саатал, аваар, ослын тоо	Ээлжит болон их засварын ажилд тавих хяналтын тогтолцоо, үүрэг хариуцлага дээшилсэн байх	АЗБХЗГ Гүйцэтгэгч компаниуд	Байнга
4.6	Олон улс, улсын чанартай авто замд 2025-2028 онд хийх их болон ээлжит засварын ажлыг тодорхойлон үе шаттайгаар төлөвлөн гүйцэтгэж байх	Төлөвлөгөө	2025-2028 онд хийх их болон ээлжит засварын ажлыг төлөвлөн гүйцэтгэсэн байх	АЗБХЗГ Гүйцэтгэгч компаниуд	2025-2028
Тав. Авто замын арчлалт, засварын ажилд шинэ техник, технологи нэвтрүүлж, АЗЗА-ын компаниудын хүчин чадлыг нэмэгдүүлж, чадавхыг бэхжүүлэх					
5.1	Авто замын арчлалт, засварын ажилд ашиглагдаж байгаа бусад улс орнуудын дэвшилтэт шинэ технологийг судалж нэвтрүүлэхийн дээр зам, замын байгууламжийн засварын ажилд тохирсон бага оврын өндөр хүчин чадалтай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах арга хэмжээ авах	Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тоо	Авто замын арчлалт, засварын ажилд нэвтэрсэн дэвшилтэт шинэ технологийн тоо	АЗЗА компаниуд	2021-2022
		Авто замын арчлалт, засварын ажилд нэвтэрсэн дэвшилтэт шинэ технологийн тоо	Авто замын арчлалт, засварын ажилд жил тутам 1-ээс доошгүй дэвшилтэт шинэ технологийг судалж нэвтрүүлсэн байх	АЗЗА компаниуд	Байнга

5.2	<p>Төрийн өмчит АЗЗА-ын компаниудын машин механизм тоног төхөөрөмжийг шинэчлэх талаар арга хэмжээг авч ажиллана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хооронд байгуулсан Экспортын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд авто замын засвар арчлалтын нүхэн засварын тусгай тоноглол бүхий МАЗ-5337А2-348-600 маркийн "Тайфун" авто машин 21 ширхэг, хосолмол ажиллагаатай тусгай зориулалтын тоноглол бүхий МАЗ-5905А2-390 маркийн авто машин 21 ширхэгийг худалдан авах - Азийн хөгжлийн банкны зээлээр Гадаргуун боловсруулалтын машин /Чип силлэр/ Гадаргуун боловсруулалтын машин /Слюрри силлэр/ Авто замын үзлэгийн машин /Laser Crack Measurement System/ тус бүр 1 ширхэгийг худалдан авах - Улсын төсвийн хөрөнгөөр 2021-2024 онд 65,9 тэрбум төгрөгийн үнэ бүхий 15 нэр төрлийн 435 ширхэг машин механизм тоног төхөөрөмжийг худалдан авах 	<p>Машин механизм тоног төхөөрөмж</p>	<p>МАЗ-5337А2-348-600 маркийн "Тайфун" авто машин 21 ширхэг, хосолмол ажиллагаатай тусгай зориулалтын тоноглол бүхий МАЗ-5905А2-390 маркийн авто машин 21 ширхэгийг худалдан авсан байх</p>	<p>АЗБХЗГ</p>	<p>2021</p>
5.3	<p>Хувийн өмчит АЗЗА-ын компаниудтай байгуулах зам хариуцагчийн гэрээнд заавал байх машин, механизм тоног, төхөөрөмж, багаж хэрэгслийг нарийвчлан тодорхой зааж хэрэгжилтэд нь хяналт тавьж машин механизм, тоног төхөөрөмжөө сайжруулахад нь дэмжлэг үзүүлж хамтран ажиллах</p>	<p>Машин механизм тоног төхөөрөмж</p>	<p>Хувийн өмчит АЗЗА-ын компаниудын машин механизм, тоног төхөөрөмж нормативын дагуу шаардлагатай хэмжээнд хүрсэн байх</p>	<p>АЗБХЗГ Хувийн өмчит АЗЗА-ын компаниуд</p>	<p>2021-2024</p>
5.4	<p>АЗЗА-ын байгууллагуудыг шаардлагатай ИТА, мэргэжилтэй ажилчдаар бүрэн хангаж, мэдлэг, чадварыг нь дээшлүүлэх ажлыг төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлэх</p>	<p>ИТА, мэргэжилтэй ажилчдын тоо</p>	<p>жил тутам АЗЗА-ын байгууллагуудын 10-аас доошгүй ИТА, мэргэжилтэй ажилчдын мэдлэг, чадварыг нь дээшлүүлсэн байх АЗЗА-ын байгууллагуудыг нормативын дагуу шаардлагатай ИТА, мэргэжилтэй ажилчдаар бүрэн хангасан байх</p>	<p>АЗЗА-ын компаниуд</p>	<p>байнга</p>
5.5	<p>Авто замын мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэж байгаа их, дээд сургууль, коллежид суралцагсдыг зам, замын байгууламжийн арчлалт, засварын чиглэлээр</p>	<p>Зам хариуцагч компаниудад</p>	<p>жил тутам 10-аас доошгүй Авто замын мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэж байгаа их, дээд сургууль,</p>	<p>АЗЗА компаниуд</p>	<p>байнга</p>

	мэргэшүүлэх талаар хамтран ажиллаж зам хариуцагч компаниудад дадлага хийлгэж байх ажлыг зохион байгуулах	дадлага хийсэн оюутнуудын тоо	колледжид суралцагсдыг зам хариуцагч компаниудад дадлага хийлгэсэн байх	Их, дээд сургууль, коллеж	
5.6	Авто замын инженер, техникч зэрэг мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудын судалгаа гаргаж тэднийг аймгууд дахь зам хариуцагч компаниудад ажиллуулахыг дэмжиж, урамшуулах арга хэмжээ авч ажиллах	Судалгаа Зам хариуцагч компаниудад очиж ажиллаж буй оюутнуудын тоо	Авто замын инженер, техникч зэрэг мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудын судалгаа гаргаж байх Авто замын инженер, техникч зэрэг мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудыг зам хариуцагч компаниудад ажиллуулахыг дэмжиж, урамшуулсан байх	АЗХ АЗЗА компаниуд	Байнга Байнга
5.7	АЗЗА-ын байгууллагуудын инженер техникийн ажилтнуудыг давтан сургах, мөргөжил дээшлүүлэх, зэрэг олгох, гадаад, дотоодын их дээд сургуульд мэргэшлийн чиглэлээр нь сургалтад хамруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	Мэргэжил дээшлүүлсэн, зэрэг авсан ИТА-ын тоо	байгууллагуудын 5-аас доошгүй инженер техникийн ажилтнуудыг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, зэрэг олгох, гадаад, дотоодын их дээд сургуульд мэргэшлийн чиглэлээр нь сургалтад хамруулсан байх	АЗБХЗГ АЗХ АЗЗА компаниуд	байнга
5.8	АЗЗА-ын байгууллагуудын ИТА-уудын цалин, урамшууллыг нэмэгдүүлж нийгмийн асуудлыг нь шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх	ИТА-уудын цалин, урамшууллын хэмжээ	АЗЗА-ын байгууллагуудын ИТА-уудын цалин, урамшууллыг нэмэгдүүлж нийгмийн асуудлыг нь шийдвэрлэсэн байх	АЗЗА компаниуд	байнга
5.9	Авто замын засвар арчлалтын мэргэжилтэй ажилчид бэлтгэх талаар мэргэжил сургалтын төв, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж тэднийг зам хариуцагч компаниудад тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх	Авто замын засвар арчлалтын мэргэжилтэй ажилчидын тоо	Авто замын засвар арчлалтын мэргэжилтэй ажилчидыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх	АЗЗА компаниуд	байнга
5.10	Авто замын засвар арчлалтын байгууллагуудын мэдээллийн системийг боловсронгуй болгох талаар дараах арга хэмжээг авч ажиллана. Үүнд: - "Авто замын орон зайн мэдээллийн санд суурилсан веб аппликейшнд улсын чанартай замын судалгааны мэдээллийг оруулах, веб аппликейшнийг мэргэжлийн, хэрэглээний түвшинд ашиглах дадлагыг бий болгох, олон улсын стандартын түвшинд нэгдсэн мэдээллийн	веб аппликейшн програм хангамж Камер програм хангамж	"Авто замын орон зайн мэдээллийн санд суурилсан веб аппликейшнийг нэвтрүүлсэн байх Авто зам хэрэглэгчдээс цахимаар замын нөхцөл байдлын мэдээллийг шуурхай авах програм хангамжийг нэвтрүүлсэн байх Авто зам, замын байгууламжийн төвөгшилтэй цэгүүдийг камержуулж,	ЗТХТ ЗТХТ ЗТХТ АЗЗА компаниуд	2021 2022 2022- 2024

127

	<p>системийг бий болгох" төсөл хэрэгжүүлж, ашиглалтад нэвтрүүлэх, - Авто зам хэрэглэгчдээс цахимаар замын нөхцөл байдлын мэдээллийг шуурхай авах програм хангамжийг хөгжүүлэх - Авто зам, замын байгууламжийн төвөгшилтэй цэгүүдийг камержуулж, нэгдсэн мэдээллийн системд холбох - Авто зам, замын байгууламжийн техник ашиглалтын түвшин тогтоох судалгааны үр дүнг авто замын орон зайн нэгдсэн мэдээллийн системд холбох - Олон улс, улсын чанартай авто замын бэлэн байдлын мэдээ авах системийг сайжруулан цаашид нэгдсэн удирдлагын төвтэй болох ажлыг шат дараатай авч хэрэгжүүлэх</p>	<p>Авто замын орон зайн нэгдсэн мэдээллийн систем</p> <p>Системийн нэгдсэн удирдлагын төв</p>	<p>нэгдсэн мэдээллийн системд холбосон байх</p> <p>Авто зам, замын байгууламжийн техник ашиглалтын түвшин тогтоох судалгааны үр дүнг авто замын орон зайн нэгдсэн мэдээллийн системд холбосон байх</p> <p>Олон улс, улсын чанартай авто замын бэлэн байдлын мэдээ авах системийн нэгдсэн удирдлагын төвтэй болсон байх</p>	<p>ЗТХТ АЗЗА компаниуд</p> <p>АЗБХЗГ ЗТХТ</p>	<p>2022-2024</p> <p>2024</p>
<p>Зургаа. Авто замын үндсэн хөрөнгийн менежментийг хэрэгжүүлж засварын ажлын хөрөнгө оруулалт түүний үр өгөөжийг нэмэгдүүлэх;</p>					
6.1	<p>Авто замын засвар арчлалтын ажлыг Замын үндсэн хөрөнгийн менежментийн систем (ЗУХМС)-д үндэслэн гүйцэтгэж засвар арчлалтын ажилд шаардлагатай хөрөнгийн хэмжээг тодорхойлж төвлөсөн оновчтой хэрэгжүүлж зам, замын байгууламжийн ашиглалтыг сайжруулан хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх</p>	<p>Замын үндсэн хөрөнгийн менежментийн систем</p>	<p>Авто замын засвар арчлалтын ажлын хөрөнгө оруулалтын үр өгөөж жил тутам 5-аас доошгүй хувиар нэмэгдсэн байх</p>	<p>АЗБХЗГ ЗТХТ</p>	<p>2022-2028</p>
6.2	<p>Олон улс, улсын чанартай авто замын сүлжээний дахин үнэлгээг хийж зам, замын байгууламжийн үнэлгээг чиглэл бүрээр нь гарган үндсэн хөрөнгийн бүртгэлд оруулан жил бүр элэгдэл, хорогдлыг тооцон, ертгийн хөдөлгөөн хийж байх ажлыг хэвшүүлэх</p>	<p>Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний тайлан</p>	<p>Олон улс, улсын чанартай авто замын сүлжээний үндсэн хөрөнгийн менежмент сайжирсан байх</p>	<p>АЗБХЗГ ЗТХТ</p>	<p>Жил тутам</p>
6.3	<p>Авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажлын хөрөнгө оруулалтын үр ашгийг тодорхой хугацаанд тооцон цаашид авах арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлж байх</p>	<p>Судалгааны тайлан</p>	<p>Авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажлын хөрөнгө оруулалтын үр ашгийг жил тутам тооцсон байх</p>	<p>АЗБХЗГ ЗТХТ</p>	<p>Жил тутам</p>
6.4	<p>Олон улс, улсын чанартай авто замаас төлбөр авах замын уртыг оновчтой тогтоож хоёр урсгалд нь төлбөр авах асуудлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх</p>	<p>Төлбөр авах цэгийн тоо</p>	<p>Олон улс, улсын чанартай авто замаас төлбөр авах замын уртыг оновчтой тогтоож хоёр урсгалд нь төлбөр авсан байх</p>	<p>ЗТХТ</p>	<p>байнга</p>

128

6.5	Авто зам ашигласны төлбөрийн одоогийн хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх	Авто зам ашигласны төлбөрийн хэмжээ	Авто зам ашигласны төлбөрийн хэмжээг 50-аас доошгүй хувиар нэмэгдүүлсэн байх	АЗБХЗГ ЗТХТ	2021-2022
6.6	Авто замын төлбөр авах цэгүүдийн байршлыг оновчтой тогтоон нэмэгдүүлж цахимжуулан хувь хүний оролцоо нөлөөллийг аль болох багасгах арга хэмжээ авах	Төлбөр авах цэгийн тоо	2020 онд - 12 цэг 2021 онд - 25 цэг 2022 онд - 4 цэг Нийт 41 цэгийн үйл ажиллагаа бүрэн цахимжсан байна	АЗБХЗГ ЗТХТ	2021-2024
6.7	Авто замын улсын байцаагчийн ногдуулсан торгууль шийтгэврийн орлогын тодорхой хэсгийг авто замын санд төвлөрүүлэх асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх	Авто замын санд төвлөрсөн орлогын хэмжээ	Авто замын улсын байцаагчийн ногдуулсан торгууль шийтгэврийн орлогын 50-аас доошгүй хувь Авто замын санд төвлөрсөн байх	ЗТХТ	2022-2028
6.8	Олон улс, улсын чанартай авто замын арчлалт, засварын ажлын хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, хяналтыг сайжруулан үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах	Хөрөнгө оруулалтын үр өгөөжийн хувь	Олон улс, улсын чанартай авто замын арчлалт, засварын ажлын хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авсан байх	АЗБХЗГ ЗТХТ	2021-2022
Долоо. Олон улс, улсын чанартай авто замын сүлжээний тэмдэгжүүлэлт, мэдээллийг тодорхой болгож замын дагуух үйлчилгээг нэмэгдүүлэн сайжруулж зам хэрэглэгчдийн тав, тухтай зорчих нөхцөл, боломжийг бүрдүүлэх					
7.1	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратегийг хэрэгжүүлэх шат дараатай арга хэмжээ авч замын тэмдэг тэмдэглэгээ, мэдээллийг оновчтой тодорхой болгож замаас хамааран гарах осол, авааргүй орчин нөхцөлийг бүрдүүлэх	Авто замаас хамааран гарах осол, аваарын тоо	Авто замаас хамааран гарах осол, аваарын тоо буурсан байх	АЗБХЗГ ЗХАБҮЗ Ажлын алба	байнга
7.2	Олон улс, улсын чанартай авто зам болон түүнээс салаалах орон нутгийн замыг тэмдэгжүүлэх арга хэмжээг нэгдсэн зохион байгуулалт, төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлж зорчигчид хаана, ямар онцлогтой замаар явж байгаа мэдээллийг авч зорьсон газраа төөрч, будлихгүйгээр хүрч байх нөхцөлийг шат дараатайгаар бүрдүүлэх	Олон улс, улсын чанартай авто зам болон орон нутгийн замын тэмдэгийн тоо	Зорчигчид зорьсон газраа төөрч, будлихгүйгээр хүрч байх нөхцөлийг бүрдүүлсэн байх	АЗБХЗГ ЗХАБҮЗ Ажлын алба	байнга
7.3	Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын нийт зурвас газрын судалгааг гарган кадастрын бүртгэлд хамруулах асуудлыг зохион байгуулж ЗТХЯ-ны эзэмшилд авах	Эзэмшлийн гэрчилгээ	Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын нийт зурвас газрыг ЗТХЯ-ны эзэмшилд авсан байх	АЗБХЗГ	2022-2024
7.4	Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын зурвас газарт үйл ажиллагаа, үйлчилгээ эрхэлж байгаа байгууллага, иргэдийн судалгаа гаргаж	Судалгааны тайлан	Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын зурвас газарт үйл ажиллагаа,	ЗТХТ	2021

129

	цаашид зурвас газрыг чөлөөлөх болон үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох зэргээр шийдвэрлэх		үйлчилгээ эрхэлж байгаа байгууллага, иргэдийн судалгааг шинэчилэн гаргасан байх			
		Чөлөөлсөн болон зөвшөөрөл олгосон зурвас газрын нэгж талбарын тоо	Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын зурвас газрыг чөлөөлөх болон үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох зэргээр шийдвэрлэсэн байх	АЗБХЗГ	2021-2022	
7.5	Авто замын зурвас газарт үйл ажиллагаа, үйлчилгээ явуулах, түүнд тавигдах шаардлага болон тодорхой хураамж тогтоох журам боловсруулж батлуулан хэрэгжүүлэх	Журам	Журам боловсруулж батлуулсан байх	АЗБХЗГ	2021	
7.6	Олон улс, улсын чанартай авто замын зурвас газарт үйл ажиллагаа, үйлчилгээ явуулах, газар эзэмшүүлэхгүй байх талаар орон нутгийн төр, захиргааны байгууллагад мэдэгдэл өгч зурвас газрыг хамгаалах, тохижуулах талаар хамтран ажиллах	Мэдэгдэл Хамтын ажиллагааны Санамж бичиг	Авто замын зурвас газрыг хамгаалах, тохижуулах талаар орон нутгийн төр, захиргааны байгууллагатай хамтран ажилласан байх	АЗБХЗГ	2021	
7.7	Зам хариуцагч байгууллагаас замын зурвас газарт ажил гүйцэтгэх үүргийг тодорхой болгож тохижуулан байнга арчлан хамгаалдаг болгох арга хэмжээ авах	Тохижуулсан зурвас газрын хэмжээ	Зам хариуцагч байгууллагаас замын зурвас газрыг тохижуулан байнга арчлан хамгаалсан байх	АЗЗА компаниуд	байнга	
7.8	Олон улс, улсын чанартай авто замын сүлжээгээр зорчигчдын тав, тухтай зорчих боломжийг бүрдүүлэх зорилгоор замын дагууд тээврийн хэрэгслийн түр зогсох талбайг үе шаттайгаар байгуулах	Түр зогсоолын тоо	Олон улс, улсын чанартай авто замын дагууд тээврийн хэрэгслийн түр зогсох талбайг байгуулах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байх	АЗБХЗГ АЗЗА компаниуд	2021-2024	
7.9	Олон улс, улсын чанартай авто замын сүлжээгээр зорчих тээврийн хэрэгслийн жолооч, зорчигчдын амрах болон машиндаа үзлэг, үйлчилгээ хийх зориулалтаар авто замын дагууд үйлчилгээний цогцолборуудыг байгуулж ажиллуулна. Үйлчилгээний цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулж ажиллуулах.	Авто замын дагууд үйлчилгээний цогцолборын тоо	Авто замын дагууд үйлчилгээний цогцолборуудыг байгуулах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байх	АЗБХЗГ АТБХЗГ	2021-2024	
7.10	Олон улс, улсын чанартай авто замын сүлжээний дагууд түр зогсох талбай болон үйлчилгээний цогцолбор байгуулж ажиллуулах журам гарган баталж хэрэгжүүлнэ	Журам	Журам боловсруулан баталж хэрэгжүүлсэн байх	АЗБХЗГ АТБХЗГ	2021	

-000-



**“ОЛОН УЛС, УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭНИЙ АРЧЛАЛТ, ЗАСВАР, АШИГЛАЛТЫГ САЙЖРУУЛЖ ЧАДАВХЫГ
БЭХЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨР”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ,
САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ТӨСӨӨЛӨЛ /2020-2024 ОН/**

№	Бодлогын зорилт	Эхлэх /дуусах огноо	Нийт төсөв /сая.₮/	Хөрөнгө оруулалт /он/, сая төгрөг					Санхүүжилт эх үүсвэр
				2020	2021	2022	2023	2024	
1	Авто замын засвар арчлалтын ажлын удирдлага, зохион байгуулалтыг тодорхой, оновчтой болгож, хяналтын тогтолцоог сайжруулах	2021-2022	4719	1147	3190	382			Улсын төсөв
2	Авто замын засвар арчлалтын ажлын стандарт, норм дүрэм, эрх зүйн орчинг боловсронгуй болгох	2021	350		350				Улсын төсөв
3	Авто замын арчлалт, урсгал засварын ажлын хөрөнгө оруулалтыг шаардлагатай хэмжээнд хүртэл нэмэгдүүлж замын ашиглалтын бэлэн байдлын түвшингээр санхүүжүүлэн зам хариуцагч компаниудын идэвх санаачилга, хариуцлагыг дээшлүүлэх.	2020-2024	392600	55000	52000	92300	94800	98500	Улсын төсөв
4	Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийн ээлжит болон их засварыг хугацааны норматив, техник ашиглалтын түвшингийн дүгнэлтэд үндэслэн үе шаттайгаар хийж хэвшүүлэх	2021-2024	504510		17248	198632	206265	82365	Улсын төсөв 299265,0 Гадаадын зээл 243105,0
5	Авто замын арчлалт, засварын ажилд шинэ техник, технологи нэвтрүүлж, АЗЗА-ын компаниудын хүчин чадлыг нэмэгдүүлж, чадавхыг бэхжүүлэх	2021-2024	66015.6		18702	16148.2	18102.3	13063.1	Улсын төсөв 40316,4 Гадаадын зээл 11,174.6
6	Авто замын үндсэн хөрөнгийн менежментийг хэрэгжүүлж засварын ажлын хөрөнгө оруулалт түүний үр өгөөжийг нэмэгдүүлэх;	2020-2024	15684	5588	6096	4000			Улсын төсөв
7	Олон улс, улсын чанартай авто замын сүлжээний тэмдэгжүүлэлт, мэдээллийг тодорхой болгож замын дагуух үйлчилгээг нэмэгдүүлэн сайжруулж зам хэрэглэгчдийн тав, тухтай зорчих нөхцөл, боломжийг бүрдүүлэх;	2021-2024	6529.2		3804	1737.6	761.4	226.2	Улсын төсөв
Нийт шаардагдах хөрөнгийн хэмжээ төгрөгөөр /сая.төгрөг/		2020-2024	990407.8	61735	101390	313199.8	319928.7	194154.3	Улсын төсөв 736128,2 Гадаадын зээл 254279,6


САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ТӨСӨӨЛӨЛ

ЭХ ХҮБЬ

Саяд Төрийн нарийн бичгийн дарга: *Р.Орво* /11/23

132

ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХАВСРАЛТ № 4



**ОЛОН УЛС, УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМЫН ДАГУУ
ЗОГСООЛ БАЙГУУЛАХ ДУНД ХУГАЦААНЫ ДЭД ХӨТӨЛБӨР**

Улаанбаатар хот
2020 он

АГУУЛГА

1. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ
2. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ
3. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО
4. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ
5. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА
6. ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА,
7. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ
8. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
9. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
10. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН
11. ХАВСРАЛТ



“ОЛОН УЛС, УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМЫН ДАГУУ ЗОГСООЛ БАЙГУУЛАХ” ДЭД ХӨТӨЛБӨР

НЭГ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ

1.1. Хууль эрх зүйн хүрээнд:

“Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд “Олон улс, улс хооронд, орон нутгийн авто замын дагуу 150-200 км тутамд үйлчилгээний цогцолбор, эрэлт хэрэгцээнд тулгуурлан тээврийн хэрэгслийг цахилгаан болон байгалийн шатах хийгээр цэнэглэх станц байгуулах” болон “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т аялал жуулчлалын гол чиглэлд зам дагуу түр буудаллах цэгүүд, боловсон ариун цэврийн байгууламжийг барьж байгуулах зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэхээр тусгасан.

Мөн Зам, тээврийн сайдын 2015 оны 339 дүгээр тушаалаар баталсан “Жолоочийн хөдөлмөр, амралтын горим, түүнийг мөрдөх тухай зөвлөмж”-ийн 3.4-т “Улс, хот хоорондын тээвэрлэлт гүйцэтгэхдээ автотээврийн хэрэгсэл жолоодож эхэлснээс хойш тасралтгүй 4 цаг хүртэл үргэлжилсний дараа 15 минутаас багагүй хугацаагаар завсарлага авч амрах үүнээс хойш 2 цаг тутамд 15 минутаас доошгүй хугацаагаар завсарлага хийж байх шаардлагатай” гэж заасныг хэрэгжүүлэх гол нөхцөл нь авто замын дагуу амрах талбайг байгуулах явдал юм.

1.2. Практик шаардлага:

“Авто зам төсөллөх” БНБД 32-01-16-ын 7.7.2-д “Амрах талбайг 50-80 км зайтай байгуулна” гэж заасан бөгөөд олон улс, улсын чанартай авто замын дагуу зогсоолыг энэхүү нормын дагуу төлөвлөөгүйгээс хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгсэл зориулалтын бус газар зогсож замын хөвөө, далан эвдрэх нөхцөл үүсэж байна.

Авто тээврийн хэрэгслийн жолоочийн ажил, амралтын дэглэмийг хангах, зорчигчдын тав тухтай аялах нөхцөлийг бүрдүүлэх, тээврийн хэрэгслийн техникийн хэвийн үйл ажиллагаа, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн стандартад нийцсэн авто замын дагуу зогсоол байгуулах нь нэн чухал байна.

Иймд олон улс, улсын чанартай авто замын дагуу 200 км тутамд баригдахаар төлөвлөгдөж байгаа үйлчилгээний цогцолборуудтай уялдуулан тэдгээрийн хооронд 100 км тутамд амрах талбай /2 чиглэлд/, 50 км тутамд түр зогсоол /2 чиглэлд/ тус бүр бие засах газар, хогийн цэг, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тэмдэг тэмдэглэгээний хамт байгуулах шаардлагатай байна.


ХОЁР. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ

2.1 Дэд хөтөлбөр нь олон улс, улсын чанартай авто замын дагуу зогсоол байгуулах үйл ажиллагаанд хамаарна.

2.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

2.2.1 Олон улс, улсын чанартай авто замын сүлжээний дагуу амрах талбай зогсоолыг нэгдсэн төлөвлөлтийн дагуу барьж байгуулах;

2.2.2 Авто тээврийн хэрэгслийн жолоочийн ажил, амралтын дэглэмийг хангах, зорчигчдын тав тухтай аялах нөхцөлийг бүрдүүлэх, тээврийн хэрэгслийн техникийн хэвийн үйл ажиллагаа, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах



2.2.3 Авто замын дагуу зогсоол байгуулах ажил нь төр хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагаанд тулгуурласан байх

ГУРАВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Жолооч болон зорчигчдод аюулгүй, ая тухтай, байгаль орчинд ээлтэй, нийгэм эдийн засгийн хувьд үр өгөөжтэй, орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн авто зам, замын байгууламжаар үйлчлэхэд энэхүү дэд хөтөлбөрийн зорилго оршино.

ДӨРӨВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ

Олон улс, улсын чанартай авто замын дагуу стандартад нийцсэн түр зогсоол, амрах талбай байгуулж, одоо байгаа авто зогсоолыг стандартад нийцүүлэн тохижуулах.

ТАВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 5.1.1. Шинээр байгуулах зогсоолуудын нэг маягийн зураг, төсвийг боловсруулж батлуулна.
- 5.1.2. Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын дагуу шинээр барих, тохижуулах авто зогсоол, амрах талбайн байршлыг тодорхойлно.
- 5.1.3. Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын дагуу 32 байршилд 780 м² талбайтай амрах талбайг шинээр барих ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 5.1.4. Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын дагуу 5 байршилд 300 м² талбайтай түр зогсоолыг шинээр барих ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 5.1.5. Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын дагуу одоо байгаа 10 авто зогсоолыг тохижуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.

Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтад үзүүлэв.

ЗУРГАА. ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

Дэд хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлнэ.

ДОЛОО. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ


- 1. Улсын төсөв
- 2. Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн хүрээнд

Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн хэмжээг 2 дугаар хавсралтад үзүүлэв. Нэг байршилд тус бүр хоёр зогсоол, амрах талбайг барихаар зардлыг тооцсон болно.

НАЙМ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг дор дурдсан шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Зорилтот түвшин			
			2021 он	2022 он	2023 он	2024 он
1	Хуучин зогсоолыг тохижуулах	цэг	7	3		
2	Шинээр байгуулах түр зогсоол	цэг			2	3
3	Шинээр байгуулах амрах талбай	цэг	21	11		




ЕС. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

- 9.1. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах ажлыг зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Авто замын асуудал хариуцсан бүтцийн нэгж хариуцна.
- 9.2. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ хийж, шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын зохион байгуулалтын бүтцийн нэгж 2 жил тутам зохион байгуулна.
- 9.3. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд үндэслэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

АРАВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН

- 10.1. Гадаад, дотоодын аялал жуулчлал хөгжих, ая тухтай орчин бий болно.
- 10.2. Орчны бохирдол багасаж байгаль орчинд эерэгээр нөлөөлнө.
- 10.3. Замын хөдөлгөөнд соёлтой, анхаарал болгоомжтой оролцох дадал эзэмшүүлнэ. Мөн жолоочийн ажил амралтын дэглэм мөрдөгдөнө.
- 10.4. Олон улсын болон улсын чанартай авто замын эвдрэл, гэмтэл багасна.
- 10.5. Эрүүл мэндийн байгууллагаас зам тээврийн осолд өртөгсдөд үзүүлдэг эмчилгээ, сувилгааны зардал багасна.
- 10.6. Зам, тээврийн осол буурч, нас баралт багасаж замын хөдөлгөөний ослоос үүдэлтэй амь нас, эрүүл мэнд, эд материалын бодит хохирлын хэмжээ буурна.

--oOo--



**“ОЛОН УЛС, УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМЫН ДАГУУ ЗОГСООЛ БАЙГУУЛАХ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа
1.	Шинээр байгуулах зогсоолуудын нэг маягийн зураг, төсвийг боловсруулж батлуула.					
1.1	Шинээр түр зогсоол амрах талбай байгуулах байршлын хөдөлгөөний эрчим болон орчны нөхцөл байдлыг тодорхойлсон судалгаа хийх	Судалгаа хийгдсэн байна	Хөдөлгөөний эрчим болон орчны нөхцөл байдлыг тодорхойлсон байна.	АЗБХЗГ	“ЗТХТ” ТӨҮГ БОАЖЯ	2020
	Нэг маягийн зураг, төсвийг боловсруулж батлуулах	ТЭЗҮ, нэг маягийн зураг төсөл	ТЭЗҮ, зураг төсөл батлагдсан байна.	АЗБХЗГ	“ЗТХТ” ТӨҮГ	2021
2.	Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын дагуу шинээр барих, тохижуулах авто зогсоол, амрах талбайн байршлыг тодорхойлно.					
2.1	Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын дагуу шинээр барих, тохижуулах авто зогсоол, амрах талбайн байршлыг тодорхойлно.	Судалгааны тайлан	Шинээр барих, тохижуулах авто зогсоолын байршлыг тодорхойлсон байна	АЗБХЗГ	“ЗТХТ” ТӨҮГ	2020
Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын дагуу амрах талбайг шинээр барих ажлыг хийж гүйцэтгэнэ.						
3.1	Улаанбаатар – Чойр чиглэлийн авто замын 172 км-т 16-р зөрлөгт амрах талбай байгуулна.	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	“ЗТХТ” ТӨҮГ АЗЗА компани	2021
3.2	Чойр-Сайншанд чиглэлийн авто замын 326 км-т Айраг суманд амрах талбай байгуулна.	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	“ЗТХТ” ТӨҮГ АЗЗА компани	2021
3.3	Замын-Үүд Сайншанд чиглэлийн авто замын 551 км-т Эрдэнэ сумын уулзвар дээр амрах талбай байгуулна.	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	“ЗТХТ” ТӨҮГ АЗЗА компани	2021
3.4	Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замын 80 км-т Ногоон довын даваанд амрах талбайн байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	“ЗТХТ” ТӨҮГ АЗЗА компани	2021
3.5	Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замын 181 км-т 90-ийн овооны орчимд амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	“ЗТХТ” ТӨҮГ АЗЗА компани	2022
3.6	Мандалговь-Даланзадгад чиглэлийн авто замын 381 км орчимд амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	“ЗТХТ” ТӨҮГ АЗЗА компани	2021
3.7	Мандалговь-Даланзадгад чиглэлийн авто замын 465 км орчимд амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	“ЗТХТ” ТӨҮГ АЗЗА компани	2022

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ ТЭВЭРИЙН ХЭТЭГЭЙН ЯАМ
ОХ ХУВЬ
Самд Төрлийн нарийн бичгийн дарга *2020.12.21*

137

3.8	Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замын 112 км Баянхангай сумын уулзварт амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2021
3.9	Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замын 222 орчимд амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2022
3.10	Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замын 326 км Л.Пүрэвдоржийн гэрэлт хөшөө орчимд амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2022
3.11	Арвайхээр-Баянхонгор чиглэлийн авто замын 539 км Сэнжитийн хоолой орчимд амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2021
3.12	Баянхонгор-Алтай чиглэлийн авто замын 722 км орчимд амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2021
3.13	Баянхонгор-Алтай чиглэлийн авто замын 922 км Дэлгэр сум орчимд амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2022
3.14	Алтай-Ховд чиглэлийн авто замын 1168 км Далан түрүү орчимд амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2021
3.15	Ховд-Өлгий чиглэлийн авто замын 1554 км Хонгион цайны газар орчимд амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2021
3.16	Ховд-Булган боомт чиглэлийн авто замын 1648 км Үенч сумын орчимд амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2021
3.17	Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 157 км Баруун хараа орчимд амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2021
3.18	Дархан-Эрдэнэт чиглэлийн авто замын 272 км Орхон Сантын гүүр орчимд амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2021
3.19	Булган-Мөрөн чиглэлийн авто замын 690 км амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2021
3.20	Улаанбаатар-Өндөрхаан чиглэлийн авто замын 190 км Хамар даваа орчимд амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2021
3.21	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн авто замын 400 км орчимд амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2021
3.22	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн авто замын 512 км Хөлөнбуйр сум орчимд амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2022
3.23	Өндөрхаан-Баруун-урт чиглэлийн авто замын 427 км Мөнххаан сум орчимд амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2021
3.24	Лүн-Дашинчилин-Ихтамир чиглэлийн авто замын 214 км Хар бухын балгас орчимд амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2021
3.25	Лүн-Дашинчилин-Ихтамир чиглэлийн авто замын 308 км Тамир гол амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2022



3.26	Цэцэрлэг-Нөмрөг чиглэлийн авто замын 580 км Чулуутын голын гүүр орчимд амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2021
3.27	Цэцэрлэг-Нөмрөг чиглэлийн авто замын 720 км орчимд амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2022
3.28	Цэцэрлэг-Нөмрөг чиглэлийн авто замын 848 км 4-н замын уулзвар орчимд амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2022
3.29	Нөмрөг-Улаангом чиглэлийн авто замын 962 км Түдэвтэй сумын уулзвар орчимд амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2021
3.30	Нөмрөг-Улаангом чиглэлийн авто замын 1096 км Өндөрхангай сумын уулзвар орчимд амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2021
3.31	Нөмрөг-Улаангом чиглэлийн авто замын 1210 км Хяргас нуурын хөвөө орчимд амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2022
3.32	Нөмрөг-Улаангом чиглэлийн авто замын 1303 км Ховд салдаг уулзвар орчимд амрах талбай байгуулна	Амрах талбай	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2022
4.	Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын дагуу түр зогсоолыг шинээр барих ажлыг хийж гүйцэтгэнэ.					
4.1	Улаанбаатар- Чойр чиглэлийн авто замын 58 км Хөндлөнгийн давааны орчимд түр зогсоол байгуулна	Түр зогсоол	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2024
4.2	Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 50 км орчимд түр зогсоол байгуулна	Түр зогсоол	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2023
4.3	Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын 200 км орчимд түр зогсоол байгуулна	Түр зогсоол	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2023
4.4	Дархан-Сүхбаатар чиглэлийн авто замын 286 км Дулаанхааны уулзвар орчимд түр зогсоол байгуулна	Түр зогсоол	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2024
4.5	Дархан-Эрдэнэт чиглэлийн авто замын 350 км орчимд түр зогсоол байгуулна	Түр зогсоол	Баригдсан байна.	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2024
5.	Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын дагуу одоо байгаа авто зогсоолыг тохижуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.					
5.1	Улаанбаатар- Чойр чиглэлийн авто замын 86 км Багахангай ЗЦХ орчимд байгаа авто зогсоолыг тохижуулна.	Тохижуулсан авто зогсоол	Тохижуулсан байна	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2021
5.2	Чойр-Сайншанд чиглэлийн авто замын 276 км Өлзийт зөрлөг орчимд байгаа авто зогсоолыг тохижуулна.	Тохижуулсан авто зогсоол	Тохижуулсан байна	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2021
5.3	Чойр-Сайншанд чиглэлийн авто замын 391 км 33-р зөрлөг орчимд байгаа авто зогсоолыг тохижуулна.	Тохижуулсан авто зогсоол	Тохижуулсан байна	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2022
5.4	Сайншанд-Замын-Үүд чиглэлийн авто замын 491 км Өргөн сумын уулзвар орчимд байгаа авто зогсоолыг тохижуулна.	Тохижуулсан авто зогсоол	Тохижуулсан байна	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2021



5.5	Сайншанд-Замын-Үүд чиглэлийн авто 609 км Нартын хошуу орчимд байгаа авто зогсоолыг тохижуулна.	Тохижуулсан авто зогсоол	Тохижуулсан байна	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2022
5.6	Мандалговь-Даланзадгад чиглэлийн авто замын 517 км орчимд байгаа авто зогсоолыг тохижуулна.	Тохижуулсан авто зогсоол	Тохижуулсан байна	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2021
5.7	Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замын 62 км Хүрэн чулуутын ар орчимд байгаа авто зогсоолыг тохижуулна.	Тохижуулсан авто зогсоол	Тохижуулсан байна	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2021
5.8	Алтай-Ховд чиглэлийн авто замын 1118 км Эввийн буудал орчимд байгаа авто зогсоолыг тохижуулна.	Тохижуулсан авто зогсоол	Тохижуулсан байна	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2021
5.9	Алтай-Ховд чиглэлийн авто замын 1393 км Манхан сумын салаа орчимд байгаа авто зогсоолыг тохижуулна.	Тохижуулсан авто зогсоол	Тохижуулсан байна	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2022
5.10	Ховд-Өлгий чиглэлийн авто замын 1608 км Толбо сум орчимд байгаа авто зогсоолыг тохижуулна.	Тохижуулсан авто зогсоол	Тохижуулсан байна	АЗБХЗГ	"ЗТХТ" ТӨҮГ АЗЗА компани	2021



140

**“ОЛОН УЛС, УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМЫН ДАГУУ ЗОГСООЛ БАЙГУУЛАХ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД
ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ТӨСӨӨЛӨЛ /2020-2024 ОН/**

№	Үйл ажиллагаа	Эхлэх/ дуусах огноо	Нийт төсөв /сая.₮/	Хөрөнгө оруулалт /он/, сая төгрөг				
				2020	2021	2022	2023	2024
1	Шинээр байгуулах зогсоолуудын нэг маягийн зураг, төсвийг боловсруулж батлуулна.	2020-2021	50.00	50.00				
2	Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын дагуу шинээр барих, тохижуулах авто зогсоол, амрах талбайн байршлыг тодорхойлно.	2020						
3	Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын дагуу амрах талбайг шинээр барих ажлыг хийж гүйцэтгэнэ.	2021-2022	4587.90		3010.81	1577.09		
4	Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын дагуу түр зогсоолыг шинээр барих ажлыг хийж гүйцэтгэнэ.	2023-2024	206.39				82.56	123.83
5	Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын дагуу одоо байгаа авто зогсоолыг тохижуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.	2021-2022	30.52			21.36	9.15	
	Дэд хөтөлбөрийн нийт зардал		4874.81	50.00	3010.81	1598.45	91.71	123.83

Шинээр барих, тохижуулах авто зогсоол, амрах талбайн нэгж үнийн тооцоо

№	Хийх ажлын төрөл	Тоо хэмжээ	Талбайн хэмжээ /м²/	Нэгж үнэ /₮/	Нийт үнэ /₮/
1	Хуучин зогсоолыг тохижуулах	20	-	1.53	30.52
2	Шинээр байгуулах түр зогсоол	10	300м²	206.40	206.40
3	Шинээр байгуулах амрах талбай	64	780м²	71.69	4,587.96
	Нэг маягийн зураг төсөл	1		50.00	50.00
	Нийт	94	52920	-	4,874.88


Жич: Нэг байршилд дээр хоёр зогсоол, амрах талбайг барих болно.

-оОо-



142

ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХАВСРАЛТ № 5



**УНАДАГ ДУГУЙН ЗОРЧИХ ОРЧИН БА ХЭРЭГЛЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ
ДУНД ХУГАЦААНЫ ДЭД ХӨТӨЛБӨР**

Улаанбаатар хот
2020 он

АГУУЛГА

1. ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ
2. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ
3. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО
4. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ
5. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА
6. ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА
7. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ
8. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
9. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
10. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨ
11. ХАВСРАЛТ

144

“УНАДАГ ДУГУЙН ЗОРЧИХ ОРЧИН БА ХЭРЭГЛЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ” ДЭД ХӨТӨЛБӨР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Практик шаардлага:

Сүүлийн жилүүдэд унадаг дугуйн хэрэглээ нэмэгдэж эдийн засгийн хэмнэлт, байгаль экологийн тэнцвэрт байдлыг бий болгох, иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах боломжийг нэмэгдүүлэх, аялал жуулчлалыг өргөжүүлэх, хот суурин газрын замын хөдөлгөөний түгжрэлийг багасгах зэрэг үр ашигтай олон боломжийг бүрдүүлж байна.

Аялал жуулчлал хөгжиж байгаа улс орнууд дугуйн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор стандартын шаардлага хангасан унадаг дугуйн зам барих төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлж эхлээд байна.


Иймд Монгол Улсад унадаг дугуйн хэрэглээг дэмжих үүднээс Улаанбаатар хот, аймаг, орон нутаг болон аялал жуулчлалын бүсийг холбосон дугуйн зам, түүний дэд бүтцийг өргөжүүлэн хөгжүүлэх хэрэгцээ шаардлага бий болж байна.

Одоогийн байдлаар Улаанбаатар хотод 84,6 км дугуйн зам байна. “Нийслэлийн авто замын сүлжээг хөгжүүлэх дунд урт хугацааны мастер төлөвлөгөө”. Улаанбаатар хотын тээврийн эрэлт хэрэгцээ явган зорчигчийг оруулан тооцвол ойролцоогоор өдөрт 3,4 сая зорчигч Улаанбаатар хотын замын хөдөлгөөнд оролцож байна. Мөн өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод 30 орчим мянган иргэн унадаг дугуйг зуны улиралд төдийгүй жилийн дөрвөн улиралд тогтмол унаж байна. Сүүлийн жилүүдэд албан байгууллагууд унадаг дугуй унах хөдөлгөөнийг дэмжиж ажиллаж байгаа бөгөөд төрийн 75 байгууллага унадаг дугуйн зогсоол байгуулсан байна.

Нийслэлийн хүн амын зорчих хөдөлгөөнийг судалсан 50000 өрхийн судалгааны үр дүнгээс тээврийн эрэлтийн бүтцийг авч үзвэл явган зорчилт 30.6%, автомашин 24.4%, такси 9.2%, автобус 33.4%, бусад тээврийн хэрэгсэл 2.6% тус тус байх ба тээврийн хэрэгслийн зорчилтын дундаж хурд 15-25 км/цаг байна.

1.2. Хууль эрх зүйн үндэслэл:

Дугуйгаар зорчигчдын эрхийг хамгаалах бодлого, журам ба тэдгээрийн хэрэгжилт Монгол улсын замын хөдөлгөөний дүрэмд “унадаг дугуйн эгнээ” гэж зорчих хэсэг дээрх унадаг дугуй, мопедын хөдөлгөөнд зориулсан, 4.4 тэмдэг бүхий эгнээг хэлнэ. Унадаг дугуйн эгнээ нь зорчих хэсгийн бусад эгнээнээс тэмдэглэлээр зааглагдсан байна. Унадаг дугуйн зам болон унадаг дугуйн эгнээ байхгүй, эсхүл түүгээр явах боломжгүй тохиолдолд зорчих хэсгийн баруун гар талын захаар байрлан явж болно,” гэж заажээ. Харамсалтай нь энэ заалтыг тээврийн хэрэгслийн жолооч тэр бүр мэддэггүйгээс унадаг дугуйгаар зорчигчидтой зорчих хэсгийг хуваалцахдаа сөрөг хандлагатай байдаг.



Улаанбаатар хотын гудамжнууд өнөөг хүртэл автомашинд зориулагдан төлөвлөгдсөөр ирсэн нь явган зорчигчдын аюулгүй зорчих эрхийг орхигдуулж байна. Ихэнх улс, орнууд хотынхоо төвд автомашингүй гудамжиндаа худалдаа, үйлчилгээний цөм бий болгож, гудамжинд явган зорчигчид, дугуйчдын эрхийг нэн тэргүүнд тавьдаг бөгөөд зөвхөн бараа хүргэлтийн машинуудыг тодорхой цагийн хязгаартай нэвтрүүлж, түргэн тусламжийн машины орц, гарцыг байнга нээлттэй байхаар дизайныг нь боловсруулсан байдаг.

Иймд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д Олон улсын стандартад нийцсэн явган хүний болон унадаг дугуйн зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж барьж байгуулан, тоосжилтыг 50 хувь бууруулах, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т Олон улсын стандартад нийцсэн унадаг дугуйн болон явган хүний зам барьж, иргэдэд ая тухтай зорчих боломжийг нэмэгдүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд энэхүү дэд хөтөлбөрийг боловсруулж байна.

ХОЁР. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ

2.1 Улсын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй өмчийн бүх хэлбэрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хамаарна.

2.2 Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

2.2.1 Дэд хөтөлбөрийн агуулга, хэрэгжилт нь нийгмийн хөгжил, орон нутгийн онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн уян хатан байх;

2.2.2 Төр хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагаанд тулгуурласан байна;

ГУРАВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Иргэдийн унадаг дугуйн хэрэглээг нэмэгдүүлэх, унадаг дугуйгаар зорчих аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэх, зорилтот аялал жуулчлалыг дэмжиж унадаг дугуйгаар аялагчдыг дэмжих, иргэдийн эрүүл хэв маягаар амьдрахад уриалах, автомашины хэрэглээг бууруулахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.


ДӨРӨВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ

Дэд хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараах үндсэн зорилтыг хэрэгжүүлнэ:

4.1. Зорилтот аялал жуулчлалыг дэмжиж аялал, жуулчлалын бүсийг холбосон унадаг дугуйн замын сүлжээг бий болгоно.

4.2. Аймаг, Нийслэлд унадаг дугуйн замын дэд бүтцийг бий болгож, хэрэглээг нэмэгдүүлнэ.

4.3. Унадаг дугуйн замын шинэ технологийг нэвтрүүлэх, аюулгүй байдлыг сайжруулна.



ТАВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

5.1. Зорилтот аялал жуулчлалыг дэмжиж аялал, жуулчлалын бүсийг холбосон унадаг дугуйн замын сүлжээг бий болгох зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:

5.1.1 Бүсчилсэн аялал жуулчлалын гол чиглэл болон цогцолбор газруудад хатуу хучилттай авто замын дагуу унадаг дугуй замын сүлжээ байгуулах

5.1.2 Дугуйн зам дагуух аялагчдад зориулсан дугуйн зам дагуу амрах цэгүүдийг байгуулах.

5.2. Аймаг, Нийслэлд унадаг дугуйн замын дэд бүтцийг бий болгож, хэрэглээг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ:

5.2.1 Шинээр болон шинэчлэн байгуулах унадаг дугуйн замын нэг маягийн зураг, төслийг боловсруулах, батлуулах;

5.2.2. Хот суурингуудад дугуйн замын дэд бүтцийн сүлжээ бий болгох, улсын болон орон нутгийн чанартай авто замын дагуух дугуйн замыг үе шаттайгаар байгуулах.

5.2.3. Дугуйн хэрэглээг нэмэгдүүлэх, түрээсийн унадаг дугуйн үйлчилгээг хөгжүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх механизмыг боловсруулах.

5.3. Унадаг дугуйн замын шинэ технологийг нэвтрүүлэх, аюулгүй байдлыг сайжруулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ:

5.3.1 Хот, суурин газруудад одоо байгаа дугуйн замын аюулгүй байдлыг сайжруулах;

5.3.2. Унадаг дугуйн замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашлага, хашилт, чиглүүлэх хэрэгсэл, зогсоолыг тэмдэгжүүлэх

5.3.3 “Унадаг дугуйн замыг төлөвлөхөд тавих ерөнхий шаардлага MNS 5683:2016” стандартыг шинэчлэн боловсруулах, аюулгүй байдал болон шинэ технологи нэвтрүүлэхтэй холбоотой стандартуудыг боловсруулж, нутагшуулах;

ЗУРГАА. ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

Дэд хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлнэ.

ДОЛОО. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

7.1. Улсын болон орон нутгийн төсөв.

7.2. Төр хувийн хэвшлийн түншлэл.

7.3. Нийгмийн хариуцлагын хүрээнд зам дагуу үйлчилгээ үзүүлж байгаа хувийн хэвшлийн оролцоотой байгуулна.

7.4. Бусад эх үүсвэр.



НАЙМ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

5.1. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг дор дурдсан шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2020 он)	Зорилтот түвшин, оноор			
				2021	2022	2023	2024
1	Шинээр барьж байгуулсан унадаг дугуйн замын урт	км	84.7	95.7	95.7	95.7	95.7
2	Унадаг дугуйн зогсоолын тоо	тоо	-	10	10	10	15
3	Шинээр бий болсон дугуйн засвар үйлчилгээний төвийн тоо	тоо	-	10	20	30	35

ЕС. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

9.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах ажлыг зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын авто замын асуудал хариуцсан нэгж, аймаг, нийслэлийн авто замын хөгжлийн асуудал хариуцсан нэгж хариуцан зохион байгуулна.


9.2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ хийж, шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын зохион байгуулалтын бүтцийн нэгж 2 жил тутам зохион байгуулна.

9.3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд үндэслэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

АРАВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН

- 4.1 Зорилтот аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 4.2 Иргэдийн эрүүл мэнд, хөдөлгөөний дутагдалд орохоос сэргийлнэ.
- 4.3 Замын хөдөлгөөний ачааллыг бууруулна.
- 4.4 Агаар, орчны бохирдлыг бууруулж байгаль орчинд эерэгээр нөлөөлөх;
- 4.5. Иргэдэд эдийн засгийн хэмнэлт бий болно.

---oOo---



**“УНАДАГ ДУГУЙН ЗОРЧИХ ОРЧИН БА ХЭРЭГЛЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ”
ДЭД ХӨТӨЛБӨР-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ТӨСӨӨЛӨЛ**

№	Бодлогын зорилго, зорилт	Эхлэх /дугсах огноо	Нийт төсөв /сая.₮/	Хөрөнгө оруулалт /он/				Санхүүжилт эх үүсвэр
				2021	2022	2023	2024	
1	Зорилт 1. Зорилтот аялал жуулчлалыг дэмжиж аялал, жуулчлалын бүсийг холбосон унадаг дугуйн замын сүлжээг бий болгох зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:							
1.1	Бүсчилсэн аялал жуулчлалын гол чиглэл болон цогцолбор газруудад хатуу хучилттай авто замын дагуу унадаг дугуй замын сүлжээ байгуулах	2021-2024	21,900.0	5,477.0	5,477.0	5,477.0	5,477.0	Улсын төсөв
1.2	Дугуйн зам дагуух аялагчдад зориулсан дугуйн зам дагуу амрах цэгүүдийг байгуулах	2021-2024						
2.	Зорилт 2. Аймаг, Нийслэлд унадаг дугуйн замын дэд бүтцийг бий болгож, хэрэглээг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ:							
2.1	Шинээр болон шинэчлэн байгуулах унадаг дугуйн замын нэг маягийн зураг, төслийг боловсруулах, батлуулах;	2021	500.0	125.0	125.0	125.0	125.0	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Хувийн хэвшил
2.2	Хот суурингуудад дугуйн замын дэд бүтцийн сүлжээ бий болгох, улсын болон орон нутгийн чанартай авто замын дагуух дугуйн замыг үе шаттайгаар байгуулах.	2021-2024	82,900.0	20,725	20,725	20,725	20,725	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Хувийн хэвшил
2.3	Дугуйн хэрэглээг нэмэгдүүлэх, түрээсийн унадаг дугуйн үйлчилгээг хөгжүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх механизмыг боловсруулах	2021	50.0	50.0	-	-	-	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Хувийн хэвшил
3.	Зорилт 3. Унадаг дугуйн замын шинэ технологийг нэвтрүүлэх, аюулгүй байдлыг сайжруулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ:							
3.1	Хот, суурин газруудад одоо байгаа дугуйн замын аюулгүй байдлыг сайжруулах;	2021-2024	1,000.0	250.0	250.0	250.0	250.0	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Хувийн хэвшил
3.2	Унадаг дугуйн замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашлага, хашилт, чиглүүлэх хэрэгсэл, зогсоолыг тэмдэгжүүлэх	2022-2023	1,000.0	250.0	250.0	250.0	250.0	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Хувийн хэвшил

МОНГОЛ УЛСЫН
ЗАР ТЭВЭГИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

ЭХ ХУВЬ

Саяд Төрлийн орчин бичгийн
Адрес: *Золотой Асар*

148

										төсөв, Хувийн хэвшил
3.3	"Унадаг дугуйн замыг төлөвлөхөд тавих ерөнхий шаардлага MNS 5683:2016" стандартыг шинэчлэн боловсруулах, аюулгүй байдал болон шинэ технологи нэвтрүүлэхтэй холбоотой стандартуудыг боловсруулж, нутагшуулах;	2021	30.0	30.0	-	-	-	-	-	Улсын төсөв
	Нийт шаардагдах хөрөнгийн хэмжээ төгрөгөөр /сая.төгрөг/	2021-2024								
	Улсын төсөв	2021-2024	30.9	7.725	7.725	7.725	7.725	7.725	7.725	
	Орон нутгийн төсөв	2021-2024	88.8	22.225	22.225	22.225	22.225	22.225	22.225	
	Гадаадын зээл, тусламж	2021-2024	-	-	-	-	-	-	-	
	Төр хувийн хэвшлийн түншлэл	2021-2024	-	-	-	-	-	-	-	
	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт	2021-2024	-	-	-	-	-	-	-	

149

8

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ ТЭВЭРЛИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

ЭХ ХУБЬ

Саяд Төрийн эрхийн бичгийн
дэргэд 2020.04.23

**“УНАДАГ ДУГУЙН ЗОРЧИХ ОРЧИН БА ХЭРЭГЛЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа
1	Зорилтот аялал жуулчлалыг дэмжиж аялал, жуулчлалын бүсийг холбосон унадаг дугуйн замын сүлжээг бий болгох зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:					
1.1.	Бүсчилсэн аялал жуулчлалын гол чиглэл болон цогцолбор газруудад хатуу хучилттай авто замын дагуу унадаг дугуй замын сүлжээ байгуулах	Норовлин сум-Дадал чиглэлд унадаг дугуйн зам /Хэнтий/ Налайх-Тэрэлж чиглэлд унадаг дугуйн зам Мөрөн-Хатгал чиглэлд унадаг дугуйн зам /Хөвсгөл/ Сүхбаатар-Алтанбулаг чиглэлд унадаг дугуйн зам /Сэлэнгэ/	58км унадаг дугуйн зам байгуулсан байна. 33км унадаг дугуйн зам байгуулсан байна. 97км унадаг дугуйн зам байгуулсан байна. 28км унадаг дугуйн зам байгуулсан байна. 10 унадаг дугуйн зогсоол байгуулсан байна. 10 унадаг дугуйн зогсоол байгуулсан байна 15 унадаг дугуйн зогсоол байгуулсан байна 10 унадаг дугуйн зогсоол байгуулсан байна	ЗТХЯ ЗТХЯ ЗТХЯ ЗТХЯ	БОАЖЯ Аймаг, нийслэлийн засаг дарга БОАЖЯ Аймаг, нийслэлийн засаг дарга ҮХГ Аймаг, нийслэлийн засаг дарга БОАЖЯ Аймаг, нийслэлийн засаг дарга	2021-2024 2021-2024 2021-2024 2021-2024
1.2.	Дугуйн зам дагуух аялагчдад зориулсан дугуйн зам дагуу амрах цэгүүдийг байгуулах	Норовлин сум-Дадал чиглэлд унадаг дугуйн зам /Хэнтий/ Налайх-Тэрэлж чиглэлд унадаг дугуйн зам Мөрөн-Хатгал чиглэлд унадаг дугуйн зам /Хөвсгөл/ Сүхбаатар-Алтанбулаг чиглэлд унадаг дугуйн зам /Сэлэнгэ/				
2	Аймаг, Нийслэлд унадаг дугуйн замын дэд бүтцийг бий болгож, хэрэглээг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ.					
2.1.	Шинээр болон шинэчлэн байгуулах унадаг дугуйн замын нэг маягийн зураг, төслийг боловсруулах, батлуулах;	ТЭЗҮ зураг төслийг боловсруулах	Зураг төсөл боловсруулж батлуулсан байна.	ЗТХЯ	Аймаг, нийслэлийн засаг дарга, “ЗТХТ” ТӨҮГ	2021-2024

ЭХ ХҮБЬ

Саяд Төрвийн зорилго бүхий
дүрэм /2020/ №231

2.2.	Хот суурингуудад дугуйн замын дэд бүтцийн сүлжээ бий болгох, улсын болон орон нутгийн чанартай авто замын дагуух дугуйн замыг үе шаттайгаар байгуулах.	Улаанбаатар хот	165км	Аймаг, нийслэлийн засаг дарга	"ЗТХТ" ТӨҮГ	2021-2024
		Дархан-Уул аймаг	13км			
		Өвөрхангай аймаг	2км			
		Төв аймаг	51км			
		Дорнод аймаг	21км			
		Баян-Өлгий аймаг	7км			
		Өмнөговь аймаг	20км			
		Сүхбаатар аймаг	9км			
		Дундговь аймаг	3км			
		Завхан аймаг	12км			
Хэнтий аймаг	8км					
2.3.	Дугуйн хэрэглээг нэмэгдүүлэх, түрээсийн унадаг дугуйн үйлчилгээг хөгжүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх механизмыг боловсруулах	1. Унадаг дугуйн хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр санхүүгийн дэмжлэг үзүүлэх механизмыг бий болгоно.	Судалгаа хийгдсэн байна	ЗТХЯ	"ЗТХТ" ТӨҮГ	2021-2024
		2. Аймаг, Нийслэлд унадаг дугуйн түрээсийн үйлчилгээг хөгжүүлнэ.				
3	Унадаг дугуйн замын шинэ технологийг нэвтрүүлэх, аюулгүй байдлыг сайжруулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ.					
3.1.	Хот, суурин газруудад одоо байгаа дугуйн замын аюулгүй байдлыг сайжруулах;	Аюулгүйн байдлыг хангасан тэмдэг, тэмдэглэгээгээр тоноглох	300	Аймаг, нийслэлийн засаг дарга	"ЗТХТ" ТӨҮГ	2021-2024
3.2.	Унадаг дугуйн замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашлага, хашилт, чиглүүлэх хэрэгсэл, зогсоолыг тэмдэгжүүлэх	Хот, суурин газрын дугуйн замын сүлжээний огцом эргэлт, огцом өгсүүр, уруудах хэсгүүдэд аюулгүйн саадыг арилгах	300	Аймаг, нийслэлийн засаг дарга	"ЗТХТ" ТӨҮГ	2021-2024
3.3.	"Унадаг дугуйн замыг төлөвлөхөд тавих ерөнхий шаардлага MNS 5683:2016" стандартыг шинэчлэн боловсруулах, аюулгүй байдал болон шинэ технологи нэвтрүүлэхтэй холбоотой стандартуудыг боловсруулж, нутагшуулах;	1. Олон улсад мөрдөгддөг унадаг дугуйн технологийн стандартын талаар судлана. 2. "Унадаг дугуйн замыг төлөвлөхөд тавих ерөнхий шаардлага MNS 5683:2016" стандартыг шинэчлэн төсөл боловсруулах.	"Унадаг дугуйн замыг төлөвлөхөд тавих ерөнхий шаардлага MNS 5683:2016" стандартыг шинэчлэн боловсруулж батлуулсан байна.	ЗТХЯ	"ЗТХТ" ТӨҮГ	2021

---000---



ЕРӨНХИЙ ЗОРИУЛАЛТЫН НИСЭХИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөр боловсруулах үндэслэл, өнөөгийн байдал

1.1. Эрх зүйн үндэслэл

Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-д “Ерөнхий зориулалтын агаарын тээврийг хөгжүүлэх” зорилтыг тодорхойлсон.

Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Гадаад, дотоод худалдааны тээврийн зардлыг бууруулах, хугацааг багасгах, аймаг болон томоохон сумдын нисэх буудлыг хөгжүүлэх, ерөнхий зориулалтын агаарын тээврийг хөгжүүлэх, Хөшигийн хөндийн олон улсын нисэх буудлыг барьж дуусгах” гэж тодорхойлсон.

Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Жижиг нисэх онгоц, нисдэг тэрэгний зах зээлийг хөгжүүлж, гамшгаас хамгаалах, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн түргэн тусламжийн үйлчилгээ, иргэний агаарын тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр ашиглана.” гэсэн зорилтыг тусгасан.

Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаанд иргэний нисэхийн 9 багц дүрмийг мөрдөж байгаа ч хуулиар тодорхой зохицуулаагүй тул ерөнхий зориулалтын нисэхийн эрх зүйн орчныг хуульчлах шаардлагатай байна.

Манай улс Гаалийн тариф, гаалийн татварын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулиар зөвхөн зорчигч тээврийн агаарын хөлөг, түүний сэлбэгийг татвараас чөлөөлж байгааг өөрчилж, ерөнхий зориулалтын агаарын хөлөг, тэдгээрийн сэлбэгийг мөн татвараас чөлөөлөх, хөнгөлөх эрх зүйн орчныг бүрдүүлснээр тус салбарын хөгжлийг дэмжих чухал алхам болно.

1.2. Өнөөгийн байдал

Ерөнхий зориулалтын нисэхийн салбарыг уул уурхайн компанийн захиалгат нислэг, агаараас зураг авалт, эмнэлгийн яаралтай тусламж, зам, тээврийн сүлжээний эргүүл, хяналт, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх эргүүл, эрэн хайх, авран туслах ажиллагаа, хөдөө аж ахуй, хортон шавьж устгал, ан амьтны тооллого, тэдгээрийн нүүдэл, суурьшлын судалгаа, цаг агаарын тандалт, судалгаа, агаар, хүрээлэн буй орчны тандалт, аялал жуулчлал, эйр такси, бизнесийн болон хувийн нислэг зэрэг олон чиглэлээр хөгжүүлэх нь нийгэм, эдийн засгийн чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсад ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх бодлогыг тодорхойлж, эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх, дэд бүтэц барьж байгуулах ажлууд эхлэл төдий байна.

Энэ салбарыг өргөжүүлэн хөгжүүлэхийн тулд эрх зүйн орчинг боловсронгуй болгох, дэд бүтцийг сайжруулах, нисэгч, инженер, техникийн ажилтан бэлтгэх, агаарын хөлгийн засвар үйлчилгээ, шатахуун хангамжийн сүлжээг бүрдүүлэх зэрэг Монгол орны газар нутаг, нийгэм, эдийн засгийн бүхий л салбарыг хамарсан өргөн хүрээний бодлого, үйл ажиллагаа хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Иргэний нисэхийн салбарт 7 аж ахуйн нэгж, хувь хүн бага оврын нийт 17 агаарын хөлөг, нисдэг тэрэг улирлын чанартай үйл ажиллагаа явуулж, нисэгч бэлтгэдэг 1 хувийн нисэх клуб ажиллаж байна.

Өнөөгийн байдлаар орон нутгийн нисэх буудлууд ерөнхий зориулалтын агаарын хөлгийн шатахууныг хангаж байгаа бөгөөд орон нутагт байнгын ажиллагаатай 10, нөөц 12 нисэх буудал байгаагийн 19 нь Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяанд, 3 нь хувийн нисэх буудал байна.

Томоохон сум, суурин газарт ашиглаж байсан нислэгийн зурвас, хөдөө аж ахуйн болон захиалгат нислэгийн хөөрч буух зурвас, талбайн нийт 116 байршлыг судлан тогтоосон. Эдгээр байршилд техникийн засвар, үйлчилгээ, шатахуун хангамжийн сүлжээ, хамгаалалтын зурвас, хашаа байгуулж, тэмдэг, тэмдэглэгээ хийж нислэгийн аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаснаар ерөнхий зориулалтын дэд бүтцийн сүлжээг бий болгох боломжтой юм.

Манай улстай хүн амын тоо ойролцоо буюу 4.7 сая хүн амтай, газар нутгийн хэмжээгээр манайхаас 15 дахин бага Шинэ-Зеланд Улсад 4900 гаруй ерөнхий зориулалтын агаарын хөлгөөр ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа явуулж байна.

Ерөнхий зориулалтын нисэхийн үйлдвэрлэгчдийн холбооны судалгаагаар 2016 оны жилийн эцсийн байдлаар дэлхий даяар 416.0 мянга гаруй ерөнхий зориулалтын агаарын хөлөг ашиглаж байна. Эдгээрээс АНУ-д 210.0 мянга, Европын Холбооны нутаг дэвсгэр дээр 140.0 мянга гаруй ерөнхий зориулалтын агаарын хөлөг нислэг үйлдэж, 1.1 сая ажлын байр бий болгож, дэлхийн эдийн засагт 219.0 тэрбум доллар оруулсан гэсэн тооцоо, судалгаа гарчээ.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Ерөнхий зориулалтын нисэхийн эдийн засаг, эрх зүйн орчныг бүрдүүлэх, дэд бүтцийн сүлжээг бий болгох, төр, хувийн хэвшлийн түншлэл, хувийн хэвшил, иргэдийн оролцоог дэмжих, салбар хоорондын уялдааг хангах замаар ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлж, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд бодит үр нөлөө үзүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна:

2.2.1. ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх эдийн засаг, эрх зүйн орчныг бүрдүүлэх;

2.2.2. ерөнхий зориулалтын нисэхийн дэд бүтцийг хөгжүүлэх, нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх;

2.2.3. ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах агаарын зайн зохицуулалт, аюулгүй ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулах;

2.2.4. ерөнхий зориулалтын нисэхийн салбарын хүний нөөцийг бэлтгэх тогтолцоог бүрдүүлэх;

2.2.5. бага оврын агаарын хөлгийн үйлдвэрлэл, засвар, үйлчилгээний сүлжээг бий болгох;

2.2.6. ерөнхий зориулалтын агаарын хөлгийн шатахуун хангамжийн сүлжээг бий болгох;

2.2.7. иргэд хувийн хэрэгцээндээ агаарын хөлөг ашиглахыг дэмжин хөгжүүлэх.

Гурав. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх эдийн засаг, эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд:

3.1.1. Иргэний нисэхийн тухай хууль болон Иргэний нисэхийн багц дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулж ерөнхий зориулалтын нисэхийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

3.1.2. ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, үнэмлэхжүүлэх, нислэгийн захиалга, төлөвлөлтийг хялбаршуулах, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний дүрэм, журмыг боловсронгуй болгох;

3.1.3. холбогдох төрийн байгууллага болон ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч, бусад оролцогчийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны шаардлага, эрх, үүрэг, хариуцлагын тогтолцоог бий болгох;

3.1.4. ерөнхий зориулалтын нисэхийн агаарын хөлөг ашиглах төрийн байгууллага болон салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах;

3.1.5. ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэхэд түрээс, хөнгөлөлттэй зээл зэрэг санхүү, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

3.1.6. иргэд хувийн хэрэгцээндээ зориулан агаарын хөлөг, нисдэг тэрэг авч ашиглахад татварын дэмжлэг үзүүлэх асуудлыг судлан шийдвэрлүүлэх;

3.1.7. ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах газрын хэмжээ, байршлыг орон нутгийн эрх бүхий байгууллагатай хамтран тогтоож, газрын төлбөрийн хэмжээг бууруулах, чөлөөлөх зохицуулалтыг бий болгох асуудлыг судлан шийдвэрлүүлэх;

3.1.8. ерөнхий зориулалтын агаарын хөлгөөр алслагдсан сум, суурин газарт агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бий болгох.

3.2. Ерөнхий зориулалтын нисэхийн дэд бүтцийг хөгжүүлэх, нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

3.2.1. Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг ашиглалтад оруулж, "Чингис хаан" олон улсын нисэх буудлыг нүүлгэн шилжүүлсний дараа одоогийн нисэх буудлын барилга байгууламжийн зохих хэсгийг ерөнхий зориулалтын нисэхийн төв болгон өөрчлөн зохион байгуулах;

3.2.2. орон нутаг дахь ашиглагдахгүй болсон нисэх буудал, агаарын хөлөг хөөрч, буух зурвас, талбайг сэргээн сайжруулж, ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах;

3.2.3. барилга байгууламжийн дээвэр, хот, суурин газрын талбайд вертодром байгуулах, ашиглах үйл ажиллагааны норм, стандартыг баталж, хэрэгжүүлэх;

3.2.4. хот, суурин газар, суурьшлын бүсэд нийтийн хэрэгцээнд ашиглах вертодром байгуулах;

3.2.5. ерөнхий зориулалтын агаарын хөлөг хөөрч, буух зурвас, вертодром барьж байгуулахад улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэл болон хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих.

3.3. Ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах агаарын зайн зохицуулалт, аюулгүй ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулах зорилтын хүрээнд:

3.3.1. ерөнхий зориулалтын нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний үүрэг, хариуцлагыг боловсронгуй болгох;

3.3.2. ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаанд ашиглах агаарын зайн зохицуулалтыг сайжруулах, ашиглалтыг хялбаршуулах;

3.3.3. хяналтгүй агаарын зайн мэдээллийг хэрэглэгчид мэдээлэх тогтолцоог бий болгох, холбогдох баримт бичиг, гарын авлагаар хангах;

3.4. Ерөнхий зориулалтын нисэхийн салбарын хүний нөөцийг бэлтгэх тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд:

3.4.1. хувийн нисэгч бэлтгэх анхан шатны сургалтын тогтолцоог бүрдүүлж, улмаар ерөнхий зориулалтын нисэхийн дэд бүтцэд суурилсан, олон улсын стандарт шаардлага хангасан, бүс нутгийн хэмжээнд сургалт зохион байгуулах хүчин чадал бүхий сургалтын төв байгуулах;

3.4.2. Ерөнхий зориулалтын агаарын хөлгийн нисэгч, инженер, техникийн ажилтныг гадаад, дотоодод бэлтгэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

3.4.3. Хувийн нисэх клуб, сургалтын байгууллагыг дэмжих.

3.5. Бага оврын агаарын хөлгийн үйлдвэрлэл, засвар, үйлчилгээний сүлжээг бий болгох зорилтын хүрээнд:

3.5.1. олон улсын иргэний нисэхийн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, өөрийн орны нөхцөлд тохирсон бага оврын агаарын хөлөг угсрах, үйлдвэрлэхэд урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл болон бусад төрлийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг судлан шийдвэрлүүлэх;

3.5.2. бага оврын агаарын хөлөг угсрах, үйлдвэрлэх, туршилт баталгаажуулалт хийх, засвар, үйлчилгээний төвүүд байгуулах;

3.5.3. томоохон хот, суурин газар, орон нутагт ерөнхий зориулалтын агаарын хөлгийн засвар, үйлчилгээний төв байгуулахыг дэмжиж, сүлжээ бий болгох;

3.5.4. агаарын хөлгийн сэлбэг, тоног төхөөрөмжийн хангамж, үйлчилгээний сүлжээ бий болгох.

3.6. Ерөнхий зориулалтын агаарын хөлгийн шатахуун хангамжийн сүлжээг бий болгох зорилтын хүрээнд:

3.6.1. ерөнхий зориулалтын агаарын хөлөгт ашиглах авгаз болон бусад төрлийн шатахууныг олон эх үүсвэрээс нийлүүлэх боломж бүрдүүлэх;

3.6.2. томоохон хот, суурин газар, орон нутагт ерөнхий зориулалтын агаарын хөлгийн шатахуун хангамжийн сүлжээ байгуулахыг дэмжих.

3.7. Иргэд хувийн хэрэгцээндээ агаарын хөлөг ашиглахыг дэмжин хөгжүүлэх зорилтын хүрээнд:

3.7.1. иргэний хувийн хэрэгцээнд ашиглах бага оврын агаарын хөлөг, нисдэг тэрэгт тавигдах стандарт, шаардлагыг тогтоож, холбогдох эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

3.7.2. агаарын хөлөг худалдан авах, түрээслэхэд урт хугацаатай хөнгөлөлттэй зээл болон бусад төрлийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг судлан шийдвэрлүүлэх;

3.7.3. хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэх агаарын хөлгийн холбоо, навигацийн төхөөрөмжийн шаардлагыг боломжит хамгийн бага түвшинд байлгах зохицуулалтыг хийх.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт

4.1. Хөтөлбөрийг 2018-2022 онд хэрэгжүүлнэ.

4.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

4.2.1. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтыг хэрэгжүүлснээр ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх эрх зүйн зохицуулалт сайжирч, аж ахуйн нэгж, иргэд ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдэнэ.

4.2.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтыг хэрэгжүүлснээр бага оврын агаарын хөлгийн хөөрч буух зурвас, вертодромын тоо нэмэгдэж, аялал жуулчлал, уул уурхай, бизнесийн нислэг болон эйр такси үйлчилгээ өргөжиж, эдийн засагт иргэний нисэхийн салбарын үзүүлэх бодит үр ашиг өснө.

4.2.3. Хөтөлбөрийн 3 дугаар зорилтыг хэрэгжүүлснээр ерөнхий зориулалтын нислэгийн агаарын зайн зохион байгуулалт, зохицуулалт сайжирч, эрх зүйн орчин боловсронгуй болно.

4.2.4. Хөтөлбөрийн 4 дүгээр зорилтыг хэрэгжүүлснээр ерөнхий зориулалтын нисэхийн дэд бүтцэд суурилсан, олон улсын стандарт, шаардлагыг хангасан, бүс нутгийн хэмжээнд сургалт зохион байгуулах, хүний нөөцийг бэлтгэх тогтолцоо бүрдэнэ.

4.2.5. Хөтөлбөрийн 5 дугаар зорилтыг хэрэгжүүлснээр дотоодод бага оврын агаарын хөлөг угсралт, үйлдвэрлэл хөгжиж, засвар, үйлчилгээний сүлжээ өргөжин хөгжих нөхцөл бүрдэнэ.

4.2.6. Хөтөлбөрийн 6 дугаар зорилтыг хэрэгжүүлснээр ерөнхий зориулалтын агаарын хөлгийн шатахуун хангамжийн сүлжээ бий болно.

4.2.7 Хөтөлбөрийн 7 дугаар зорилтыг хэрэгжүүлснээр иргэд хувийн хэрэгцээнд агаарын хөлөг авч ашиглах, тээвэрлэлтийн эрэлт хэрэгцээгээ хангах боломж бүрдэж, хувь хүн төдийгүй хувийн хэвшлийн бизнесийн нислэг өргөжиж, орчин үеийн үйлчилгээний шинэ төрлүүд бий болно.

158

4.3. Хөтөлбөрийн үр дүнг дараах үндсэн шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Шалгуур үзүүлэлт	Нэгж	Суурь түвшин		Зорилгот түвшин
			2018	2022	
1.	Гадаад, дотоодын болон хувийн хөрөнгө оруулалт	сая. төг	1,025.0		10,000.0
2.	Ерөнхий зориулалтын агаарын хөлгийн нисэгч	тоо	31		100
3.	Бага оврын агаарын хөлөг	тоо	17		35
4.	Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, онцгой байдлын үед ашиглах хөөрч, буух зурвас, вертодром	тоо	3		10
5.	Байнгын болон түр хөөрч, буух зурвас, вертодром, аэродром	тоо	20		116
6.	Хяналтгүй агаарын зайд үйлдэх нислэг	цаг	125		800
7.	Алслагдсан сумдын чиглэлд үйлдэх нислэг	цаг	176		3500
8.	Уул уурхайн нислэг	тоо	1130		2850
9.	Бэлтгэх хүний нөөц	тоо	8		130
10.	Сургалтын байгууллага	тоо	13		25
11.	Агаарын хөлгийн засвар, үйлчилгээний төв	тоо	12		60
12.	Агаарын хөлгийн шатахуун хангамжийн төв	тоо	3		30
13.	Хувийн нисэгчийн үнэмлэх эзэмшигч	тоо	17		150

4.4. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн зорилтот түвшинг жил бүр шалгуур үзүүлэлт бүрээр тогтооно.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.1.1. улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

5.1.2. хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, хандив, тусламж;

5.1.3. олон улсын байгууллага, гадаадын зээл, тусламж болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

5.1.4. бусад.

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

6.1. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

6.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжид үндэслэн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах болон шаардлагатай бусад арга хэмжээ авна.

АГААРЫН ТЭЭВРИЙН ЗАЙЛШГҮЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсад 1925 онд нисэх хүчин анх үүсч, улмаар батлан хамгаалах салбар болон улсын хөгжил, нийгмийн амьдралд бодитой хувь нэмрийг оруулсаар ирсэн бөгөөд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1956 оны 272 дугаар тогтоолоор тээврийн нислэгийг эхлүүлэх бэлтгэлийг хангуулан, Иргэний агаарын тээврийн талаар ЗХУ-тай байгуулсан гэрээний дагуу Улаанбаатар, Сайншандын нисэх онгоцны буудлын тоног төхөөрөмж, хэрэгсэл, ИЛ-14 онгоц 5-ыг хүлээн авснаар 15 аймгийн төвийг нийслэлтэй, 300 орчим сум, бригадын төвийг аймгийн төвтэй агаарын тээврээр холбож байжээ.

1980 оны эхэн үеэс 1990 он хүртэл иргэний агаарын тээврийн салбарын үйл ажиллагааны оргил үе байсан бөгөөд хот хооронд АН-24 онгоц 17, ачааны АН-26 онгоц 4, орон нутгийн тээвэрт АН-2 онгоц 24, авиахимийн ажилд АН-2 онгоц 20-ийг тус тус ашиглаж, жилд 820000 зорчигч тээвэрлэж, 2.0 сая гаруй га газарт авиахимийн ажил хийж байсан байна.

1990 оноос 2004 оныг хүртэл "МИАТ" ХК иргэдэд орон нутгийн агаарын тээврийн үйлчилгээг бага тарифаар үзүүлж, жил бүр 2.0-3.0 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан. 2004 онд АН-24 агаарын хөлгүүдийн ашиглалтын хугацаа дууссанаар Тосонцэнгэл, Цэцэрлэг, Булган, Тэшиг, Арвайхээр, Мандалговь, Баруун-Урт, Өндөрхаан чиглэлд нислэг зогссон байна. Өнөөдрийн байдлаар хувийн хэвшлийн 2 агаарын тээвэрлэгч 8 аймаг руу хуваарьт болон хуваарьт бус нислэг үйлдэж байна.

Өргөн уудам нутагтай, хүн ам сийрэг суурьшсан, нэг хүнд ногдох үндэсний нийт орлого багатай манай орны хувьд иргэний агаарын тээвэр улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд онцгой ач холбогдолтой бөгөөд алслагдсан бүс нутгийг холбох, иргэдийн суурьшил, орлогын түвшинг үл харгалзан төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд агаарын тээвэр чухал шаардлагатай байгаа хэдий ч орон нутгийн агаарын тээврийг хөгжүүлэхэд дараахь асуудлууд тулгамдаж байна:

- орон нутагт агаарын тээврийн үйлчилгээний хүртээмж буурснаар иргэд богино хугацаанд Улаанбаатар хот руу ирж, очих, эрүүл мэндийн яаралтай тусламж, үйлчилгээ авах боломж хангагдахгүй байна;
- агаарын хөлгийн нислэгийн зардал өндөр, зардлын дийлэнх хувь нь гадаад валютаар хийгддэгээс агаарын тээвэрлэгчид орон нутагт шинэ чиглэл нээх, нислэгийн давтамжийг нэмэгдүүлэх боломжгүй болж, хөрөнгө оруулагчдын хувьд орон нутгийн нислэгийн бизнес ашиггүй, өндөр өртөгтэй тул зорчигч урсгал багатай чиглэлд нислэг гүйцэтгэхээс зайлсхийж байна;
- орон нутгийн нислэгийн тийзний үнэ иргэдийн дундаж цалин хөлсний 50-70 орчим хувийг эзэлж байгаагаас нэн яаралтайгаас бусад тохиолдолд авто тээврийг сонгон үйлчлүүлж байна;
- Монгол Улсад ирэх зорчигч болон жуулчид орон нутаг руу шууд дамжин нисэх боломж хомс тул жуулчдын тоо нэмэгдэхгүй байх нэг хүчин зүйл болж байна;

- хүн амын дийлэнх хувь нь Улаанбаатар хотод төвлөрч, орон нутагт сийрэг суурьшсан, бүс нутгийн хөгжил муу манай орны хувьд орон нутгийн агаарын тээврийн үйлчилгээг алслагдмал бүс нутгийн иргэдэд, аюулгүй, эдийн засгийн үр ашигтай, хүртээмжтэй байдлаар зохион байгуулах шаардлагатай байна;
- хуваарьт нислэг зогсох нь төрийн зайлшгүй үйлчилгээг орон нутгийн иргэдэд хүртээмжтэй хүргэх боломжгүй байдал үүсгэж байгаа тул зарим аймаг руу нөхөн олговортой нислэг үйлдэх, зорилтот бүлгийн иргэдэд нислэгийн тийзний хөнгөлөлт үзүүлэх шаардлагатай байна;

Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-д дотоодын агаарын тээврийн үйлчилгээг алслагдсан бүс орон нутгийн иргэдэд хүргэхэд чиглүүлэх болон төрөөс алслагдсан бүс нутаг агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэх “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”-ийг боловсруулж хэрэгжүүлэх зорилтыг тус тус дэвшүүлсэн байна. Түүнчлэн Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.118-д “Төрөөс агаарын тээврийн салбарт баримтлах бодлогод тулгуурлан орон нутгийн болон олон улсын нислэгийн тоог нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжих замаар тус салбарт үнэ тарифыг бууруулна” гэж заасан нь “Агаарын тээврийн үйлчилгээний зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр” (цаашид “хөтөлбөр” гэх)-ийг боловсруулах үндэслэл болж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Алслагдсан аймаг руу хийх хуваарьт нислэгийн үйлчилгээг сэргээн тогтворжуулан иргэдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн агаарын тээврийн үйлчилгээг үзүүлж, төрөөс үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, агаарын тээвэрлэгч эдийн засгийн үр ашигтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд энэ хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараахь зорилтыг дэвшүүлж байна:

2.2.1. орон нутгийн агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээнд хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

2.2.2. орон нутгийн нислэгийг үе шаттайгаар сэргээн тогтворжуулах;

2.2.3. зорилтот бүлгийн иргэд (ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй болон эрүүл мэндийн яаралтай тусламж, үйлчилгээ авах шаардлагатай иргэн, 18 хүртэлх насны хүүхэд) орон нутгийн нислэгээр хөнгөлөлттэй үнээр зорчих тогтолцоо бүрдүүлэх.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, үе шат

3.1. Хөтөлбөрийг 2019-2023 оны хооронд дараахь үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

3.1.1. I үе шат-2019-2020 он;

3.1.2. II үе шат-2021-2023 он.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. Орон нутгийн агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээнд хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.1. орон нутгийн агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээ, түүнд хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

4.1.2. иргэний нисэхийн салбарын хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээг хөгжүүлэх зорилт, үйл ажиллагааг тодорхойлох;

4.1.3. орон нутгийн агаарын тээврийн үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжих нөхцөл, боломжийг бүрдүүлэх;

4.1.4. агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалтын дүрэм, журамд орон нутгийн агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний зохицуулалтыг тусгах;

4.1.5. орон нутгийн нислэгийг зохих нөхөн олговор (татаас) олгох нөхцөлтэйгээр гүйцэтгүүлэх зохицуулалтыг бий болгох;

4.1.6. агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээг иргэдэд сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах;

4.2. Орон нутгийн нислэгийг үе шаттайгаар сэргээн тогтворжуулах зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.2.1. иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нислэгийн чиглэл, давтамж, эдийн засгийн тооцоо, судалгаанд үндэслэн агаарын тээвэрлэгчийн нислэгийн алдагдлыг тооцож, нөхөн олговрын хэмжээг тогтоох зохицуулалтыг бий болгох;

4.2.2. зорчигчийн тийзний үнийг тухайн орон нутгийн хүн амын худалдан авах чадварыг харгалзан уян хатан тогтоох;

4.2.3. орон нутгийн хүн амын суурьшил, байршлын онцлог, алслагдмал байдал, зорчигч болон жуулчдын эрэлт хэрэгцээнд үндэслэн нислэг зогссон, өрсөлдөх боломжгүй чиглэлд зохих нөхөн олговор олгох нөхцөлтэйгөөр нислэг гүйцэтгүүлэх тогтолцоог бүрдүүлэх;

4.2.4. орон нутгийн агаарын тээврийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, чөлөөт өрсөлдөөнийг дэмжих үүднээс нөхөн олговортой нислэг гүйцэтгэх агаарын тээвэрлэгчийг ижил тэгш хамруулах нөхцөлийг бүрдүүлэх;

4.2.5. алслагдсан бүс, орон нутгийн нисэх буудлыг мэргэжлийн хүний нөөц, барилга, байгууламж, тоног төхөөрөмжөөр хангаж, тэдгээрийн ашиглалтад хяналт тавьж, бэлэн байдлыг хангах;

4.2.6. орон нутгийн нисэх буудал болон онцгой байдал, цагдаа, эмнэлэг, холбогдох бусад байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах.

4.3. Зорилтот бүлгийн иргэд орон нутгийн нислэгээр хөнгөлөлттэй үнээр зорчих тогтолцоо бүрдүүлэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.3.1. зорилтот бүлгийн иргэдэд хөнгөлөлттэй тийз олгох зохицуулалтыг бий болгох;

4.3.2. дотоодын агаарын тээвэрлэгчдийн орон нутгийн хуваарьт нислэг бүрийн тодорхой тооны суудлыг зорилтот бүлэгт зориулах журмыг баталж, мөрдүүлэх;

4.3.3. зорилтот бүлгийн иргэдэд олгох тийзний үнийг 80 хүртэл хувиар хөнгөлөх нөхцөлийг бүрдүүлэх.

Тав. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

5.1.1. орон нутгийн агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний эрх зүйн зохицуулалт бий болно;

5.1.2. агаарын тээвэрлэгчдийн үйл ажиллагааг дэмжих эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдэнэ;

5.1.3. орон нутгийн агаарын тээвэрт хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалт нэмэгдэнэ;

5.1.4. орон нутгийн агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний талаар эдийн засгийн зохицуулалтын дүрэм, журамтай болсон байна;

5.1.5. иргэд агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний талаарх мэдээлэлтэй болж, үйлчлүүлж хэвшинэ;

5.1.6. орон нутгийн хуваарьт нислэг тогтворжиж, агаарын тээврийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ;

5.1.7. дотоодын агаарын тээвэрлэгчдийн өрсөлдөх чадвар нэмэгдсэн байна;

5.1.8. зорилтот бүлгийн иргэдэд агаарын тээврийн үйлчилгээг хямд үнээр үзүүлэх боломж бүрдэнэ.

5.2. Хөтөлбөрийн үр дүнг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2018 он)	Зорилтот түвшин (2020)	Зорилтот түвшин (2023 он)
1.	Эрх зүйн акт	1	2	4
2.	Дотоодын агаарын тээвэрлэгчид олгосон нөхөн олговрын хэмжээ (төгрөг)	431.0 сая	2.1 тэрбум	10.4 тэрбум

3.	Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээг сурталчлан таниулсан аймгийн тоо	0	4	10
4.	Нислэг сэргээсэн чиглэлийн тийзний үнийн бууралтын хувь	0	50	50
5.	Зорилтот бүлгийн зорчигчийн тийзний үнийн бууралтын хувь	0	80	80
6.	Зорилтот бүлгийн зорчигчийн тоо	0	7280	21840
7.	Орон нутгийн нислэгийн чиглэлийн тоо	8	12	12
8.	Тогтмол нислэгтэй орон нутгийн нисэх буудлын тоо	8	12	12
9.	Орон нутгийн нислэгийн зорчигчийн тоо (уул уурхайн захиалгат нислэгийн зорчигчийн тоо хамаарахгүй)	106149	137761	169373
10.	Дунд оврын агаарын хөлгийн тоо	7	8	10
11.	Агаарын хөлгийн суудал ашиглалтын хувь	50	60	75

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 6.1.1. улсын болон орон нутгийн төсөв;
- 6.1.2. иргэний нисэхийн ерөнхий газрын төсөв;
- 6.1.3. гадаад, дотоодын зээл, тусламж, төслийн санхүүжилт;
- 6.1.4. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ

7.1. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

7.2. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

7.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат бүрийн эцэст үр дүнгийн үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах болон шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

---o0o---

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассемблейн 2010 оны 64/255 дугаар тогтоолоор 2011-2020 оныг “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын жилүүд” болгон зарлаж, зам, тээврийн ослыг эрс багасгаж, нас баралтыг 50 хувь бууруулах зорилтыг дэвшүүлсэн, Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагаас “2030 он хүртэл хэрэгжүүлэх Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бүс нутгийн стратеги”-ийг 2016 онд баталсан бөгөөд эдгээр тогтоол, стратегийг Монгол Улс дэмжиж гарын үсэг зурсан.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2018 онд гаргасан мэдээгээр дэлхий дахинд зам, тээврийн ослын улмаас жилд 1.2 сая хүн амь насаа алдаж, 50 гаруй сая хүн гэмтэн хөгжлийн бэрхшээлтэй болж байгаагийн дотор 15-29 насны хүүхэд, залуучуудын нас баралтын үндсэн шалтгаан нь зам тээврийн осол болж байна.

Манай улсын тээврийн хэрэгслийн тоо жил бүр өсч, 2018 оны байдлаар 970880 тээврийн хэрэгсэл бүртгэгдэж, зам, тээврийн ослын улмаас 20345 хүн гэмтэн эмнэлгийн тусламж, үйлчилгээ авч, 504 хүн амь насаа алдаж, 19.2 тэрбум төгрөгийн эд материалын шууд, 35.0 тэрбум төгрөгийн шууд бус хохирол учирчээ.

Монгол Улсын хэмжээнд зам, тээврийн ослын улмаас нас барагсдын 78, хүнд гэмтэгсдийн 72 хувь нь орон нутгийн замд гарсан бөгөөд 2012 онд 100.0 мянган хүнд ногдох зам, тээврийн ослоос үүдэлтэй нас баралт 21 байсан бол 2018 онд 16.9 болж буурсан хэдий ч Европын орнуудтай харьцуулахад ихээхэн өндөр байна.

“Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги”-ийн хэрэгжилтийг 2018 онд хүрсэн түвшнээр нь авч үзэхэд 54 хувьтай гарсан нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлогын зорилтот түвшинд хүрээгүйг харуулж байгаа бөгөөд цаашид бодлого, үйл ажиллагааг оновчтой тодорхойлж, төлөвлөх шаардлага үүсч байна.

НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс, Төв Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагын судалгаанаас үзэхэд эдийн засаг-нийгмийн үзүүлэлт нь зам, тээврийн ослын тоо, үр дагавартай шууд хамааралтай байна. Иймд иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болгох, нийтийн тээврийн зохион байгуулалтыг сайжруулах, явганаар болон унадаг дугуйгаар ая тухтай орчинд тайван зорчих нөхцөлийг бүрдүүлэх нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын суурь нөхцөл болно.

Хөтөлбөрийг боловсруулахдаа Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлийн 1-д заасан “Амьд явах эрхтэй; 2/ эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасныг, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, уг хуульд нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн хэм хэмжээг үндэслэл болгов.

Хөтөлбөр нь “Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилт”, “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”, “Автотээврийн талаар төрөөс баримтлах бодлого”, “Осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр”, “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдсан болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

2.1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах “Аюулгүй дэд бүтэц”, “Аюулгүй тээврийн хэрэгсэл”, “Аюулгүй хурд”, “Аюулгүй оролцогч” гэсэн хүчин зүйлүүдэд тулгуурлан “Хүн-Тээврийн хэрэгсэл-Зам, орчин-Ослын дараахь тусламж” гэсэн харилцан уялдаа бүхий цогц системийг бүрдүүлж, замын хөдөлгөөнд оролцогчдын аюулгүй байдлыг хангаж, ослоос учирч болзошгүй хохирлыг бууруулахад хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараахь зорилтыг хэрэгжүүлнэ:

2.2.1. зам, тээврийн ослын тоог 50 хувь бууруулах;

2.2.2. зам, тээврийн ослоос үүдэлтэй нийгмийн эрсдэлийг 50 хувь бууруулах;

2.2.3. эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр, ложистикийн сүлжээг 30 хувь өргөжүүлэн хөгжүүлэх;

2.2.4. Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбай, хот хоорондын замын 50 хувийг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулах.

2.3. Хөтөлбөрийг 2019-2023 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Зам, тээврийн ослын тоог 50 хувь бууруулах зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1. замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах олон улсын жишигт нийцсэн эрх зүйн болон эдийн засгийн хосолсон зохицуулалтыг бүрдүүлэх;

3.1.2. замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой чиг үүрэг бүхий байгууллагуудын уялдаа холбоог хангах, чадавхыг бэхжүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг цогц байдлаар шинжлэн судлах бие даасан, хараат бус тогтолцоог бүрдүүлэх;

3.1.3. замын хөдөлгөөн зохион байгуулалтын болон аюулгүй байдлын мэргэжилтэн, тээврийн эдийн засагч нарыг гадаад, дотоодын их, дээд сургуульд бэлтгэх замаар хүний нөөцийг бүрдүүлэх;

3.1.4. судалгаа, шинжилгээ, төлөвлөлтөд суурилсан замын хөдөлгөөн зохион байгуулалтын оновчтой зохицуулалтыг нэвтрүүлж, замын хөдөлгөөний удирдлага зохицуулалтыг боловсронгуй болгох.

3.2. Зам, тээврийн ослоос үүдэлтэй нийгмийн эрсдэлийг 50 хувь бууруулах зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1. явганаар болон унадаг дугуйгаар зорчих, хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настан, бага насны хүүхдийг замын хөдөлгөөнд аюулгүй оролцох нөхцөлийг бүрдүүлэх;

3.2.2. олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлэх замаар жолоочийн сахилга, хариуцлагаас шалтгаалсан зам, тээврийн ослыг бууруулах;

3.2.3. сургалтын хөтөлбөр, орчныг сайжруулж, орчин үеийн технологи ашиглан тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх, мэргэшүүлэх тогтолцоог боловсронгуй болгох;

3.2.4. бүх шатны боловсрол, сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөрт замын хөдөлгөөнд оролцогчдын мэдлэг, дадал, хандлагыг дээшлүүлэх сургалтыг тусгах замаар замын хөдөлгөөнд оролцогчдын хандлага, соёл, дадал, хариуцлагыг дээшлүүлэх;

3.2.5. соён гэгээрүүлэх нийтийг хамруулсан ажлыг үе шаттай зохион байгуулж замын хөдөлгөөнд оролцогчдын хандлага, соёл, дадал, хариуцлагыг дээшлүүлэх;

3.2.6. зам, тээврийн ослын үед ашиглах техник хэрэгслийн хангалтыг сайжруулах, орчин үеийн шаардлагад нийцүүлэх, осол саатлын үед үзүүлэх тусламж, үйлчилгээг шуурхай зохион байгуулах тогтолцоог бүрдүүлэх.

3.3. Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр, ложистикийн сүлжээг 30 хувь өргөжүүлэн хөгжүүлэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.3.1. автотээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, ашиглалт, техникийн үйлчилгээ, техникийн хяналт, устгал, дахин боловсруулахтай холбоотой олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэн орох, үндэсний стандарт, техникийн зохицуулалтыг боловсруулж мөрдүүлэх замаар тээврийн хэрэгслийн техникийн болон экологийн аюулгүй байдалд тавих шаардлагыг нэмэгдүүлэх;

3.3.2. үйлдвэрлэгчээс баталгаат автотээврийн хэрэгсэл, сэлбэгийг хэрэглэгчид шууд хүргэх хяналтын тогтолцоог бүрдүүлэх, тухайн оронд болон Монгол Улсад ашиглахыг хориглосон, ашиглалтын хугацаа дууссан, баруун гар талдаа жолооны хүрдтэй, 6-гаас дээш жилийн насжилттай тээврийн хэрэгслийн импортыг хязгаарлах замаар авто тээврийн хэрэгслээс үүдэлтэй осол, байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах;

3.3.3. тээврийн хэрэгслийн хийц, технологийн онцлогт тохирсон, техник, технологийн дэвшилд суурилсан, тээврийн хэрэгслийн тооны зохистой харьцаанд нийцүүлэн “Үйлчилгээ-Оношлогоо-Хяналт”-ын нэгдсэн системийг бүрдүүлэх;

3.3.4. тээврийн ухаалаг системд суурилсан авто замын хөдөлгөөний удирдлага, хяналт, зохицуулалт, осол, зөрчлийг бүртгэх мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэх;

3.3.5. автотээврийн салбарт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах даатгалын цогц систем бий болгох замаар төр, иргэнд учрах санхүүгийн дарамтыг бууруулах;

3.3.6. нийтийн тээврийн үйлчилгээнд суурилсан хот төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлэх;

3.3.7. хот, суурин газрын төлөвлөлт, газар олголтод замын хөдөлгөөн зохион байгуулалт, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах шалгуур үзүүлэлтийг нэн тэргүүнд тавих зохицуулалтыг бий болгох;

3.3.8. авто зам, замын байгууламжийг төлөвлөх, зураг, төсөл зохиох, барих, ашиглах, ашиглалтын дараахь үе шатанд авто замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийх тогтолцоог бүрдүүлэх;

3.3.9. тусгай зориулалтын авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг бүрдүүлэх.

3.4. Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбай, хот хоорондын замын 50 хувийг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулах зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.4.1. тээврийн ухаалаг системд суурилсан авто замын удирдлага, хяналт, зохицуулалтын систем нэвтрүүлэх;

3.4.2. улсын болон орон нутгийн чанартай авто замын дагуу тээврийн хэрэгслийн зөрчлийг хянах дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх;

3.4.3. тээврийн хэрэгслээс хөдөлгөөнийг хянах тогтолцоог бий болгох;

3.4.4. гудамж, замын хөдөлгөөний сүлжээг төлөвлөх, шинэчлэхдээ "Аюултай нь бага, аюулгүй нь их" гэсэн олон улсын зарчмыг баримталж явган зорчигч замын хөдөлгөөнд оролцох таатай нөхцөл бүрдүүлэх.

Дөрөв. Хөтөлбөрийн үр дүн

4.1. Зам, тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүний тоо, эрүүл мэнд, эд хөрөнгийн хохирлын хэмжээ мэдэгдэхүйц хэмжээгээр буурна.

4.2. Улсын хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах байгууллагуудын чадавх дээшилж, зам, тээврийн ослын тоо буурч, түүнээс урьдчилан сэргийлэх, тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр салбар хоорондын хамтын ажиллагаа сайжирна.

4.3. Зам, тээврийн осол, гэмтлээс сэргийлэх орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.

4.4. Ослын үед үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулснаар осол, гэмтлээс шалтгаалсан нас баралт, хөгжлийн бэрхшээлтэй болох, хөдөлмөрийн чадвараа алдах тохиолдол буурна.

Тав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

5.1. Хөтөлбөрийн үр дүнг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	
		(2018 он)	2024 он	
1.	Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам, тээврийн ослын тоо	29474	15000	
2.	Зам, тээврийн ослын улмаас учирсан материаллаг хохирлын хэмжээ (төгрөг)	19.2 тэрбум	10.0 тэрбум	
3.	Зам, тээврийн ослын улмаас нас барсан тохиолдол (10.000 хүн тутамд)	1.7	0.85	
4.	Зам, тээврийн ослын улмаас гэмтсэн хүний тоо (10.000 хүн тутамд)	56.4	28	
5.	Зүүн гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл (нийт тээврийн хэрэгсэлд эзлэх хувь)	46.7	65.0	
6.	6 хүртэл жил ашигласан автомашины тоо (нийт автомашинд эзлэх хувь)	17	30	
7.	Техник, технологийн дэвшлийг ашиглан хяналт тавих цэгийн тоо	Улаанбаатар хотод	8	320
		Орон нутгийн замд	50	500

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- 6.1.1. улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;
- 6.1.2. гадаадын болон дотоодын зээл, тусламж, төслийн санхүүжилт;
- 6.1.3. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив;
- 6.1.4. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ

7.1. Төрийн захиргааны төв байгууллага, холбогдох агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд өөрийн хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

7.2. Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Засгийн газар болон Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлд танилцуулна.

---oOo---

ТЭЭВРИЙН УХААЛАГ СИСТЕМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Автотээврийн салбар анх 1925 онд үүсч хөгжин 1990 он гэхэд хот хоорондын ачаа тээвэрлэлтийн зориулалттай, 300-1000 автомашин бүхий 15 томоохон авто аж ахуй ажиллаж байсны дээр аймаг, орон нутагт, ачаа зорчигчид шуудан тээвэрлэх зориулалттай 20 гаруй авто аж ахуй ажиллаж, улсын нийт ачаа тээвэрлэлтийн 70 гаруй хувь, зорчигч тээвэрлэлтийн 98.5 хувийг гүйцэтгэж байсан бол 2019 оны байдлаар автотээврээр 168.4 сая зорчигч, 40.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь нийт зорчигч тээврийн 97 хувь, ачаа тээврийн 59.2 хувийг эзэлж байна.

Улсын хэмжээнд 2019 оны байдлаар 1.4 сая тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагийн 54.5 хувь нь Улаанбаатар хотод бүртгэлтэй байна.

Тээврийн хэрэгслийн тоо жил бүр хурдацтайгаар өсч байгаа нь авто замын нэвтрүүлэх чадварыг бууруулах, түгжрэл үүсэх, осол, хэргийн тоо нэмэгдэх, хүний амь нас, эрүүл мэнд, эдийн засаг, байгаль орчинд хохирол учруулах зэргээр сөрөг үр дагавруудыг бий болгож байна. Зам, тээврийн ослын улмаас 2019 онд нийт 561 хүн амь насаа алдаж, 3790 хүн гэмтсэн байна.

Импортоор 2019 онд 158224 тээврийн хэрэгсэл орж ирснээс 43.9 хувийг суудлын автомашин, 14.6 хувийг ачааны автомашин эзэлж байна. Импортын суудлын автомашины 86.6 хувь, ачааны автомашины 20 хувь нь баруун талдаа жолооны хүрдтэй байна.

Импортоор орж ирсэн эвдрэлтэй суудлын автомашины тоо 2018 онд 3688, 2019 онд 4172 болж өссөн байна.

Нийт автомашинд 0-3 жилийн насжилттай автомашины эзлэх хувийн жин 2012 онд 10 хувь байсан бол 2019 онд 3.2 хувь болж буурчээ. Эдгээр тоон үзүүлэлтээс харахад хямд үнэ бүхий эвдрэлтэй, хуучин автомашин импортоор оруулж ирэх хандлага нэмэгдэж байна.

Улаанбаатар хотод 2010 онд гэрлэн дохионы хяналт, тээврийн хэрэгслийн дугаар таних камер, мэдээллийн самбар, хяналтын камерын систем бүхий замын хөдөлгөөний удирдлагын төвийг байгуулснаар анхны тээврийн ухаалаг системийн суурийг тавьж, 2015 онд нийслэлийн нийтийн тээврийн автобусны ухаалаг карт, удирдлага болон мэдээллийн системийг хувийн хэвшлийн оролцоотойгоор нэвтрүүлсэн ч эдгээр системүүд нь өөр хоорондоо уялдаа холбоогүй, нэгдсэн байдлаар ажиллахгүй байгаагаас шалтгаалан үр дүн муутай, цаашид хөгжүүлэлт хийхэд хүндрэлтэй байна.

Тээврийн ухаалаг системийг байгууллага, аж ахуйн нэгжүүд бие даасан байдлаар, хоорондоо уялдаа холбоогүй, хэрэгжүүлж байгааг нэгдсэн бодлого, төлөвлөлт, стандарт, техник, технологийн хүрээнд хэрэгжүүлэх, автотээврийн салбарт

мэдээллийн технологийн орчин үеийн ололтыг нэвтрүүлэн ухаалгаар зохицуулж, зохион байгуулах шаардлага бий болоод байна.

Иймд “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.118-д “эрэлтэд нийцсэн, хүрээлэн байгаа орчинд ээлтэй тээврийн ухаалаг систем нэвтрүүлэх”, “Төрөөс автотээврийн талаар баримтлах бодлого”, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 5.4-т “Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ” гэж тус тус заасныг үндэслэн “Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулав.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

2.1. Тээврийн салбарт ухаалаг системийг нэвтрүүлж, тээвэрлэлтийг оновчтой, эдийн засгийн хувьд хэмнэлттэй байдлаар зохион байгуулж, иргэдэд аюулгүй, ая тухтай тээвэрлэлтийн үйлчилгээг үзүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

3.1. Хөтөлбөрийн зорилгыг дараахь зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ:

3.1.1. замын хөдөлгөөнийг ухаалгаар удирдах дэвшилтэт системийг нэвтрүүлэх;

3.1.2. замын хөдөлгөөний зөрчил илрүүлэх, мэдээлэх автомат системийг хөгжүүлэх;

3.1.3. цахим төлбөрийн системийг хөгжүүлэх;

3.1.4. тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;

3.1.5. нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. “Замын хөдөлгөөнийг ухаалгаар удирдах дэвшилтэт системийг нэвтрүүлэх” зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.1. замын хөдөлгөөний ачааллыг удирдах системийг хөгжүүлэх;

4.1.2. авто зогсоолын мэдээлэл, удирдлагын системийг хөгжүүлэх;

4.1.3. гэрлэн дохионы хяналтын системийг шинэчлэх.

4.2. “Замын хөдөлгөөний зөрчил илрүүлэх, мэдээлэх автомат системийг хөгжүүлэх” зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.2.1. тээврийн хэрэгслийн хурд хэтрэлтийг анхааруулах системийг хөгжүүлэх;

4.2.2. хурд ба гэрлэн дохионы зөрчлийг зохицуулах системийг хөгжүүлэх;

4.2.3. тээврийн хэрэгслийн даац хэтрэлтийг илрүүлэх автомат системийг хөгжүүлэх;

4.2.4. авто зам дээрх дүрмийн бус зогсолтыг хянах системийг хөгжүүлэх;

4.2.5. аюултай ачаа тээвэрлэж байгаа тээврийн хэрэгсэлд тавих хяналтын системийг хөгжүүлэх.

4.3. "Цахим төлбөрийн системийг хөгжүүлэх" зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.3.1. нийтийн тээврийн төлбөрийн цахим системийг өргөжүүлэх;

4.3.2. авто зам ашигласны төлбөр хураах үйл ажиллагааг цахимжуулах;

4.3.3. авто зогсоолын төлбөр хураах үйл ажиллагааг цахимжуулах.

4.4. "Тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх" зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.4.1. тээврийн ухаалаг системтэй холбоотой техникийн баримт бичиг, стандарт, нормативийг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох;

4.4.2. "Радио давтамжаар таних систем" (RFID)-ийг нэвтрүүлэх;

4.4.3. тээврийн хэрэгслийн бүртгэл, техникийн хяналт, авто үйлчилгээ, татвар, даатгалын үйл ажиллагааг цахимжуулах.

4.5. "Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах" зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.5.1. нийтийн тээврийн мэдээлэл, үйлчилгээний удирдлагын системийг хөгжүүлэх;

4.5.2. унадаг дугуйн хэрэглээг ухаалаг системээр дэмжих;

4.5.3. замын хөдөлгөөн зохион байгуулалтын мэргэжилтэй хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах.

Тав. Хөтөлбөрийн үр дүн

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

5.1.1. замын хөдөлгөөний зохион байгуулалт сайжирч, түгжрэл буурна;

5.1.2. тээвэрлэлтийн аюулгүй байдал хангагдана;

5.1.3. тээвэрлэлттэй холбоотой ажил, үйлчилгээ, төлбөр тооцооны системийг цахимжуулснаар үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна;

5.1.4. иргэд үйлчилгээ авахад зарцуулах цаг хугацаа, зардлыг хэмнэнэ;

5.1.5. тээвэрлэлт үр ашигтай болно;

5.1.6. тээврийн байгууллагын удирдлага, зохион байгуулалт, хяналт сайжирна.

175

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, шалгуур үзүүлэлт

6.1. Хөтөлбөрийг 2020-2024 онд хэрэгжүүлнэ.

6.2. Хөтөлбөрийн үр дүнг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин
		(2019)	(2024)
1.	Тээврийн мэдээллийн нэгдсэн удирдлагын төвийн тоо	0	1
2.	Цахим технологи нэвтрүүлсэн авто замын төлбөр хураах цэгийн тоо	0	35
3.	Автомашины даац хэтрэлтийг хянах цахим технологи нэвтрүүлсэн цэгийн тоо	0	33
4.	Тээврийн хэрэгслийн хурд хэтрэлтийг хянах камерын тоо	11	26
5.	Автомашины утааны хяналтын камерын тоо	0	15
6.	Нийт автомашинд радио долгионы давтамж үүсгэгч (RFID) ялтас бүхий автомашины эзлэх хувь	0	100
7.	Радио долгионы давтамж (RFID) хүлээн авагч төхөөрөмжийн тоо	0	80
8.	Бодит цагийн горимд суурилсан технологи бүхий гэрлэн дохионы эзлэх хувь	0	100
9.	Авто замын гэрлэн дохионы дүрмийн зөрчил илрүүлэгч камерын тоо	29	44

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

7.1.1. улс, орон нутгийн төсөв;

7.1.2. хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт;

7.1.3. гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж;

7.1.4. төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив;

7.1.5. хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.

**Найм. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт,
хяналт-шинжилгээ, үнэлгээ**

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах ажлыг зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

8.2. Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулна.

8.3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

-----oOo-----

177

ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН ЧИГ ҮҮРЭГТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2019.10.10.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах” тухай 55 дугаар тушаалаар Зам, тээврийн салбарын чиг үүргийн шинжилгээ хийх, дахин хуваарилах санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсгийн хуралдаанаар дэд ажлын хэсэг байгуулах шийдвэр гаргасны дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн “Дэд ажлын хэсэг байгуулах тухай” 104 дүгээр тушаалаар Зам, тээврийн салбарын чиг үүргийн шинжилгээ хийх, дахин хуваарилах санал боловсруулах үүрэг бүхий техникийн дэд ажлын хэсгийг 13 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж чиг үүрэг дахин хуваарилах аргачлал, гарын авлага, программын зааврыг мөрдлөг болгон ажиллаа.

Зам, тээврийн салбарын чиг үүргийн шинжилгээ хийх, дахин хуваарилах санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг явцын тайланг 2019 оны 06 дугаар сарын 14-ны өдөр Зөвлөлдөх ажлын хэсэгт танилцуулан ажилласан. 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 04/3548 тоот албан бичгээр Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төсөлд тайлан, дүгнэлтийг хүргүүлэн ажилласан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн ХЭГ/2482 дугаар “Ажлын тайлан, үр дүнг танилцуулах тухай” албан бичгийн дагуу техникийн дэд ажлын хэсэг хуралдаж Зам, тээврийн салбарын чиг үүргийг дахин хуваарилах төрийн байгууллагын үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, эсхүл төрийн бус байгууллага, хувийн хэвшилд шилжүүлэх чиг үүргийг тодорхойлох чиглэлээр холбогдох төрийн бус байгууллага, нийгэмлэг холбоодоос санал авахаар 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 03/4759 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Зам, тээврийн салбарын хэмжээнд Ерөнхий чиг үүргийг 4 ангилсан. Үүнд:


- ✓ Зам, тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх
- ✓ Тээврийн хэрэгсэл, техник ашиглах
- ✓ Тээвэрлэлтийг төлөвлөх, зохион байгуулах, зохицуулах, үйлчилгээ үзүүлэх
- ✓ Зам, тээврийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих

Дээрх ерөнхий чиг үүргийн хүрээнд үндсэн чиг үүрэг **23**, дэд чиг үүрэг **123**-ийг тодорхойлон, чиг үүрэг тус бүрийн шинжилгээ, холбогдох хууль, эрхзүйн зохицуулалт, захиргааны эрхзүйн хэм хэмжээний шинжилгээ, захиргааны эрхзүйн хэм хэмжээг хэрэгжүүлж байгаа төвшинг үнэлж, дэд чиг үүргийн дахин хуваарилалтын саналыг гаргаад байна.

1. ЧИГ ҮҮРГИЙН ШИНЖИЛГЭЭ

1.1. Авто замын салбар:

Авто замын салбар нь 2 ерөнхий чиг үүрэг, 2 үндсэн чиг үүрэг, 33 дэд чиг үүрэгтэй байхаар тодорхойлсон. Авто замын салбарын бүтэц, зохион байгуулалт, төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргүүд Монгол Улсын сонгуулийн үр дүнгээс хамаарч байнга өөрчлөгдөж ирсэн бөгөөд яамны төвшинд бусад салбартай нийлүүлэх, салгах байдлаар өөрчлөгдөж ирсэн. Засгийн газрын агентлагийн төвшинд шинээр байгуулах, татан буулгах байдлаар өөрчлөгдөж ирсэн бол орон нутгийн төвшинд аймгийн Засаг даргын дэргэд хэрэгжүүлэх агентлаг шинээр байгуулах, татан буулгах зэргээр тогтворгүй байдлаар ажиллаж ирлээ.



178

Өнөөдрийн байдлаар 2012 оны сонгуулийн үр дүнгээр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийг татан буулгаж түүний хэрэгжүүлж байсан чиг үүргийг зам, тээврийн хөгжлийн яам үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд Авто замын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор авто замын салбарын судалгаа шинжилгээ, авто замын засвар арчлалтын ажлын зохион байгуулалт, хяналт гэх мэт зарим чиг үүргийг “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ хариуцан гүйцэтгэж байна.

Татан буугдсан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Авто замын газарт 50 гаруй хүн ажиллаж байсан бол одоогийн байдлаар “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ нь үндсэн ажилтан 65 гэрээт ажилтан 170, нийт 235 хүний орон тоотойгоор ажиллаж байна. Мөн Зам, тээврийн хөгжлийн яаманд авто замын асуудлыг хариуцсан 23 хүн ажиллаж байна.

1.2.Авто тээврийн салбар

Авто тээврийн салбар нь 4 ерөнхий чиг үүрэг, 6 үндсэн чиг үүрэг, 42 дэд чиг үүрэгтэй байхаар тодорхойлсон.

Авто тээврийн салбарын бүтэц, зохион байгуулалт, төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргүүд Монгол Улсын сонгуулийн үр дүнгээс хамаарч байнга өөрчлөгдөж ирсэн бөгөөд яамны төвшинд бусад салбартай нийлүүлэх, салгах байдлаар өөрчлөгдөж ирсэн. Засгийн газрын агентлагийн төвшинд шинээр байгуулах, татан буулгах байдлаар өөрчлөгдөж ирсэн бол орон нутгийн төвшинд аймгийн Засаг даргын дэргэд хэрэгжүүлэх агентлаг шинээр байгуулах, татан буулгах зэргээр тогтворгүй байдлаар чиг үүргийг хэрэгжүүлж ирсэн.

Дээр дурдсан чиг үүргийн өөрчлөлттэй холбоотойгоор Төрийн өмчийн үйлдвэрийн газрыг мөн байгуулж ирсэн бөгөөд бүтцийн хувьд улсын төсөвт үйлдвэрийн газар, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар зэргээр байнга өөрчлөгдөж байсан байна.

Өнөөдрийн байдлаар 2012 оны сонгуулийн үр дүнгээр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, аймгийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлагийг татан буулгаж түүний хэрэгжүүлж байсан чиг үүргийг “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ-иар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж байна. Тус үйлдвэрийн газар нь нийт 799 хүний орон тоотойгоор ажиллаж байна.

1.3. Иргэний нисэхийн салбар:

Иргэний нисэхийн салбар нь “Иргэний нисэхийн тухай” хуулийн хүрээнд 4 үндсэн чиг үүрэг, 18 дэд чиг үүргийн хүрээнд үйл ажиллагааг Яам, “Иргэний нисэхийн ерөнхий газар”, “МИАТ” ТӨХК болон мэргэжлийн холбоод үйл ажиллагаа явуулж байна.

Иргэний нисэхийн салбарын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын чиг үүргийг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох яам, иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Иргэний нисэхийн ерөнхий газар тус тус хэрэгжүүлж ирсэн болно. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнгээс хамаарч яамны нэр өөрчлөгдөж ирсэн боловч Иргэний нисэхийн ерөнхий газрын хувьд бүтэц, зохион байгуулалт нь өөрчлөгдөж ирсэн ч чиг үүргийн хувьд сүүлийн 20 гаруй жил өөрчлөлт ороогүй тогтвортой байгаа болно. Иргэний нисэхийн салбарын бодлого, төлөвлөлтийн тухайд бусад салбарын адил Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд буюу 4 жилээр тодорхойлогддог ч салбарын хөрөнгө оруулалтын дутагдалтай байдлаас хамаарч их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай орон нутгийн нисэх буудлуудын хүчин чадлыг сайжруулах ажил төдийлөн ахицгүй байна.



Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолоор “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ыг баталж, иргэний нисэхийн салбарт 8 жилийн хугацаанд баримтлах бодлогыг тодорхойлсон.

Чиг үүргийн шинжилгээнээс үзэхэд иргэний нисэхийн салбарт хувийн хэвшлийн оролцоо маш бага буюу агаарын тээврийн үйлчилгээ, нисэх буудлын үйлчилгээ, агаарын хөлгийн засвар үйлчилгээ гэсэн үндсэндээ 3 чиг үүргийг хувийн хэвшлийн оролцоотой хэрэгжүүлж байна.

Иргэний нисэхийн бусад үйл ажиллагаа, үйлчилгээнд аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хяналт, зохицуулалтыг Засгийн газрын агентлаг Иргэний нисэхийн ерөнхий газар хэрэгжүүлж байгаа болно. Төрийн хяналт, зохицуулалтын чиг үүргээс маш хязгаарлагдмал хэмжээнд буюу мэргэжлийн ажилтныг гэрчилгээжүүлэхэд нислэгийн шалгалт авах, эрүүл мэндийн гэрчилгээ олгох шалгалт авах зэрэг чиг үүргийг цөөн тооны мэргэжлийн хүнээр гүйцэтгүүлж байна. Энэ нь өртөг өндөртэй бэлтгэгддэг, мэргэжлийн өндөр ур чадвар шаарддаг мэргэжилтнийг төрийн байгууллага-агентлаг төсвийн цалингаар ажиллуулах боломжгүй байгаатай холбоотой юм.

Иргэний нисэхийн салбарын чиг үүргийн тухайд орон нутаг бүрт адил хэрэгцээ шаардлага байгаа, дам нөлөөтэй тул зохицуулах шаардлагатай, үйл ажиллагаа нь эдийн засгийн үр ашиг бага, өндөр технологи, нарийн мэргэжил, нийтлэг стандарт шаарддаг бөгөөд шалгуураар хувийн хэвшлийн байгууллага, орон нутгийн оролцоо сонирхол маш сул байна.

Орон нутгийн засаг захиргааны хэрэгжүүлэх чиг үүрэг нь Иргэний нисэхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т заасан “Нислэгийн аюулгүй ажиллагааг хангах шаардлагын үүднээс иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага харьяалах сум, дүүргийн Засаг даргатай хамтарч аэродром орчмын аюулгүйн бүсийг тогтооно” гэсэн заалтаар хязгаарлагдаж байна.

Өнөөдрийн байдлаар иргэний нисэхийн салбарт хувийн хэвшлийн оролцоотой нисэх буудал аэродромын болон агаарын тээвэр, ерөнхий зориулалтын нисэхийн үйлчилгээний чиг үүргийг гүйцэтгэж байна.

Төрийн хяналт, зохицуулалтын чиг үүргийг хэрэгжүүлж буй Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Иргэний нисэхийн ерөнхий газар нь Монгол Улсын агаарын зай, нутаг дэвсгэрт дангаараа агаарын навигацийн үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд олон улс, орон нутгийн нийт 21 нисэх буудлын үйлчилгээг үзүүлж байна. Хувийн хэвшлийн 3 нисэх буудал үйл ажиллагаа явуулж байна. Төрийн өмчийн нэг, хувийн 20 агаарын тээврийн компани агаарын хөлгөөр нислэгийн үйл ажиллагаа явуулж байгаа.

Төвлөрлийг сааруулах, төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор иргэний нисэхийн салбарын чиг үүрэгт шинжилгээ хийсэн. Чиг үүргийн шинжилгээг хийдээ Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан аргачлалыг баримталсан бөгөөд ажлын хэсэгт орсон гишүүд холбогдох чиглэлээр судалгаа хийж, төслийн нэгжийн мэргэжилтнүүдээс зөвлөгөө, сургалт авах, өмнө судалгааг хэрэгжүүлсэн бусад төрийн байгууллагын тайлан мэдээтэй танилцах, ажлын явц, үр дүнг танилцуулж, зөвлөмж авах хэлбэрээр гишүүдийн ажлын туршлагад үндэслэн гүйцэтгэсэн.

Хамрах хүрээний хувьд ажлын хэсэг салбарын шууд хамааралтай 6 хууль, хууль тогтоомж, бодлогын баримт бичиг боловсруулах, төрийн алба, яам, агентлагийн эрхлэх асуудал, төсөв санхүү зэрэг хамааралтай 39 хууль, нийт 45 хууль, 12 олон улсын гэрээ, конвенцид шинжилгээ хийсэн. Ингэхдээ Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй нийт хуульд шүүлт хийж ажилласан.



Зам, тээврийн салбарын хэмжээнд Ерөнхий чиг үүргийг 4 ангилсан.Үүнд:

- ✓ Зам, тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх;
- ✓ Тээврийн хэрэгсэл, техник ашиглах;
- ✓ Тээвэрлэлтийг төлөвлөх, зохион байгуулах, зохицуулах,үйлчилгээ үзүүлэх;
- ✓ Зам, тээврийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих.

Дээрх 4 ерөнхий чиг үүргийн хүрээнд иргэний нисэхийн салбарын 4 үндсэн чиг үүрэг, 18 дэд үүргийг бүхэлд нь аргачлалын 2 дугаар хавсралтын дагуу үнэлж, бодлого боловсруулах, яамдын нийтлэг чиг үүрэгт хамаарахаас бусад хэрэглэгч рүү чиглэсэн засаг захиргааны нэгжийн түвшинд хэрэгжүүлэх боломжтой байж болох болон яам, агентлаг, орон нутгийн түвшинд давхардсан, хийдэл үүсгэсэн гэж үзсэн дэд чиг үүргүүд буюу нийт чиг үүргийн хувьд аргачлалын 4 дүгээр хавсралтын дагуу үнэлгээ хийсэн.

Зам, тээврийн салбарын 4 ерөнхий чиг үүргийн хүрээнд иргэний нисэхийн салбарт үйл ажиллагаа явуулж буй яам, Иргэний нисэхийн ерөнхий газар, орон нутгийн захиргаа, төрийн болон хувийн хэвшлийн агаарын тээврийн байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн хэрэгжүүлж буй 4 үндсэн чиг үүрэг, 18 дэд чиг үүргийг Иргэний нисэхийн тухай хууль, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль, Улсын нисэхийн тухай хуулийн дагуу тодорхойлсон.


Аргачлалын 2 болон 4 дүгээр хавсралтаар хийсэн үнэлгээ, шинжилгээнээс дараах үр дүн, дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

ргэний нисэхийн салбарын 18 дэд чиг үүргээс 6 дэд чиг үүргийг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлж байгаа бөгөөд төрийн бус байгууллага болон хувийн хэвшилд чиг үүрэг шилжүүлэх шаардлагагүй.

1. Иргэний нисэхийн салбарын 18 дэд чиг үүргээс 6 дэд чиг үүргийг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлж байгаа бөгөөд төрийн бус байгууллага болон хувийн хэвшилд чиг үүрэг шилжүүлэх шаардлагагүй.
2. Иргэний нисэхийн тухай хуулийн хүрээнд “Иргэний нисэхийн дэд бүтцийг төлөвлөх, барих, ашиглах, засварлах, бодлого боловсруулах, хууль эрхзүйг боловсронгуй болгох” үндсэн чиг үүрэгт хамаарах 5 дэд чиг үүргээс “агаарын зам, агаарын хаалгыг тогтоох”, “иргэний нисэхийн бодлогыг тодорхойлох, хууль тогтоомжийг боловсронгуй болгох” гэсэн 2 дэд чиг үүргийг яам дангаар, “аэродром, нисэх буудлын үйлчилгээ үзүүлэх”, “Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлэх” “нисэх буудал, аэродромыг төлөвлөх, барих, ашиглах, засварлах” гэсэн 3 дэд чиг үүргийг агентлаг хэрэгжүүлж байна.

Агентлагаас “аэродром, нисэх буудлын үйлчилгээ үзүүлэх”, “нисэх буудал, аэродромыг төлөвлөх, барих, ашиглах, засварлах” гэсэн 2 дэд чиг үүргийг төрийн бусад байгууллага, хувийн хэвшил, орон нутагт, “нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлэх” гэсэн 1 дэд чиг үүргийг төрийн бусад байгууллагад шилжүүлэх нь эрх зүйн хувьд нээлттэй байна. Гэвч хөрөнгө оруулалт их, өндөр технологи, нарийн мэдлэг, мэргэжил шаарддаг чиг үүрэг тул хувийн хэвшил болон орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх сонирхолгүй байдаг болно.Агаарын хөлгийн ашиглалтыг зохицуулах, зохион байгуулах” үндсэн чиг үүрэгт хамаарах “агаарын хөлгийн бүртгэл ашиглалт”, “агаарын хөлгийн засвар, үйлчилгээ” гэсэн 2 дэд чиг үүргийг хэрэгжүүлэхэд хяналт, зохицуулалтын хэмжээнд агентлаг оролцож байгаа бөгөөд агаарын хөлгийн ашиглалт, агаарын хөлгийн засвар үйлчилгээг хувийн хэвшил хэрэгжүүлж байна.

3. Агаарын тээвэрлэлтийг төлөвлөх, зохион байгуулах, үйлчилгээ үзүүлэх” үндсэн чиг үүрэгт хамаарах 4 дэд чиг үүргээс “олон улс, орон нутгийн нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчийг тогтоох”, “олон улс, орон нутгийн нислэгийн чиглэлийг нээх, хаах”, “тээвэрлэлтийн эрх олгох, тарифыг баталгаажуулах” гэсэн 3 дэд чиг үүргийг яам, агентлаг, “агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэх” гэсэн 1 дэд чиг үүргийг төрийн өмчит компани, хувийн хэвшил хэрэгжүүлж байна.



4. "Иргэний нисэхийн дэд бүтцийг төлөвлөх, барих, ашиглах, засварлах, бодлого боловсруулах, хууль эрхзүйг боловсронгуй болгох", "Агаарын хөлгийн ашиглалтыг зохицуулах, зохион байгуулах", "Агаарын тээвэрлэлтийг төлөвлөх, зохион байгуулах, үйлчилгээ үзүүлэх", "Иргэний нисэхийн салбарын нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хяналт, зохицуулалт" үндсэн чиг үүрэг нь яам, агентлагийн түвшинд бодлого боловсруулах, зохион байгуулах эрх хэмжээний хувьд зөв хуваарилагдсан, дахин хуваарилах шаардлагагүй байна.
5. "Иргэний нисэхийн салбарын нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хяналт, зохицуулалт" үндсэн чиг үүрэгт хамаарах 5 дэд чиг үүргийг бодлогын удирдамжаар хангах хэмжээнд яам оролцох бөгөөд Монгол Улс 1989 онд нэгдэн орсон Олон улсын иргэний нисэхийн тухай 1944 оны Чикагогийн конвенцийн дагуу Олон улсын иргэний нисэхийн байгууллагын чиг үүргийг Монгол Улсад хэрэгжүүлэх үүрэг бүхий агентлаг дангаар хэрэгжүүлнэ.
6. Иргэний нисэхийн салбарт Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд агентлагт 2019 онд улсын төсвөөс 3.1 тэрбум төгрөг, 139,5 тэр бум төгрөгийг өөрийн үйл ажиллагааны орлого буюу агентлагийн төсвөөс тус тус санхүүжүүлж, орон нутгийн төсвөөс санхүүжигдэх чиг үүрэг байхгүй байна.
7. Агентлагийн харьяа үйлдвэрлэлийн албадын урсгал зардалд төсөвлөгдсөн 139,5 тэрбум төгрөгийн 107,3 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтад төсөвлөсөн. Улсын төсөвт навигацийн орлого 156,0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 156,1 тэрбум буюу 101,0 хувийн биелэлтэй байна.
8. Нийт санхүүжилтийг 100 хувь буюу 142,6 тэрбум төгрөгийг 3 үндсэн чиг үүрэгт хамаарах 11 дэд чиг үүргийг агентлаг хэрэгжүүлэхэд зарцуулсан. Агентлагт төсвийн болон эдийн засгийн төвлөрөл үүссэн.
9. Төсвийн санхүүжилт шаардагдахгүй "агаарын хөлгийн завсар үйлчилгээ", "агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэх" гэсэн 2 дэд чиг үүргийг төрийн өмчит компани, хувийн хэвшил хэрэгжүүлж байна.
10. Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан иргэний нисэхэд ашиглах агаарын зайг тогтоох, 5 дугаар зүйлийн 5.3-т заасан агаарын зайг нисэхэд ашиглах ерөнхий журмын хэрэгжилтийг хангах зэрэг яамны чиг үүргийг шилжүүлэн хэрэгжүүлэх шаардлагагүй байна. Төсвийн болон чиг үүргийн хувьд тодорхой зохицуулсан гэж үзлээ.
11. Улсын нисэхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан улсын агаарын хөлгийн онцгой болон тусгай үүргийн нислэгийн хөдөлгөөний зохицуулалтыг хамтарсан журмаар хэрэгжүүлэх, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.-т заасан улсын нисэхийн аэродромыг хамтран ашиглах журмыг хамтран тогтоох яамны чиг үүргийг агентлаг болон бусад байгууллагад шилжүүлэх шаардлагагүй, чиг үүргийн хуваарилалтын хувьд зөв хуваарилагдсан гэж үзэж байна.
12. "Агаарын тээвэрлэлтийг төлөвлөх, зохион байгуулах, үйлчилгээ үзүүлэх" үндсэн чиг үүрэгт хамаарах чиг үүргийн тухайд Улсын нисэхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5-д "Улсын агаарын хөлгөөр арилжааны нислэг үйлдэх бол Иргэний нисэхийн тухай хуулийг баримтална" гэсэн заалт нь Олон улсын иргэний нисэхийн тухай 1944 оны Чикагогийн конвенцын 3 дугаар зүйлд заасан "улсын агаарын хөлөг" гэж цэрэг, цагдаа, гаалийн агаарын хөлөг тодорхойлолтын дагуу ойлгогдох бөгөөд Иргэний нисэхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан "иргэн, аж ахуйн нэгж" агаарын хөлгөөр нислэгийн үйл ажиллагаа эрхлэхэд Иргэний нисэхийн ерөнхий газраас "тусгай зөвшөөрөл" олгох зохицуулалттай зөрчилдөж байгаа, мөн олон улсын гэрээ, Конвенцын хүрээнд зөвшөөрөгдөхгүй зохицуулалт тул "улсын агаарын хөлгөөр арилжааны нислэг үйлдэх " гэсэн зохицуулалтыг хууль эрх зүйн хүрээнд хэрэгжүүлэх боломжгүй байна.

Чиг үүргийг дахин хуваарилах аргачлалын 7 дугаар хавсралтаар мэдээлэл боловсруулахад иргэний нисэхийн хууль тогтоомж, бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах үндсэн чиг үүрэгт зориулагдсан улсын төсвийн хуваарилалтад өөрчлөлт орхоогүй байна.



182

Иргэний нисэхийн салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, удирдлага зохион байгуулалтын чиг үүргийг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох яам, иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын чиг үүргийг Иргэний нисэхийн ерөнхий газар буюу агентлаг тус тус хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнгээс хамаарч Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнөөр яамны нэр өөрчлөгдөж ирсэн боловч Иргэний нисэхийн ерөнхий газрын хувьд бүтэц, зохион байгуулалт нь өөрчлөгдөж ирсэн ч чиг үүргийн хувьд сүүлийн 20 гаруй жил өөрчлөлт ороогүй, тогтвортой байгаа болно. Иргэний нисэхийн салбарын бодлого, төлөвлөлтийн тухайд бусад салбарын адил Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд буюу 4 жилээр тодорхойлогддог ч салбарын хөрөнгө оруулалтын дутагдалтай байдлаас хамаарч их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай орон нутгийн нисэх буудлуудын хүчин чадлыг сайжруулах ажил төдийлөн ахицгүй байна.

Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолоор “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ыг баталж, иргэний нисэхийн салбарт 8 жилийн хугацаанд баримтлах бодлогыг тодорхойлсон.

Иргэний нисэхийн салбарын чиг үүргийн шинжилгээнээс үзэхэд хувийн хэвшлийн оролцоо маш бага буюу агаарын тээврийн үйлчилгээ, нисэх буудлын үйлчилгээ, агаарын хөлгийн засвар үйлчилгээ гэсэн үндсэндээ 3 чиг үүргийг хувийн хэвшлийн оролцоотой хэрэгжүүлж байна.


Иргэний нисэхийн бусад үйл ажиллагаа, үйлчилгээнд аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хяналт, зохицуулалтыг Засгийн газрын агентлаг Иргэний нисэхийн ерөнхий газар хэрэгжүүлж байгаа болно. Төрийн хяналт, зохицуулалтын чиг үүргээс маш хязгаарлагдмал хэмжээнд буюу мэргэжлийн ажилтныг гэрчилгээжүүлэхэд нислэгийн шалгалт авах, эрүүл мэндийн гэрчилгээ олгох шалгалт авах зэрэг чиг үүргийг цөөн тооны мэргэжлийн ажилтан гэрээний үндсэн дээр гүйцэтгэж байна. Энэ нь өртөг өндөртэй бэлтгэгддэг, мэргэжлийн өндөр ур чадвар шаарддаг мэргэжилтнийг төрийн байгууллага-агентлаг төсвийн цалингаар ажиллуулах боломжгүй байгаатай холбоотой юм.

Иргэний нисэхийн салбарын чиг үүргийн тухайд орон нутаг бүрд адил хэрэгцээ шаардлага байгаа, дам нөлөөтэй тул зохицуулах шаардлагатай, үйл ажиллагаа нь эдийн засгийн үр ашиг бага, өндөр технологи, нарийн мэргэжил, стандарт шаарддаг бөгөөд хувийн хэвшлийн байгууллага, орон нутгийн оролцоо сонирхол маш сул байна.

Орон нутгийн засаг захиргааны чиг үүрэг нь Иргэний нисэхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т заасан “Нислэгийн аюулгүй ажиллагааг хангах шаардлагын үүднээс иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага харьяалах сум, дүүргийн Засаг даргатай хамтарч аэродром орчмын аюулгүйн бүсийг тогтооно” гэсэн заалтаар хязгаарлагдаж байна. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 4-т хот, тосгоны захирагчийн бүрэн эрхэд нисэх буудалд зорчигчдын үйлчилгээг зохион байгуулж байгаад хяналт тавих чиг үүргийг тодорхойлсон.

Өнөөдрийн байдлаар нисэх буудал аэродромын болон агаарын тээвэр, ерөнхий зориулалтын нисэхийн үйлчилгээний чиг үүргийг хувийн хэвшлийн оролцоотой гүйцэтгэж байна.

Төрийн хяналт, зохицуулалтын чиг үүргийг хэрэгжүүлж буй Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Иргэний нисэхийн ерөнхий газар нь Монгол Улсын агаарын зай, нутаг дэвсгэрт дангаараа агаарын навигацийн үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд олон улс, орон нутгийн нийт 21 нисэх буудлын үйлчилгээг үзүүлж байна. Хувийн хэвшлийн 3 нисэх буудал үйл ажиллагаа явуулж байна. Төрийн өмчийн нэг, хувийн 20 агаарын тээврийн компани агаарын хөлгөөр нислэгийн үйл ажиллагаа явуулж байгаа.



1.4. Төмөр замын салбар:

Төмөр замын тээврийн салбар нь 4 ерөнхий чиг үүрэг, 4 үндсэн чиг үүрэг, 25 дэд чиг үүрэгтэй байхаар тодорхойлсон.

2007 он хүртэл Төмөр замын салбарт “УБТЗ” ХНН төмөр замын салбарын бүхий л үйл ажиллагаа буюу төрийн чиг үүргийг, байгууллагын үйл ажиллагаатай хамтран зохион байгуулж байсан. 2007 оны Төмөр замын тээврийн тухай хууль батлагдсанаар Төмөр салбарт Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч агентлаг анх байгуулагдан Төмөр замын тээврийн багц дүрмийг боловсруулан бэхжих шатандаа ажиллаж байсан ч 2012 онд татан буулгасан.

Энэхүү чиг үүргийн өөрчлөлттэй холбоотойгоор “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” Улсын төсөвт үйлдвэрийн газрыг төмөр замын байгууллагуудын галт тэрэгний хөдөлгөөнийг уялдуулан зохицуулахаар байгуулсан ба Агентлагийн чиг үүргийг нийтэд нь Төмөр замын асуудал эрхэлсэн Төрийн захиргаан төв байгууллагад шилжүүлсэн.

Өнөөдрийн байдлаар “ГТХЗНТ” УТҮГ-ыг байгуулж нийт 25 хүний орон тоотойгоор ажиллаж байн

1.5. Усан зам, далайн тээврийн салбар:


Салбарын гол хууль - Усан замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 оны 5 дугаар сард УИХ-аас баталж, мөн оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон.

Тус хуулиар усан замын тээврийн салбарт хэрэгжүүлэх чиг үүргийг төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүрэг нутгийн захиргааны байгууллагын хооронд ямар нэгэн давхардал, хийдэлгүй байхаар тодорхойлсон. Тухайлбал, усан замын тээврийн захиргааны хяналтыг МХЕГ, түүний орон нутаг дахь салбарууд, усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналт, усан замын тээврийн үйлчилгээний хяналтыг тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний харъя мэргэжлийн байгууллагын улсын байцаагчид, аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагын асуудал хариуцсан албан тушаалтан, байгаль орчны хяналтын байцаагч, байгаль хамгаалагч нар хэрэгжүүлэхээр заасан.

Иймд тус салбарт хэрэгжүүлэх аж ахуйн ажлыг Далайн захиргаа /Далайн хэрэг эрхлэх газар/-ны нэг нэгжид хариуцуулах нь зүйтэй.

Далай ашиглах салбар:

Салбарын гол хууль - Далай ашиглах тухай хуулийг УИХ-аас 1999 онд баталсан. Уг хуульд 2007 онд нэмэлт, өөрчлөлт оруулж Монгол Улсын далайн захиргааг байгуулсан. Тус хуулийн 8¹ дугаар зүйлд: “8¹.1.Монгол Улсын далайн захиргаа байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн шийдвэрлэнэ” гэж заасан. Хуулийн энэхүү заалтаар Далайн захиргааг байгуулах, өөрчлөх татан буулгах асуудлыг салбарын сайдын эрх мэдэлд өгсөн нь Засгийн газар, сайд солигдох бүр тус байгууллагыг болон Сингапур улс дахь “Монголын хөлөг онгоцны бүртгэл” компанийн орон тоо, бүтцийг өөрсдийн үзэмжээр өөрчлөн байгуулах, ТУЗ-ыг өөрсдийн хүмүүсээр бүрдүүлэх, өөрсдийн мэргэжлийн бус хүмүүсийг ажиллуулах гэх мэтээр үйл ажиллагаанд нь байнга оролцож байгаа нь хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагаанд болон Сингапур талын түншийн харилцаанд сөргөөр нөлөөлж байна. Мөн байгуулагдсан цагаасаа хойш өнөөг хүртэл Далайн захиргааны статус /улсын бүртгэлийн гэрчилгээнд нь төрийн байгууллага, хуулийн этгээд, албан газар гэх мэт өмчийн бүх хэлбэрийг заасан/ тодорхойгүй байгаа.



184

2. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

2.1. Авто замын салбар:

Авто замын салбарын эрх зүйн орчны шинжилгээ хийх зорилгоор нийт 50 гаруй хуулийг судалсан.

Авто замын салбарын үйл ажиллагааг Авто замын тухай хуулиар зохицуулж байгаа бусад нь шууд болон шууд бус хамааралтай хуулиуд байна.

Авто замын тухай хуулиар авто замын салбарын чиг үүргийг УИХ, төрийн захиргааны төв байгууллага, авто замын зөвлөл, авто замын судалгаа, шинжилгээ, хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага, аймаг, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын эрх, үүргийг тодорхойлсон байна.

Аймгийн Засаг дарга нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар өмчийн бүх төрөл, хэлбэрт тулгуурлан харьяалах нутаг дэвсгэрийнхээ орон нутгийн чанартай авто замын бодлого, төлөвлөлт, сүлжээг хөгжүүлэх ажлыг хариуцахаар заасан боловч одоогийн байдлаар орон нутгийн авто замыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө боловсруулж баталсан ганц ч аймаг байхгүй байна. Авто замын салбарт тусгай зөвшөөрөл олгох асуудлын зохион байгуулалт, үйлчилгээ үзүүлэх хэм хэмжээтэй холбоотой ажлууд, авто замын салбарын инженер, төсөвчдөд зэрэг олгох сургалтыг “Монголын авто замчдын холбоо” ТББ-т гэрээгээр шилжүүлэн гүйцэтгүүлж байна.

2.2. Автотээврийн салбар:

Авто тээврийн салбарын эрх зүйн орчны шинжилгээ хийх зорилгоор нийт 80 гаруй хуулийг судалсан.

Авто тээврийн салбарын үйл ажиллагааг авто тээврийн тухай хуулиар зохицуулж байгаа боловч Иргэний хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Авто замын тухай хууль нь зарим харилцааг зохицуулахад шууд хамааралтай, бусад 70 гаруй хууль нь шууд бус хамааралтай хуулиуд байна.

Авто тээврийн тухай хуулиар автотээврийн салбарын чиг үүргийг УИХ, төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүрэг нутгийн захиргааны байгууллагын эрх, үүргийг тодорхойлсноос гадна тээвэрлэлтийн болон техникийн ашиглалтын байдалд тавигдах нөхцөл шаардлагуудыг хуульчлан тогтоосон байна.

Автотээврийн тухай хууль 1999 онд батлагдсан бөгөөд түүнээс хойш нийт 19 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байдаг. Авто тээврийн тухай хуулиар авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт хамаарах нийт 7 чиг үүргийг “Авто тээврийн үндэсний төв” аж ахуйн тооцоот төрийн өмчийн үйлдвэрийн газраар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар өмчийн бүх төрөл, хэлбэрт тулгуурлан харьяалах нутаг дэвсгэрийнхээ хүн амын тээврийн үйлчилгээний хэрэгцээг хангах ажлыг зохион байгуулах, уг үйлчилгээнд дагаж мөрдөх журам, стандартын биелэлтийг хангуулах бүрэн эрхтэй гэж, мөн Авто тээврийн тухай хуулиар нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийг тухайн нутаг дэвсгэртээ зохицуулах, зохион байгуулах гэж тус тус заасан боловч энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэх засаг захиргааны нэгж, байгууллага байхгүй улмаас хуулийн хэрэгжилт хангагдахгүй байна.



185

Нийгмийн хөгжлийн үйл явцтай уялдан шинээр зохицуулах шаардлагатай зарим харилцаанууд бий болсноос гадна зарим чиг үүргийг иргэдэд хамгийн ойр байгаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид шилжүүлэх нь зүйтэй гэсэн санал энэхүү тайлангаар гарч байна.

Хуулийн ерөнхий бүтэц:

Автотээврийн тухай хууль нь 6 бүлэг, 23 зүйлтэй. Хуулийн зорилт нь автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа болон автотээврийн хэрэгсэлд тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох, автотээвэрлэлт болон автотээврийн хэрэгслийг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Нэмэлт, өөрчлөлт орсон байдал:

Автотээврийн тухай хууль Улсын Их Хурлаас 2001-11-08, 2001-11-30, 2002-07-10, 2003-05-15, 2003-11-28, 2005-01-27, 2006-12-22, 2007-08-03, 2008-05-29, 2008-10-09, 2008-12-19, 2009-05-07, 2011-01-20, 2011-10-06, 2012-08-17, 2015-12-04, 2017-02-02, 2017-12-07, 2017-12-21 нийт 19 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Эдгээр нэмэлт өөрчлөлтөөр 46 зүйл заалт нэмсэн, 8 зүйл заалтыг хассан, 11 зүйл заалтыг зүйл, заалтыг өөрчлөн найруулж, 15 зүйл, заалтыг өөрчилсөн, 15 зүйл заалтыг хүчингүй болгосон байна.

Төмөр замын тээврийн тухай хуулийн давхардал, зөрчил, хийдлийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 84 дугаар тушаалаар батлагдсан "Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх аргачлал"-д заасан шалгуурын дагуу шалгаж тогтоолоо.

2.5. Усан зам, далайн тээврийн салбар:


Салбарын гол хууль - Усан замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 оны 5 дугаар сард УИХ-аас баталж, мөн оны 7 дугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон. Тус хуулиар усан замын тээврийн салбарын чиг үүргийг төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүрэг нутгийн захиргааны байгууллагын бүх төвшинд давхардалгүйгээр тодорхойлсон.

Монгол Улсын нэгдэн орж хуульчилсан далайн эрх зүйн олон улсын гэрээ, конвенцод Далайн захиргаа /Далайн хэрэг эрхлэх газар/ гэж ямар байгууллага байхыг тодорхой зааж өгсөн. Иймд далайн салбарын асуудлаар Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын өмнө хариуцлага хүлээх байгууллага болох Далайн захиргаа /Далайн хэрэг эрхлэх газар/-ны эрх зүйн байдал буюу статусыг тодорхойлох шаардлага үүсч байгаа.

3. САЛБАРЫН САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ

3.1. Авто замын салбар:

Авто замын салбарын удирдлагын санхүүжилт нь Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын багцын зам, тээврийн удирдлагын санхүүжилт хэсгийн 3,2 тэрбум төсвийн хэсэгт хамаарагдахаас гадна бие даасан төсвийн санхүүжилт авдаг ТАЦ-ын орлогын эх үүсвэр болон аймгуудын замын сангуудаас бүрдэж байна. Төсвөөс санхүүжилт авч байгаа төлбөр авах цэг нь /улсын чанартай авто зам/ 155 хүний орон тоотой жилийн 2,1 тэрбум төгрөгийн урсгал зардал, 7 тэрбум төгрөгийн орлоготой үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн өөрийн орлогоор санхүүжиж байгаа Зам, тээврийн хөгжлийн төв нь 90 хүний орон тоо, 2,2 тэрбум төгрөгийн урсгал зардалтай 2,7 тэрбум төгрөгийн орлогын эх үүсвэртэй байна. 2018 оны Улсын төсвийн гүйцэтгэлээр замын салбарт гадаад болон дотоодын эх үүсвэрээр нийт 364,4 тэрбум төгрөгийн ажил гүйцэтгэсэн байна. Мөн нийслэл орон нутгийн төсвөөс 7,2 тэрбум төгрөгийн 128 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна.



№	Зардлын зүйлс	2018 он /мян. Төг/
А	УЛСЫН ТӨСӨВ НИЙТ, ҮҮНЭЭС	364,407,753.0
1	Урсгал зардал	3,542,202.1
1.1	цалин хөлс	2,179,670.4
1.2	НДШ	256,837.9
1.3	бараа үйлчилгээний бусад зардал	720,612.0
1.4	татаас, шилжүүлэг	163,884.0
1.5	бусад	221,197.8
2	Хөрөнгийн зардал	360,865,550.9
Б	АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВ НИЙТ, ҮҮНЭЭС	7,123,808.9
1	Урсгал зардал	381,589.9
1.1	цалин хөлс	161,632.2
1.2	НДШ	15,423.0
1.3	бараа үйлчилгээний бусад зардал	116,578.2
1.4	татаас, шилжүүлэг	50,698.3
1.5	бусад	37,258.2
2	Хөрөнгийн зардал	6,742,219.0
В	СУМ, ДҮҮРГИЙН ТӨСӨВ НИЙТ, ҮҮНЭЭС	700,728.8
1	Урсгал зардал	55,228.8
1.1	цалин хөлс	13,118.2
1.2	НДШ	1,705.4
1.3	бараа үйлчилгээний бусад зардал	19,341.1
1.4	татаас, шилжүүлэг	21,064.1
1.5	бусад	-
2	Хөрөнгийн зардал	645,500.0
	НИЙТ ДҮН (А+Б+В)	372,232,290.7

3.2. Авто тээврийн салбар:

Автотээврийн салбарын удирдлагын санхүүжилт нь Зам, тээврийн хөгжлийн сайд /ГЕЗ/-ын багцын зам, тээврийн удирдлагын санхүүжилт хэсгийн 3,2 тэрбум төсвийн хэсэгт хамаарагдаж байгаа билээ. Чиг үүргийн зарим хэсгийн хэрэгжүүлж байгаа "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-нь 2018 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр нийт 22 салбар нэгжтэй, удирдах 42, гүйцэтгэх 752, нийт 799 хүний орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

Мөн нийт гүйцэтгэлээр урсгал зардалд 19,1 тэр бум, хөрөнгө оруулалтад 657,7 сая, төгрөгийн зардал буюу нийт 19,7 тэр бум төгрөгийн зардал гаргаж 21 нэр төрлийн орлогын эх үүсвэрээс 25,6 тэрбум төгрөгийн орлого олжээ.

Хүснэгт 2
2018 оны зардлын гүйцэтгэл /мян.төг/

№	Зардлын зүйлс	АТҮТ
А	УЛСЫН ТӨСӨВ НИЙТ, ҮҮНЭЭС	19,798,957.4
1	Урсгал зардал	19,131,239.0
1.1	цалин хөлс	10,001,311.9
1.2	НДШ	1,329,678.7
1.3	бараа үйлчилгээний бусад зардал	4643924.32
1.4	татаас, шилжүүлэг	2,186,099.5
1.5	бусад	970,224.66
2	Хөрөнгийн зардал	667,718.4



187

2.1	Барилга байгууламж	667,718.4
2.2	Их засвар	
2.3	Тоног төхөөрөмж	
	Ажилчдын тоо	799.0
	Нийт орлого	25,603,254.8
	Төсөвт төлсөн	

3.3. Иргэний нисэхийн салбар:

Иргэний нисэхийн ерөнхий газар нь Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын багцад 3,1 тэрбум төгрөгийн урсгал зардалтай 106 хүний орон тоотой агентлаг нь улсын төсвөөс санхүүжиж байна. Мөн навигацын болон бусад орлогоос санхүүжиж байгаа 2431 хүний орон тоотой үйлдвэрлэлийн албад нь 2018 оны жилийн эцсийн байдлаар 300,8 тэрбум төгрөгийн орлого олж улсын төсөвт 167,6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Үүнээс 119,3 тэрбум төгрөгийг өөрийн урсгал санхүүжилтэд, 15,4 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтад ашигласан байна.

Хүснэгт 3
ИНЕГ-ын 2018 оны төсвийн гүйцэтгэл/мянган төгрөг/

№	Зардлын зүйлс	ИНЕГ /агентлаг/	ИНЕГ /үйлдвэрлэл/	ИНЕГ /нийт/
A	УЛСЫН ТӨСӨВ НИЙТ, ҮҮНЭЭС	7,745,773.2	134,802,450.0	142,548,223.2
1	Урсгал зардал	3,150,228.3	119,388,598.1	122,538,826.4
1.1	цалин хөлс	2,333,752.5	60,557,039.4	62,890,791.9
1.2	НДШ	280,050.3	7,544,467.7	7,824,518.0
1.3	бараа үйлчилгээний бусад зардал	273,485.5	4,254,689.0	4,528,174.5
1.4	татаас, шилжүүлэг	176,315.0	15,101,720.0	15,278,035.0
1.5	бусад	86,625.0	31,930,682.0	32,017,307.0
2	Хөрөнгийн зардал	4,595,544.9	15,413,851.9	20,009,396.8
2.1	Барилга байгууламж	3,588,657.5	14,211,394.3	17,800,051.8
2.2	Их засвар		41,380.0	41,380.0
2.3	Тоног төхөөрөмж	1,006,887.4	1,161,077.6	2,167,965.0
	Ажилчдын тоо	106.0	2,431.0	2,537.0
	Нийт орлого		300,893,058.2	300,893,058.2
	Төсөвт төлсөн		167,672,800.0	167,672,800.0

3.4. Төмөр замын салбар:

Төмөр замын салбарт улсын төсвөөс санхүүжилт авч байгаа Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв нь Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын багцад 699,5 сая төгрөгийн урсгал зардалтай 26 хүний орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна. 2018 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр цалин хөлсний зардалд 334,8 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 22,6 сая төгрөгийн зардал гаргаж төсвийн төлөвлөлтийн хэмжээнд гүйцэтгэл гаргажээ.



№	Зардлын зүйлс	ГТХЗТ /мян. Төг/
A	УЛСЫН ТӨСӨВ НИЙТ, ҮҮНЭЭС	699,515.4
1	Урсгал зардал	699,515.4
1.1	цалин хөлс	334,841.9
1.2	НДШ	39,841.9
1.3	бараа үйлчилгээний бусад зардал	22,636.2
1.4	татаас, шилжүүлэг	2,550.0
1.5	бусад	299,645.4
2	Хөрөнгийн зардал	0.0
2.1	Барилга байгууламж	
2.2	Их засвар	
2.3	Тоног төхөөрөмж	
	Ажилчдын тоо	26.0
	Нийт орлого	
	Төсөвт төлсөн	

3.5 Усан зам, далайн тээврийн салбар

Зам, тээврийн удирдлагын чиг үүрэгт хамаарах төсвөөр /яамны урсгал зардлын төсөв 3,2 тэрбум/ ТЗДТБХЗГазар хэрэгжүүлсэн бөгөөд гүйцэтгэлийн төсвийг Далайн захиргаанаас гаргасан байна.

Далайн захиргаа нь 2018 онд төлөвлөгөөгөөр 1,8 тэрбум төгрөг батлагдсанаас 1,5 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарлаа. Дээрх чиг үүргийг гүйцэтгэхэд нийт удирдах болон гүйцэтгэх ажилтан 27 хүний орон тоотойгоор урсгал зардалд 790,1 сая төгрөг, хөрөнгийн зардалд 539,8 сая төгрөгийн зардал гаргаж, улсын төсөвт 209,0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Санхүүжилтийн эх үүсвэрийг Сингапур улсад бүртгэлтэй "Монголын хөлөг онгоцны бүртгэл" компаний Монголын талд ногдох хувиас гаргажээ. Мөн 2018 оны байдлаар улс, орон нутгийн төсвөөс урсгал болон хөрөнгийн зардалд ямар нэг байдлаар төсөв хөрөнгө төлөвлөөгүй болно.

Далайн захиргааны 2018 оны урсгал болон хөрөнгө оруулалт

Хүснэгт 1

№	Зардлын зүйлс	2018 оны гүйцэтгэл /мян.төг/
A	УЛСЫН ТӨСӨВ НИЙТ, ҮҮНЭЭС	1,504,100.0
1	Урсгал зардал	964,275.5
1.1	цалин хөлс	434,259.8
1.2	НДШ	52,673.1
1.3	бараа үйлчилгээний бусад зардал	240516
1.4	татаас, шилжүүлэг	18,672.7
1.5	бусад	218153.9
2	Хөрөнгийн зардал	539,824.5
2.1	Барилга байгууламж	378,582.7
2.2	Их засвар	
2.3	Тоног төхөөрөмж	161,241.8

12




4. САНАЛ, ДУГНЭЛТ

ЧИГ ҮҮРЭГ ДАХИН ХУВААРИЛАХ САНАЛ:

1. Тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх үйл ажиллагааг аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхэд шилжүүлэх;
2. Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх ажлыг зохион байгуулах аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхэд шилжүүлэх;
3. Авто тээврийн салбарын ажилтнуудыг сургах, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох сургалтыг зохион байгуулах чиг үүргийг сургалтын байгууллага болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр шилжүүлэх;
4. Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгохтой холбоотой баримт бичиг боловсруулах, бүрдүүлэх, дүгнэлт гаргах чиг үүргийг Төрийн захиргааны төв байгууллагаас ГТХЗНТ-д шилжүүлэх;
5. Төмөр замын тээврийн салбарын статистик, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, хөтлөх чиг үүргийг Төрийн захиргааны төв байгууллагаас ГТХЗНТ-д шилжүүлэх;
6. Төмөр замын салбарын ажилтнуудыг сургах, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох сургалтыг зохион байгуулах чиг үүргийг сургалтын байгууллага болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх;
7. “Аэродром, нисэх буудлын үйлчилгээ эрхлэх” чиг үүргийг төрийн өмчит аж ахуйн нэгж, хувийн хэвшил, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжид шилжүүлэх;
8. “Нисэх буудал, аэродромыг төлөвлөх, барих, ашиглах, засварлах” чиг үүргийг төрийн өмчит аж ахуйн нэгж, хувийн хэвшил, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжид шилжүүлэх;
9. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлэх” чиг үүргийг төрийн өмчит аж ахуйн нэгжид шилжүүлэх;
10. Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байгуулан Зам, тээврийн хөгжлийн яамны хэрэгжүүлж байгаа авто замын салбарын бодлогын хэрэгжилттэй холбоотой чиг үүргүүд болон Авто замын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан “Зам, тээврийн хөгжлийн төв” ААТТӨҮГ-ийн чиг үүргийг нэгтгэн хариуцуулж ажиллуулах;
11. Зам, тээврийн хөгжлийн яамнаас Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шилжүүлэх чиг үүрэг:
 - олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламжийн барилга, засвар, арчлалтын ажил, зөвлөх үйлчилгээ, захиалагчийн болон техник, технологийн хяналтыг улсын төсөв, гадаадын зээл, тусламж, бусад эх үүсвэрээр хэрэгжүүлэх;
 - авто замын бүрэн бүтэн байдал, ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах талаар байгууллага, аж ахуйн нэгжид үүрэг, чиглэл өгч, биелэлтийг хангуулах;
12. “Зам, тээврийн хөгжлийн төв” ААТТӨҮГ-аас Авто замын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заагдсан чиг үүргийг Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шилжүүлэх

ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГТ НЭМЭЛТ,ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ САНАЛ:

- Зам, тээврийн салбарын чиг үүргийг дахин хуваарилахтай холбоотойгоор дараах хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулаа.Үүнд:
- Авто тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 6.1.8 “автотээврийн салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох журмыг баталж, мөрдүүлнэ” гэж нэмж тусгах;
- Авто тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9 “автотээврийн салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох сургалтыг



- зохион байгуулах ажлыг гэрээний үндсэн дээр сургалтын байгууллага болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно” гэсэн заалт нэмж тусгах;
- Авто замын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дах заалтыг “олон улс, улс, орон нутгийн чанартай авто замын сүлжээг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг улс, орон нутгийн эдийн засаг, нийгмийн үр ашиг, ач холбогдлыг үндэслэн боловсруулж, Засгийн газраар батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулж хангах” гэж өөрчлөн найруулах;
- Авто замын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалтыг хасаж 11 дүгээр зүйлийн 11.1.17 дахь заалтад нэмж тусган өөрчлөн найруулах;
- Авто замын тухай хуулийн 11 дүгээр зүйл “Авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллагын чиг үүрэг” гэснийг “Төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг” гэж, өөрчлөн найруулах;
- Төмөр замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалтыг “Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох” гэснийг “Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох ба үүнтэй холбоотой баримт бичиг боловсруулах, дүгнэлт гаргах эрх олгох” гэж, өөрчлөн найруулах;
- Төмөр замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.12 дахь заалтад “Төмөр замын тээврийн салбарын статистик, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, хөтлөх чиг үүргийг Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхээс хасаж, хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.7 дах заалтад нэмж тусган 14 дүгээр зүйлийн 14.3.7 дах заалтын дугаарлалтыг 14 дүгээр зүйлийн 14.3.8 дахь заалт болгон өөрчлөн найруулах;
- Төмөр замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.18 дахь заалтад “Төмөр замын тээврийн салбарын ажилтнуудыг сургах, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох журмыг баталж, мөрдүүлнэ” гэж нэмж тусган 10.1.18 дах заалтын дугаарлалтыг 10.1.20 дахь заалт болгон өөрчлөн найруулах;
- Төмөр замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.19 дэх заалтыг “Төмөр замын тээврийн салбарын ажилтнуудыг сургах, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох сургалтыг зохион байгуулах ажлыг гэрээний үндсэн дээр сургалтын байгууллага болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно” гэж нэмж тусгах;
- Иргэний нисэхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-т заасан “нислэгийн хөдөлгөөн удирдах үйлчилгээ” гэснийг “агаарын навигацийн үйлчилгээ” гэж өөрчилж, уг үйлчилгээг төрийн өмчийн аж ахуйн нэгж хэрэгжүүлэхээр тус тус хуулийн төсөл боловсрууллаа.

ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН ЧИГ ҮҮРГИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ДАХИН
ХУВААРИЛАХ САНАЛ БОЛОВСРУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ ТЕХНИКИЙН
ДЭД АЖЛЫН ХЭСЭГ

